СОЁЛЫН ЯАМ

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН**
**СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР**

# БАЙГУУЛЛАГЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

*Төлөвлөгөөг хянасан:* ***Төсвийн Ерөнхийлөн захирагч***

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА ........................................ Б.АЗЖАРГАЛ

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

Тэмдэг ........................................

*(огноо)*

*Төлөвлөгөө тайлагнасан:* ***Төсвийн Шууд захирагч***

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН
ГАЗРЫН ДАРГА ........................................ Х.СОЁЛ-ЭРДЭНЭ

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

Тэмдэг 2023. 12. 05

*(огноо)*

Σ 96,31 % 97,7 %

# ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв /сая төгрөг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин /жилийн эцэс/ | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ** | | | | | | | |
| **Стратегийн зорилго 1. Соёл, урлагийн талаар баримтлах бодлого, хууль тогтоомжийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн иргэдэд тэгш хүртээмжтэй хүргэнэ.** | | | | | | | |
| **Стратегийн зорилт 1.1. Соёлын салбарын бодлого, хөгжлийн хэтийн чиглэлийг судалгаа шинжилгээнд тулгуурлан тодорхойлж, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох.** | | | | | | | |
| 1.1.1 | **Соёлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4 дэх заалт:**<br><br>Соёлын байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх хууль тогтоомжийг шинэчлэхэд санал өгөх, хэрэгжилтийг хангуулна. | Батлагдсан төсвийн хүрээнд | Санал өгөх дүрэм, журам, стандартын тоо | 1 хууль,<br>5 журам,<br>1 стандарт | Хэрэгжүүлсэн дүрэм, журам, стандартын тоо | 1.Төрийн албан хаагчдын цалин хөлсний талаарх нээлттэй хэлэлцүүлэгт оролцож санал өгсөн.<br>2.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцож санал өгсөн.<br>3.Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хэлэлцүүлэгт оролцож, цаасаар болон цахим санал асуулгад хамрагдан саналаа өгсөн.<br>4. Соёлын сайдын 2023 оны А/56 дугаар тушаалаар баталсан "Хяналт шалгалтын баримт бичигт нэгдсэн дугаар олгох заавар, Хяналт шалгалтын баримт бичигт нэгдсэн дугаар олгох бүртгэлийн дэвтрийг загварын дагуу хэвлэж, ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн.<br>5.Соёлын байгууллагын соёлын ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журмын төсөлд санал өгсөн.<br>6."Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний харьяа байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ын төсөлд санал өгсөн.<br>7.Нийгмийн даатгалын тухай багц хуулийн хэлэлцүүлэгт оролцож саналаа өгсөн.<br>8. Соёлын төвийн дүрэмд санал өгөв.<br>9.Кинонд ээлтэй хот болох зорилтын хүрээнд Соёлын Сайд болон Дархан-Уул аймгийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Засаг дарга нарын Санамж бичгийн төсөл, энэ хүрээнд зохин байгуулсан хэлэлцүүлэгт оролцож 3 санал өгсөн.<br>10. Соёлын яам болон ЗГХА СУГ-аас 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр 21 аймгийн Урлаг, уран бүтээлийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй хийсэн цахим хурлаар оюуны өмчийн талаар сургалт авах тухай санал өгч тус сургалтыг 11 дүгээр сард зохион байгуулсан.<br>11.Байгууллагын нэгдсэн портал сайтын хэрэглээ, Гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн систем, GLAM системд санал хүргэсэн.<br>12. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн сургалт, хэлэлцүүлэгт оролцсон.<br>13. Соёлын яам, АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс, Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс зохион байгуулсан Ашиг сонирхлын зөрчил - Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг - Мэдэгдэл, тайлбар - Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах тухай цахим сургалтад хамрагдсан.<br>14. "Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам"-ыг танилцуулах сургалт зохион байгуулсан.<br>16. Харъяа соёлын 7 байгууллагын дарга, нягтлан бодогч, статистик мэдээ хариуцсан албан хаагчдад Соёлын тухай хууль, Статистикийн тухай хууль, Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын тухай сургалтыг зохион байгууллаа.<br>**Хүрсэн түвшин:** Нийт 10 удаагийн хэлэлцүүлэгт оролцож, 4 хуулийн шинэчилсэн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | найруулга, 2 журмын төсөлтэй танилцаж, мөрдөгдөж буй 3 журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хэлэлцүүлэгт 15 санал өгсөн.<br>Соёлын салбарт 2023 онд шинээр батлагдсан 1 журам, 1 заавар, 1 загварыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. | |
| 1.1.2 | **Соёлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалт:**<br><br>Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд соёлын байгууллагуудад хууль сурталчилж, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулна. | Батлагдсан төсвийн хүрээнд | Арга хэмжээний тоо | - | Хуулийн хэрэгжилт хангагдана. | 1. МУЗГ-ын 2023 оны 185 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам"-ыг соёлын 7 байгууллагад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулж ажиллахыг үүрэг болгосон. 2023 оны жилийн эцсийн байдлаар соёлын 7 байгууллагын 79 соёлын ажилтанд 366,684,226 төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.<br><br>2. Харьяа соёлын 7 байгууллагын статистик мэдээ хариуцсан албан тушаалтнуудад Соёлын тухай хууль, Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг сурталчлан таниулж, соёлын салбарын статистик мэдээг нэгтгэх арга зүйгээр хангаж, тодорхой мэдлэг, мэдээлэл олгож ажилласан.<br>3. ЗГХА СУГ-тай хамтран аймгийн СУГ болон Залуучууд театр, Музей, Төв номын сан, Шарын гол, Орхон, Хонгор сумын Соёлын төвийн статистик мэдээ гаргадаг албан хаагчдад статистикийн маягт ашиглах, хөтлөх зааварчилгаа сургалтыг танхимаар зохион байгуулсан.<br>4. Орхон, Хонгор сумын Соёлын төвийн статистик мэдээ гаргадаг албан хаагчдад статистикийн маягт ашиглах, хөтлөх зааварчилгаа сургалтыг газар дээр нь зохион байгуулж, холбогдох хууль тогтоомжийг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сурталчлан мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан.<br>5. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмыг соёлын 7 байгууллагын бичиг хэрэг хариуцсан албан тушаалтанд сурталчилж, мэргэжил арга зүйгээр хангаж тус журмын хэрэгжилтийг хангаг ажиллаж байна.<br>6. "Соёлын сэргэлт-2023" аяныг улсын хэмжээнд зохион байгуулах танхимын хуралд соёлын байгууллагуудын удирдлагууд хамрагдсан.<br>7. Газрын багц хуулийн хэлэлцүүлэг, "Хос бичигтэн төрийн албан хаагч" уриан дор монгол бичгийн мэдлэгээ нэмэгдүүлэх сургалт, ТАЗ-ийн 7:4:10 сургалтад хуваарийн дагуу хамрагдсан.<br>8. Жендэрийн салбар хорооноос зохион байгуулсан "Жендерийн эрх тэгш байдал, түүнд тулгамдсан асуудал" сургалт, МУ-ын үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах сургалт, хэлэлцүүлэгт оролцсон.<br>9. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль 2023 онд шинээр батлагдан хуулийн хэрэгжилтийг СУГ-ийн албан хаагчид болон харьяа 7 байгууллагын албан хаагчдад сурталчлан таниулж, мөрдлөг болгон хэрэгжүүлж байна.<br>10. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам 2023 онд шинэчлэн батлагдсантай холбогдуулан СУГ-ийн албан хаагчдад сурталчлан таниулж, мөрдлөг болгон хэрэгжүүлж байна.<br>**Хүрсэн түвшин:** Соёлын салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай, Музейн тухай, Номын сангийн тухай, Кино урлагийг дэмжих тухай, Оюуны өмчийн тухай Монгол хэлний | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тухай хуулиудыг соёлын харьяа байгууллагуудад сурталчилж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | |
| **Стратегийн зорилт 1.2. Соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.** | | | | | | | |
| 1.2.1 | **Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.3.6 дугаар арга хэмжээ, "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 1.1.4 дүгээр арга хэмжээ, Соёлын яамны стратеги төлөвлөгөөний зорилтын 5 дугаар арга хэмжээ, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайд болон Дархан-Уул аймгийн Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээний дөрөвдүгээр хавсралтын 4.1 дүгээр арга хэмжээ:**<br><br>Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийн хадгалалт хамгаалалтыг гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдэд | Орон нутгийн төсөв | Гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдийн тоо | Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийн хадгалалт хамгаалалтыг<br>1 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн байна. | Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийн хадгалалт хамгаалалтыг гэрээний үндсэн дээр 3 хувь хүн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлнэ. | 1. Сяньбигийн үеийн хаад язгууртны 2, 9, 10, 11 дугаартай бунхант булшны малтлагын ажил 2022-2023 онуудад хийгдэж Хонгор сумын Засаг даргын Тамгын газраас хашаа хийж хамгаалтад авч ойролцоо байдаг малчин айлтай гэрээ хийж хамгаалуулсан байна.<br>2. Хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдал алдагдсан соёлын биет өвийн судалгаагаар хууль бус эрсдэлд өртсөн булш, оршуулгын дурсгал тоногдсон 2, орон нутгийн чанартай замд өртсөн 2, байгалийн хүчин зүйлийн нөлөөлөлд өртөж эх төрх байдал нь алдагдсан 1, хагарч хугарсан 1 ширхэг соёлын үл хөдлөх дурсгалт өв байна.<br>4. Хонгор сумын нутаг дэвсгэр дээр оршдог улсын хамгаалтад байдаг "Хүйтэний голын бичигт хад", аймгийн хамгаалтад байдаг "Ногоон толгойн хиргэсүүр", "Чингисийн морины уяа", Хүйтний хурлын туурь, "Суваргатай хад" бүхий нийт 23 үл хөдлөх дурсгалт газрын хадгалалт хамгаалалтыг сайжруулан тус сумын гурван байгаль хамгаалагчид хариуцуулан харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд харуул хамгаалтад авах ажлыг зохион байгууллаа.<br>5. Хонгор сумын газар зохион байгуулалтын төлөвлөлт, кадастр зурганд түүх соёлын үл хөдлөх дурсгалт 23 газрын координатын тэмдэглэгээг оруулах ажлыг зохион байгууллаа.<br>6. Орхон сумын нутаг дэвсгэрт байрладаг түүх соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл тооллогоор тоологдсон 5 дурсгалт газрыг ойролцоо нутагладаг 2 малчин иргэнд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хариуцуулсан гэрээг дүгнэж, урамшуулна. | | | | | гэрээний үндсэн дээр хариуцуулан хамгаалуулллаа.<br>7. “Найрамдал” төслийн хүрээнд “Metaforce” ХХК-тай хамтран тус аймгаас олдсон Сяньбигийн үеийн хаад язгууртны бунхант булшны олдворууд, “Домогт Шарын гол ХХК-ийн ойн төгөл, Хүйтэний голын Бичигт хад зэрэг нүүдлийн соёл иргэншил, түүх соёлын дурсгалуудыг 3D-гээр үзүүлэх контент бүтээхэд хамтарч ажилласан.<br>**Хүрсэн түвшин:** Орхон сумын түүх дурсгалын үл хөдлөх 5 дурсгалт газрыг 2 малчин иргэнд, гэрээний үндсэн дээр хариуцуулан хамгаалуулсан. Хонгор сумын 23 үл хөдлөх дурсгалт газрыг харьяа нутаг дэвсгэрийн 3 байгаль хамгаалагчид гэрээний үндсэн дээр хариуцуулан хамгаалуулж, сумын Газар зохион байгуулалтын төлөвлөлт, кадастрын зурганд тэмдэглэгээ хийлгэлээ. | |
| 1.2.2 | **Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.13 дахь заалт, “Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-ийн 1.6.1.4 дүгээр арга хэмжээ:**<br><br>Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийн гадаад өнгө төрхийг сэргээн засварлах ажлыг эхлүүлнэ. | Орон нутгийн төсөв | Сэргээн засварласан дурсгалт зүйлсийн тоо | Түүх, соёлын үл хөдлөх 1 дурсгалт зүйлсийг сэргээн засварлуулсан. | Түүх, соёлын үл хөдлөх 3 дурсгалт зүйлсийг сэргээн засварлуулна. | 1.“Хөшөө дурсгалаа хамгаалах” дэлхийн өдрийг тохиолдуулан аймгийн Музейгээс Орхон сумын Соёлын Төвтэй хамтран 2018 онд босгосон Морь барианы газрын морины хөшөөг цэвэрлэн, өнгөлж засаж сайжруулсан.<br>2.Залуучууд театр “Аавын гутал” хөшөөг өнгөлж ойр орчмын ногоон байгууламжыг нэмэгдүүлэн тохижилт үйлчилгээ хийсэн.<br>3.СӨҮТ-өөс ирсэн албан бичгийн дагуу авдар, хул аяга, морин хуур 3 үзмэрийг сэргээн засварлуулахаар хүргэж ажиллав.<br>4. 37 дэсийн 39 ширхэг уран зургийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор СӨҮТ-д сэргээн засварлуулах саналыг албан бичгийн хамт илгээв.<br>5.Музейн үзмэрийн хадгалалт хамгаалалтыг сайжруулан “Практикал” даатгалд ууjтай эхнэр дээл, хүрмэн тэрмэн дээл, эхнэр дээл гэсэн 3 дэсийн 3 ширхэг үзмэрийг даатгуулав.<br>6.Сан хөмрөгт хадгалагдаж байгаа 358 дэсийн 518 гэрэл зургийг цахимд шилжүүлэн цахим | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | архив үүсгэн хадгалах ажлыг 40 хувийн гүйцэтгэлтэй хийж гүйцэтгэсэн байна.<br>7.Музейн Байгаль, Түүх, Угсаатан, Найрамдлын 4 танхимд үзмэрийн ариутгал, халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, үзмэр эд өлгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулав.<br>8. 50 орчим үзмэрийн хадгалалтын нөхцөлийг сайжруулах зорилгоор үзмэр зөөж тээвэрлэхэд аюулгүй ажиллагааг хангаж хадгалалтын 3 ширхэг модон хайрцаг хийлгэсэн.<br>9.Сумын төвд байрлалтай "Буган чулуун хөшөө"-г 2 дугаар сургуулийн Г.Отгонжаргал багштай анги хамт олон цэвэрлэж, хашааг будаж сэргээсэн.<br>10.Аймгийн Музейд хадгалагдаж буй МУСГЗ, нэрт зураач Н.Цүлтэмийн "Уулзалт" уран зургийг судалж түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад нэр дэвшүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:** 2 үл хөдлөх түүх соёлын дурсгалт хөшөө, Музейн 3 үзмэрийн гадаад өнгө төрхийг сэргээн засварласан. Сан хөмрөгт хадгалагдаж байгаа 358 дэсийн 518 гэрэл зургийг цахимд шилжүүлэн цахим архив үүсгэн хадгалах ажлыг хийсэн. | |
| 1.2.3 | **Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.7 дахь заалт, "Монгол Улсын Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.6.3.6 дугээр арга хэмжээ, "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн** | Орон нутгийн төсөв 70.0 сая | Судалгааны баг ажиллаж эхэлсэн байх. | 2 бунхант булшийг малтан судалсан. | 2, 9, 10, 11 дугаартай бунхант булшны малтлагын ажлыг хийсэн байна. | - Сяньбигийн үеийн хаад язгууртны бунхант булшны малтлага судалгааны ажил гүйцэтгэх гэрээ" нэртэй №ОНХС-2023/01-05 дугаар бүхий Дархан-Уул аймгийн Хонгор сумын Говилуй уулын орчимд байх 1800 жилийн өмнөх үе буюу Сяньбигийн үеийн хаад язгууртны булшны малтлага судалгааг ОНХСангийн 70 сая төгрөгийн хөрөнгөөр 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрөөс долдугаар сарын 31-ний өдөр хүртэл МУИС-ийн Улаанбаатар Сургуулийн Түүх, археологийн тэнхимийн доктор Т.Идэрхангай болон тус тэнхимийн 2 дугаар багийн хамт олон хийж гүйцэтгэлээ. 2023 онд 7 болон 9 дугаартай | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **чиглэл"-ийн 1.1.4 дүгээр арга хэмжээ:**<br><br>Түүх, археологийн хайгуул судалгаа малтлагын ажлыг зохион байгуулах, Сяньбигийн үеийн хаад язгууртны бунхант булшны малтлага судалгааг үргэлжлүүлэн хийнэ. | | | | | бунхант булш болон уг 2 бунхантай зэрэгцээ хоёр том хэмжээний бунхант булшийг малтан судлав.<br>**Хүрсэн түвшин:** 2023 онд судалгааны баг Сяньбигийн үеийн хаад язгууртны булшны олдвороос нийт 4 бунхант булшийг малтан судалсан байна. | |
| 1.2.4 | **Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8 дахь заалт, Соёлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.4 дэх заалт:**<br><br>Сумдын орон нутаг судлах танхимд үзмэр дэглэх, мэргэжил арга зүйн чиглэл өгөх, орон нутгийн иргэдэд соёлын өвийг сурталчлах ажлыг хамтарч зохион байгуулна. | Батлагдсан төсвийн хүрээнд | Арга хэмжээний тоо | Соёлын 1 төвд орон нутаг судлах танхимын арга зүйн сургалт зохион байгуулсан. | 2 сумын соёлын төвийн орон нутаг судлах танхимд зөвлөн туслаж үзмэр дэглэсэн байна. | 1.Аймгийн Музейтэй хамтран Орхон сумын Соёлын төвийн Музейн сан хөмрөгийн ажилтанд мэргэжил арга зүйн сургалт 1 удаа явуулж, аймгийн музейн сан хөмрөгт хадгалагдаж буй гэрэл зурагчдын бүтээлээр "Дархан хотын хөшөө дурсгал-Миний дуранд" гэрэл зургийн үзэсгэлэн толилуулж 100 гаруй иргэд хамрагдав.<br>2. Аймгийн Музейтэй хамтран Хонгор сумын Соёлын төвийн Музейн сан хөмрөгийн ажилтанд мэргэжил арга зүйн сургалт 1 удаа явуулж, Монголын гэрэл зургийн холбоотой хамтран "Цаг уурын өөрчлөлт" гэрэл зургийн үзэсгэлэнг 2 өдөр дэлгэж 150 гаруй үзэгчдэд толилуууллаа.<br>3.Шарын гол, Хонгор, Орхон сумдын ТСҮХД-ын 2022 оны тооллогын үр дүнг тайлагнаж, 17 хуудас бүхий гарын авлага хэвлэж, арга зүйн зөвлөгөө өгөв.<br>4. Орхон сумын Соёлын Төвтэй хамтран 2018 онд босгосон морь барианы газрын морины хөшөөний хадгалалт хамгаалалалтад арга зүйн зөвлөгөө өгч, ойр орчмын хогийг цэвэрлэн, анхан шатны хэмжээнд өнгөлж сайжруулав.<br>5."Соёлын бүтээлч сар" аяны хүрээнд аймгийн Музейгээс Дархан, Орхон, Хонгор сумдын Соёлын төвд Дархан хотод зураг авалт нь хийгдсэн киноны 16 ш гэрэл зургийн түр | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үзэсгэлэнг дэглэж 600 гаруй хүнд сонирхуулж, “Шинэ дурсамж” боловсролын хөтөлбөрийг 400 гаруй хүүхдүүдэд зааж сургасан байна.<br>6. Аймгийн Музейгээс Хонгор сумын Соёлын төвд “Пянз” түр үзэсгэлэнг пянз сонирхогч иргэдийн 60 гаруй пянзаар дэглэж, 85 үзэгч үзэж сонирхлоо.<br>7. Соёлын ажилтны өдрөөр аймгийн Музейд Орхон, Хонгор, Шарын гол сумын Соёлын төвийн Музейн сан хөмрөгийн ажилтнуудад танхимын сургалт зохион байгуулж, гарын авлага, ном товхимолоор хангаж ажилласан.<br>**Хүрсэн түвшин:** 2 сумын Соёлын төвийн Музейд 4 удаа түр үзэсгэлэн дэглэж 935 хүн үзэж сонирхож, 400 гаруй хүүхэд боловсролын хөтөлбөрт хамрагдсан байна. 3 сумын Музейн сан хөмрөгийн ажилтнуудыг 5 удаа сургалт, арга зүйгээр хангаж, гарын авлага, ном товхимолоор хангасан. | |
| 1.2.5 | **Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэг, “Монгол Улсын Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.6.3.6 дугаар арга хэмжээ, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайд болон Дархан-Уул аймгийн Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээний дөрөвдүгээр хавсралтын 4.2 дугээр арга хэмжээ:** | Батлагдсан төсвийн хүрээнд | Бүртгэлд хамрагдсан баримтат өвийн тоо | 45 баримтат өвийг судалгаанд хамруулсан. | 20 баримтат өвийг судалгаанд хамруулна. | Хагас жилийн байдлаар иргэдийн гар дээр хадгалагдаж байсан 27 баримтад өвийг бүртгэл судалгаанд хамруулж хадгалалт хамгаалалтын талаар зөвлөгөө өгч ажилласан байна.<br>2023 оны жилийн эцсийн байдлаар:<br>1. Дархан сумын 5 дугаар баг Гэцогдаржайлин хийдэд хадгалагдаж байгаа Богд ламын чуулганы орон-цогшин, Ногоон дара эх, Заяаны таван тэнгэр, Лагшин /бие/ зарлиг /хэл/, таалал /сэтгэл/-ын шүтээн, Харaагийн дарь эхийн түүхэн уран зураг, Нархажид бурхан, Соёмбо үсгийн зээгт наамал, Хутагт хувилгаадын гэрэл зураг, шавар бурхан барласан дардас, зурмал бурхан, судар, монгол зураг танка зураг зээгт наамал нийт 9 дэсийн 9 ширхэг;<br>2. Дархан сумын 4 дүгээр багийн иргэн Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч О.Туулд өвлөгдөж ирсэн Говийн Лха бурхан, зөвшөөрлийн бичиг 2 дэсийн 2 ширхэг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Иргэд, сүм хийдэд хадгалагдаж байгаа баримтат өвийг бүртгэлд хамруулна. | | | | | **3.** Музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа 12 **дэсийн 12 ширхэг баримтад өв бүртгэлд хамрууллаа.**<br>**Хүрсэн түвшин:** Дархан-Уул аймгийн харьяат 4 иргэний гэрт хадгалагдаж буй 29, Гэцогдаржайлин хийдийн 9, Музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа 12, нийт 50 дэсийн **51 ширхэг** соёлын баримтат өвийг бүртгэл **судалгаанд хамруулан** баримтжуулсан. | |
| 1.2.6 | **Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайд болон Дархан-Уул аймгийн Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээний дөрөвдүгээр хавсралтын 4.14 дүгээр арга хэмжээ:**<br><br>“Нүүдэлчин Монгол” олон улсын соёлын фестивальд оролцох оролцоог хангана. | Орон нутгийн төсвөөс 28.0 сая, Соёлын яамны санхүүжилт 22.0 сая төгрөг | Оролцооны байдал хангагдсан эсэх | Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч 39, бусад оролцогч 22 буюу нийт 61 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон. | Оролцоо хангагдсан байна. | ЗГХА СУГ-аас ирүүлсэн 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 01/253 тоот “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд оролцох тухай албан бичиг, удирдамжийг үндэслэн 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдрөөс 21-ний өдрүүдэд Улаанбаатар хотын Налайх дүүргийн “Тайж хайрхан”-ы бэлд Дархан-Уул аймаг нийт 58 хүний бүрэлдэхүүнтэй оролцож шилдэг 5 аймгийн нэгээр шалгарлаа. Үүнд:<br>-Залуучууд театр мэргэжлийн 19 уран бүтээлч, СБӨӨ-ийг өвлөн уламжлагчдын хамтарсан Ардын язгуур урлагийн “Олон үндэстний дуулал” тоглолтыг бэлтгэж найруулагчаар Залуучууд театрын Уран сайхны удирдаач Г.Саранчимэг ажиллав.<br>**I.Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд:**<br>-Д.Гантөгс-Хурдан морины 37 цол дуудлага<br>-Б.Дарханням-Ерөөл, магтаал, уртын дуу<br>**II. Ардын язгуур урлаг**<br>-Б.Дэжидмаа-Баяд бий биелгээ<br>-Б.Таамж-Хотон бий биелгээ<br>-Б.Бааст-Морин хуур, экил хуур, хөгжмийн уламжлалт урлаг<br>**III.Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага**<br>-Б.Түмэннаст-Морьт харваа<br>**V.Уламжлалт арга ухаан**<br>-О.Туул-Бариа засал, Дом, шившлэг, тахилга, бөө мөргөл, уламжлалт эмийн урлал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Г.Мягмар-Угийн бичиг хөтлөх монгол уламжлалт мэдлэг<br>-А.Нямпүрэв-Нохойгоор Ан ав хийх арга ухаан, зан үйл<br>**VII.Уламжлалт гар урлал**<br>-Н.Хишигбаатар-Монгол зургийн урлал, Шуумлын урлал, Монголын уламжлалт модон эдлэл<br>-Д.Энхболд- Монгол эмээл хийх урлал, Монгол Дарханы уламжлалт арга, Баримлын урлал<br>-М.Жаргалсайхан-Эсгий хийх уламжлалт арга, Эсгий ширмэл урлал<br>-Г.Эрдэнэтөгс-Модон сийлбэрийн урлал, Хөөрөг урлал<br>-Ж.Эрхэмсайхан-Монгол бичиг, Монгол уран бичлэг, Таавapp тоглоомын уламжлалт төрлүүд, Тааварт болон үгэн тоглоом, уламжлалт ном бүтээх урлал<br>-Ж.Батцэцэг-Уламжлалт уран хатгамал, оёдлын урлал, Зоос ширээ сүлжих урлал<br>**VIII.Соёлын бүтээлч үйлдвэрлэл**<br>-Б.Очирмаа-Цагаан идээ бэлтгэх уламжлалт арга<br>-Ш.Амгалан-Монголын уламжлалт арьс ширэн эдлэлийн урлал<br>-Г.Бүрэнбат-Шагайгаар тоглох наадах, Уламжлалт гар урлал, модон сийлбэр урлал, Монгол хувцас урлал, Эсгий ширмэл урлал<br>-А.Ундармаа-Эсгий ширмэл урлал-Эсгий оймс, цүнх, аяганы суурь, хүүхдийн бойтог, малгай-5 төрлөөр тус тус оролцлоо.<br>**Хүрсэн түвшин:** Дархан-Уул аймаг нь "Нүүдэлчин Монгол" дэлхийн фестивальд Шилдэг 5 аймгийн нэгээр шалгарч аймгийн отгоор нийт 16,660 хүн үйлчлүүлснээс насанд хүрэгсэд 13167, хүүхэд 393, Хөгжлийн бэрхшээлтэй иргэд 48 үйлчлүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.7 | **Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолоор баталсан "Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам", Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайд болон Дархан-Уул аймгийн Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээний дөрөвдүгээр хавсралтын 4.4 дүгээр арга хэмжээ:**<br><br>Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийж, тайлагнана. | Улсын болон орон нутгийн төсөв | Тоологдсон түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тоо | 2019 онд 969 дэсийн 1362 ширхэг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл тоологдсон. | Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийж, холбогдох газарт тайлагнасан байна. | Хагас жилийн байдлаар Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого угтан СӨҮТ-д RICH программын ашиглалт, сумдын ОНСТ-ийн үзмэрийн тоон мэдээллийг хүргүүлж бэлтгэл ажлыг хангаж ажилласан байна.<br>**Хүрсэн түвшин:** 2023 оны жилийн эцсийн байдлаар улсын тооллогын бэлтгэл ажлын хүрээнд Соёлын Сайдын А/401 тоот тушаалын хавсралт удирдамжийн дагуу аймгийн Музейд шинээр авсан 33 дэс, Хонгор сумын 24 дэс, Орхон сумын 7 дэсийн үзмэр тус бүрд хувийн дугаар өгөн, гэрэл зургийн хамт бүртгэн баримтжуулж RICH программд шивж оруулав. | ~~90%~~<br>70% |
| 1.2.8 | **"Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн 1.1 дэх хэсгийн 4 дүгээр арга хэмжээ, "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 1.1.9 дэх заалт, "Монгол Улсын Засгийн газрын 2021-** | Орон нутгийн төсөв | Арга хэмжээний тоо | Цагдаа, Тагнуулын байгууллагад соёлын биет бус -90, түүх соёлын -53 дэсийн 354, үл хөдлөх 969 дэсийн 1362 бүтээлийг бүртгүүлсэн. | Бүртгүүлсэн түүх, дурсгалт соёлын өвийн тоо нэмэгдсэн байна. | - Эхний хагас жилд аймгийн Музейн сан хөмрөг, үзмэрийн аюулгүй байдалд хяналт тавьж 1,610,000 төгрөгийн өртгөөр үзүүллэгийн танхимуудын 12 камерыг "Дархан Сити электроникс" ХХК-иар шинэчлэн солих ажлыг гүйцэтгүүлсэн.<br>- 2023 оны 09 дүгээр сард Соёлын яамны хөрөнгө оруулалтаар Бодь электроникс ХХК Музейн камер болон дохиолол хамгааллын системийг шинэчлэн СОЯ/202212021 гэрээний дагуу Дархан-Уул аймгийн Музейд 30.393,083 төгрөгийн эд хөрөнгийг хүлээлгэн өгсөн.<br>- "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, "Соёлын өвийг хамгаалах тухай", "Төр | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.6.3.7 дугээр арга хэмжээ:**<br><br>Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана. | | | | | сүм, хийдийн харилцааны тухай" хуулиудын хэрэгжилтийг хангах, СББӨ-ийн хадгалалт хамгаалалт, аюулгүй байдалд хяналт, шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгах, алдагдсан болон дутагдсан Түүх, соёлын дурсгалт зүйлсийг эрэн сурвалжилж, олж тогтоох зорилгоор "Сүм хийд" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай Соёлын яамны Салбарын хяналтын газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 05-ны 15/2644 албан тоотын хэрэгжилтийг хангаан аймгийн Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга болон Соёл, урлагийн газрын даргын хамтарсан төлөвлөгөөг баталж тус газар нь мэргэжлийн удирдлагаар хангаан 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хооронд хяналт тавьж хамтран ажилаллаа.<br>- Түүхийн дурсгалт зүйлсийг устгаж гэмтээх, хууль бус аргаар олж авах худалдаалах зэрэг гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх зорилгоор байнгын харуул хамгаалалт, хяналтын камертай байлгах аюулгүй байдлыг хангах чиглэлээр зөвлөмжийг өгч ажиллав. Үүнээс: "Үржинсаногчойлон" хийдийн хяналтын камерын дүрс бичлэг хадгалах хугацааг 21 хоног болгох чиглэлээр зөвлөмж өгч зөрчил дутагдлыг арилгуулж ажилласан.<br>- Сүм хийдийн харуул хамгаалалтад ажилладаг болон үйл ажиллагаа хариуцсан эрх бүхий этгээдүүдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдлэг олгох сургалтыг зохион байгуулж байнгын харуул хамгаалалт, камерын хяналтын системийг ажиллуулж байх талаар зөвлөмж өгч ажилласан.<br>- Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн зөвлөгөөнд аймгийн музей, сүм хийд болон | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Σ 0,96 | харуул хамгаалалтын ажилчид болох нийт 21 иргэнийг хамруулж соёлын өв, түүх дурсгалын үнэт зүйл гэж юу болох тэдгээрийг хэрхэн хамгаалах талаар болон хүлээх хуулийн хариуцлагын талаар анхан шатны мэдлэгийг олгосон.<br>- Аймгийн хэмжээнд Буддын шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бүртгэлтэй 10 сүм хийд байна. Үүнээс 3 сүм хийд үйл ажиллагаагаа зогсоосон ба тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа 7 сүм хийдээс "Амгалан дэлгэрэх" хийд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл сунгуулаагүй гэх зөрчил дутагдал илэрсэн. /Үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл сунгуулахаар аймгийн удирдлагад холбогдох баримт бичгийг бүрдүүлэн өгсөн ба зөвшөөрөл гараагүй байсан/<br>**Хүрсэн түвшин:** Шалгалтын явцад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл сунгуулаагүй 1, хяналтын камерын хадгалалтын хугацаа шаардлага хангаагүй 1 буюу нийт 2 зөрчил дутагдал илэрсэн ба богино хугацаанд шаардлага хангасан техник хэрэгсэл, зөвшөөрөл сунгуулах чиглэлээр зөвлөмжийг өгсөн. Шалгалтаар ноцтой зөрчил дутагдал илрээгүй болно. 2023 онд Музей нь 33 дэсийн үзмэрийг шинээр авч, сан хөмрөгөө баяжуулан бүртгэлжүүллээ. | |
| **Стратегийн зорилт 1.3. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын өвийг сурталчлах, төсөл хөтөлбөрийг дэмжиж ажиллана.** | | | | | | | |
| 1.3.1 | **"Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн 1.1 дэх хэсгийн 4 дүгээр арга хэмжээ, "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 1.1.4 дүгээр арга хэмжээ,** | Улсын болон орон нутгийн төсөв | Шинээр бүртгэгдсэн соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын тоо | 90 соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчыг цахимаар бүртгэсэн. | Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг бүсчилсэн судалгаанд хамруулсан байна. | **Хүрсэн түвшин:** Соёлын биет бус өвийн үзлэг тооллого судалгааны ажлын хүрээнд Дархан, Шарын гол, Орхон сумдын 10 өвлөн уламжлагчийг бүртгэл судалгаанд хамруулан жагсаалт гаргаж www.ichmongoluv.mn программд оруулав. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайд болон Дархан-Уул аймгийн Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээний дөрөвдүгээр хавсралтын 4.12 дугаар арга хэмжээ:**<br><br>Соёлын биет бус өвийн 7 ай савд багтах өвлөн уламжлагчдыг байнга бүртгэж, бүсчилсэн судалгааны ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ. | | | | | | |
| 1.3.2 | **Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайд болон Дархан-Уул аймгийн Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээний дөрөвдүгээр хавсралтын 4.8 дугаар арга хэмжээ:**<br><br>Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг дэмжих, шавь сургалт зохион байгуулах, сурталчлах, алдаршуулах ажилд дэмжлэг үзүүлнэ. | Орон нутгийн төсөв | Арга хэмжээний тоо | Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг алдаршуулах тоглолт, өдөрлөг, контент зэрэг нийт 4 арга хэмжээг зохион байгуулсан. | 5-6 ажил, арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ. | 1. 2023.02.15-ны өдөр "Өв соёл - Цагаан сар" уулзалт, хэлэлцүүлгийг Ахмадын хөгжлийн төвд зохион байгуулж 32 хүн хамрагдлаа.<br>2. 2023.03.27-ны өдөр "Дархан тайж Хасарын нэрэмжит төвийн бүсийн аварга шалгаруулах үзэсгэлэн тэмцээн"-ийг Дархан хотноо анх удаа зохион байгуулж 8 ангилалд 71 Монгол банхар нохой өрсөлдлөө. Үзэгчдийн тоо 150<br>3. УБ хотноо МҮОНРТ-ийн "Өв түгээ" зорилтот төслийн нээлтэд аймгийн 3 өвлөн уламжлагч оролцсон.<br>4. Хонгор сумын СББӨ-ийг өвлөн уламжлагч 3 иргэн "Олон улсын музейн өдөр" буюу 2023.05.18–нд өөрсдийн өвлөсөн өвөөр мэндчилгээ дэвшүүлсэн.<br>5. Орхон сумын СББӨ-ийн өвлөн уламжлагчид болон тус сумын Соёлын төвийн дэргэдэх дугуйлангийн сурагчдын хамтарсан гурван үеийн "ЗАЛГАМЖ" тоглолтыг сумын 300 иргэнд толилуулсан.<br>6. Бий биелээч 17 хүүхэд Хүүхдийн баярын нээлтэд биеллээ. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 7. Шарын гол сумын ЕБС-ийн бага ангийн 300 сурагчдын дунд "Зан заншлаас суралцья" уралдаан, номын санч уран уншлагын дугуйлангаар дамжуулан долоон насанд хүрэгч 31 хүүхдэд ерөөл, магтаал аялгуулан уншихыг зааж сургасан.<br>8. Ахмад уран бүтээлч бий биелгээний сургалтад хамрагдан төгсөөд 12 хүүхдэд бий биелгээ, 2 хүүхдэд хурдан морины цол дуудах эрдэмд сургасан.<br>9. Тус аймгийн Соёлын салбарын залуучуудын хөгжлийн зөвлөлтэй хамтран СББӨ-ийг өвлөн уламжлагчдыг нэмэгдүүлэх, шавь сургалтыг уламжлал болгох зорилгоор "Өв соёлоо өвлөн уламжилъя" Зүү ороох хатгамлын сургалтад ЕБ-ын 1 дүгээр сургуулийн 20 сурагчийг хамруулан зохион байгуулсан.<br>10.СББӨ-ийг өвлөн уламжлагч нийт 7 хүнийг "АРДЫН АВЬЯАСТАН" цол тэмдэгт тодорхойлж шагнаж урамшуулсан.<br>11. Хонгор сумын Соёлын төв нь "Соёлын сэргэлт 2023" аяны хүрээнд СББӨ-ийн өвлөн уламжлагч 7 иргэний танилцуулга мэдээллээр Залуучууд театрт үзэсгэлэн гаргаж алдаршуулсан.<br>15. "Соёлын бүтээлч сар" аяны хүрээнд СББӨ-ийн өвлөн уламжлагч 4 ахмад иргэний танилцуулга видеог цахимд байршуулсан бөгөөд нийт 3509 хүн үзэж 378 хүнд таалагдаж 103 сэтгэгдэл үлдээж 47 хүн хуваалцсан байна.<br>16. Хонгор суманд Говлиу хайрханы тахилгыг тохиолдуулан "Малчдын баяр"-ыг 2023 оны 06 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд тус баярын хүрээнд 15 багийн 150 гаруй иргэд Шилмэл малын үзэсгэлэн, Сээр цохих, Сураар бүтээгдэхүүн хийх, Дээс томох, Цагаан идээ шалгаруулах, Олс татах, Хос морьтон шалгаруулах, Шагай шүүрэх, Эмнэг булгиулах зэрэг тэмцээн, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хурдан морины уралдаан, Үндэсний бөхийн барилдаан зэрэг төрлүүдээр өрсөлдсөн.<br>17. ЕБС-ийн 2 дугаар сургуулийн бага ангийн сурагчдын дунд "Зан заншлаас суралцъя" уралдааныг хамтран зохион байгуулсан.<br>18. Номын санч уран уншлагын дугуйлангаар дамжуулан 7 насанд хүрэгч, 31 хүүхдэд ерөөл, магтаал аялгуулан уншихыг, 2 хүүхдэд хурдан морины цол дуудахыг зааж сургасан.<br>19. Шарын гол сумын Соёлын төв өвлөн уламжлагч, соёлын ахмад ажилтан Цэрэнжавтай хамтран ажиллах гэрээ байгуулан, морин хуурын дугуйлан хичээллүүлсэн.<br>20. "Нүүдэлчин Монгол" дэлхийн фестивальд тус аймгаас СББӨ-ийн 15 өвлөн уламжлагч СББӨ-ийн 6 төрлөөр иргэдэд өв соёлоо сурталчлан оролцлоо.<br>21. "Угсаатан бий" төслийн хүрээнд МУУГЗ Г.Баяртай багшийн бий биелгээний сургалтыг зохион байгуулж, 63 сонирхогч, 17 сургагч багшийг бэлтгэн төгсгөж Батламж гардуулсан. Тус сургалтын төгсөгч, СББӨ-ийн өвлөн уламжлагч З.Алтанцэцэг Шарын гол сумын ЕБС-ийн 25 сурагчид бий биелгээг зааж сургасан.<br><br>**Хүрсэн түвшин:** Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг дэмжих, тоглолт, шавь сургалт зохион байгуулах, сурталчлах, алдаршуулах чиглэлээр нийт 22 арга хэмжээг зохион байгуулж 1115 хүн хамрагдсан байна. | |
| 1.3.3 | **"Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн 1.1 дэх хэсгийн 4 дүгээр арга хэмжээ, "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван** | Батлагдсан төсвийн хүрээнд | Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан өвлөн уламжлагчдын тоо | - | Өвлөн уламжлагчыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байна. | Монгол Улсын соёлын биет бус өвийн үндэсний жагсаалтад орсон өвлөн уламжлагчийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлын хүрээнд Дархан сум 30 өвлөн уламжлагч, Хонгор сум 12 өвлөн уламжлагч, Шарын гол сум 14 өвлөн уламжлагчийг, Орхон сум 19 өвлөн уламжлагчийг эрүүл мэндийн урьдчилан | ~~100%~~ 70% |

суурь түвшний тоо тодорхой бус!

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **жилийн үндсэн чиглэл"-ийн 1.1.4 дүгээр арга хэмжээ, "Монгол Улсын Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.6.2, 2.6.3.6 дугаар арга хэмжээ, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайд болон Дархан-Уул аймгийн Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээний дөрөвдүгээр хавсралтын 4.11 дүгээр арга хэмжээ:**<br><br>Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн жагсаалтад бүртгэгдсэн өвлөн уламжлагчийг эрүүл мэндийн үзлэгт хамруулахад дэмжлэг үзүүлнэ. | | | | | сэргийлэх үзлэгт тус тус хамруулахад дэмжлэг үзүүлж ажилласан.<br>**Хүрсэн түвшин:** Нийт 75 өвлөн уламжлагчийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.<br>Σ 0,83<br>Σ 83,0 | |
| **Стратегийн зорилт 1.4. Музейн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | |
| 1.4.1 | **Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг, Музейн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайд болон Дархан-Уул аймгийн Засаг дарга** | Орон нутгийн төсөв 25.0сая | Сан хөмрөгийн үзмэрийн тоо | Үзмэрийн тоог 46-аар нэмэгдүүлэн баяжилт хийсэн байна. | Сан хөмрөгийг баяжуулсан байна. | 1. Тайлант хугацаанд аймгийн Музей нь Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн 02-А/47 тоот тушаалаар 15.00 сая төгрөгийн санхүүжилтээр 33 дэсийн үзмэрийг шинээр авч, сан хөмрөгөө баяжуулав.<br>2. Хонгор сумын ЗДТГ-аас "Музейн тохижилт" төсөлд 10.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлснээр Хонгор сумын Соёлын төвийн Музейд 80 үзмэрийн баяжилт хийгдэн бүртгэл ангилалт хийгдэж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **нарын 2023 онд хамтран ажиллах гэрээний дөрөвдүгээр хавсралтын 4.5 дугаар арга хэмжээ:**<br>Музейн сан хөмрөгийг баяжуулж, үзмэрүүдийг нэмэгдүүлнэ. | | | | | 3.Хонгор сумын Соёлын төвийн Музей 5 иргэн, 1 байгууллагаас 31 тооны үзмэрийг хандиваар хүлээн авснаас 22 үзмэрийг үндсэн үзмэрт бүртгэн баримтжууллаа.<br>4. Орхон сумын Соёлын төвийн Музейд байгууллагаас 2 үзмэр, хувь хүнээс 5 үзмэр хандиваар хүлээн авснаас 7 үзмэрийг үндсэн үзмэрт бүртгэн баримтжууллаа.<br>**Хүрсэн түвшин:** Орон нутгийн төсвийн 25.00 сая төгрөгөөр аймгийн Музейд 33 дэсийн үзмэр, Хонгор сумын Соёлын төвийн Музейд 80 үзмэрийн баяжилт тус тус хийгдсэн.<br>Иргэд, байгууллагын хандиваар Хонгор, Орхон сумдын Соёлын төвийн Музейд 29 үзмэрийг үндсэн үзмэрт бүртгэн баримтжууллаа. | |
| 1.4.2 | **Музейн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайд болон Дархан-Уул аймгийн Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээний дөрөвдүгээр хавсралтын 4.3 дугаар арга хэмжээ:**<br><br>Музей, Номын сангийн үзэл баримтлал, үзүүллэг дэглэлтийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулна. | Соёлын яамны санхүүжилт 16.0 сая | Боловсруулсан баримт бичгийн тоо | Аймгийн Засаг даргын 2022 оны 01-А/343 дугаартай захирамжаар ажлын хэсэг байгуулагдсан. | Үзэл баримтлал, үзүүллэг, дэглэлтийн төлөвлөгөөний төслийг боловсруулж батлуулсан байна. | 1.Музейн үзэл баримтлал, үзүүллэг, дэглэлтийн ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2022 оны 01-А/343 дугаар захирамжаар байгуулсан.<br>2.Аймгийн музей, Төв номын сангийн удирдлага, ажлын хэсгийн эрдэмтдийн хамтарсан цахим уулзалтыг 1 удаа зохион байгуулж мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч ажилласан.<br>3.Аймгийн шинэ Музейн үзэл баримтлал, үзүүллэг дэглэлтийн үндсэн чиглэл боловсруулах ажлын төлөвлөгөөг аймгийн засаг даргын орлогч Б.Жавхлангаар батлуулав.<br>4.Соёлын яамны 2023 оны 10 дугаар сарын 20-ний өдөр дугаар А/401 тоот зардал баталж, эрх шилжүүлэх тухай тушаалаар Музейн үзэл баримтлал, үзүүллэг дэглэлтийн төлөвлөгөө боловсруулахад шаардагдах 16,000,000 төгрөгийн санхүүжилтийн аймгийн Соёл, урлагийн газрын дарга болон уран сайхны удирдаач О.Ангарагсүрэн нар 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр №01 дугаартай ажил гүйцэтгэх гэрээг байгуулан шинэ музейн үзэл | ~~100%~~<br>90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | баримтлал, үзүүллэг дэглэлтийн үндсэн чиглэл боловсруулах ажлыг эхлүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:** Аймгийн шинэ Музейн үзэл баримтлал, үзүүллэг дэглэлтийн үндсэн чиглэл боловсруулах ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргын орлогч Б.Жавхлангаар батлуулав. Соёлын яамнаас санхүүжилт шийдвэрлэгдсэн тул Музейн зүгээс үзэл баримтлал боловсруулахтай холбогдуулан Дархан-Уул аймгийн иргэдийн болон өрхийн тоон мэдээлэл, Музейн үзмэрийн тоон мэдээлэл, төрөл зүйлийн мэдээллийг тус тус илгээв. | |
| 1.4.3 | **Музейн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайд болон Дархан-Уул аймгийн Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээний дөрөвдүгээр хавсралтын 4.6 дугээр арга хэмжээ:**<br><br>Музейн үйлчилгээний нэр төрлийг олшруулах замаар үйлчлүүлсэн иргэдийн тоог нэмэгдүүлнэ. | Батлагдсан төсвийн хүрээнд | Үйлчилгээний нэр төрөл, үйлчлүүлсэн иргэдийн тоо | Музейн боловсролын ажил болон музейгээр үйлчлүүлсэн хүүхдийн тоо 2470 | Өмнөх оноос нэмэгдүүлсэн байна.<br><br>Σ 96,0 | 2023 онд Музейн үйлчилгээ, соёл олон нийт, боловсролын үйлчилгээг нийт 28102 иргэдэд хүргэж ажилласан. Үүнд:<br>Музейгээр үйлчлүүлэгчид-11085<br>Насанд хүрэгчид-1856<br>Хүүхэд-8990<br>Гадаадын үзэгч-164,<br>ХБИ-48<br>Нүүдлийн үйлчилгээ - 8030<br>Музейгээс "Мандала", "Мартан", "Нагтан", "Оюуны цэнгэл", "Оюуны зангилаа", "Уран зураг уншихуй", "Аав ээж би", "Бүтээлч гар", "Бяцхан гар", "Шинэ дурсамж", "Мэдлэгийн хүрд" зэрэг 13 төрлийн боловсролын хөтөлбөрийг зохион байгуулж байна.<br>2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 10.124.940 төгрөгийг Төрийн сангийн дансанд бүрэн төвлөрүүлэн ажилласан.<br><br>**Хүрсэн түвшин:** Музей нь 13 нэр төрлийн боловсролын хөтөлбөрийг 204 удаа, түр үзэсгэлэн 16 удаа дэглэсэн. Нийт 28102 хүнд үйлчилж Дархан-уул аймгийн нийт хүн амын 26 хувьд хүрч үйлчилсэн байна. | 100% |
| **ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Стратегийн зорилт 2.1.Утга зохиол, ном хэвлэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.** | | | | | | | |
| 2.1.1 | **Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.17 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайд болон Дархан-Уул аймгийн Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээний хоёрдугаар хавсралтын 2.5 дугаар арга хэмжээ:**<br><br>-Үндэсний бичиг үсгийн баяр /хавар/,<br>-Номын баяр-2023 / хавар/,<br>-Номын баяр -2023/ намар/,<br>-Дэлхийн Хүүхдийн номын өдөр /хавар/ тус тус зохион байгуулна. | Улсын болон орон нутгийн төсөв | Зохион байгуулсан ажлын тоо, хамрагдсан иргэдийн тоо | 4 арга хэмжээг зохион байгуулж, 19605 хүнийг хамруулсан. | 4 арга хэмжээг зохион байгуулж, 20000 хүнийг хамруулна. | 1."Үндэсний бичиг соёл, номын өдрүүд"-ийг Дархан, Шарын гол, Орхон, Хонгор суманд 2023 оны 5, 9 дүгээр сард "Илүү их уншъя", "Номын баяр-Номтой Монгол" уриан дор нийт 106 арга хэмжээг 154 удаа зохион байгуулж 18,828 иргэнийн хамруулсан. Цахимаар 9 арга хэмжээг 8,198 хүнд хүргэсэн.<br>2."Үндэсний бичиг үсгийн баяр-2023" үйл ажиллагааны хүрээнд харьяа соёлын байгууллагууд нийт 17 арга хэмжээг зохион байгуулж 596 хүнийг хамруулж, цахимаар 3 арга хэмжээг 3616 хүнд хүргэсэн.<br>3."Эх хэлний өдөр" үйл ажиллагааны хүрээнд 21 арга хэмжээг зохион байгуулж 508 хүнийг хамруулж, цахимаар 8,433 хүнд хүргэсэн.<br>4. "Дэлхийн Хүүхдийн номын өдөр"-өөр 93 арга хэмжээг зохион байгуулж 14,607 хүнд үйлчилсэн. Цахимаар 2,546 хүнийг хамруулсан.<br>**Хүрсэн түвшин:** Нийт хавар, намрын номын баяр, үндэсний бичиг үсгийн баярын 4 нэгдсэн үйл ажиллагааны хүрээнд 237 арга хэмжээг зохион байгуулж 34,539 хүнийг хамруулсан. Цахимаар 22,793 хүнд үйлчилгээг хүргэсэн байна. | 100% |
| 2.1.2 | **"Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 1.1 дэх хэсгийн 4 дүгээр арга хэмжээ, "Монгол Улсын Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.6.2 дугаар арга хэмжээ,** | Орон нутгийн төсвөөс 45.7 сая төгрөг | Сан хөмрөгт нэмэгдсэн номын тоо<br>Номын сан 5.0 сая<br>Сумдын Соёлын төвийн номын сан 1.0 сая төгрөгөөс доошгүй өртөг бүхий баяжилт хийсэн байна. | 2022 онд нийт 1605 боть номоор баяжигдсан. | 1650 боть ном | **1.** Төв номын сан 2023 онд нийт 23,598,580 төгрөгийн 769 нэр төрлийн 1152 боть номоор фондоо баяжууллаа. Үүнээс: Хандиваар 319 нэр төрлийн 418 боть 6,193,920 төгрөг, худалдаагаар 450 нэр төрлийн 734 боть 17,404,660 төгрөг<br>**2.** Хүүхдийн номын ордон 16 удаагийн худалдан авалтаар 19,115,422 төгрөгийн 344 нэрийн 932 боть ном худалдан авч сан хөмрөгөө баяжуулсан.<br>**3.** Шарын гол сум орон нутгийн төсвийн 3.0 сая төгрөгийн санхүүжилтээр 276 боть ном, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **“Дархан-Уул аймгийн 2023 оны хөгжлийн хөтөлбөр”-ийн 1.1 дүгээр арга хэмжээ, “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.6.1.3 дугаар арга хэмжээ, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайд болон Дархан-Уул аймгийн Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээний хоёрдугаар хавсралтын 2.5 дугаар арга хэмжээ:** Номын сангуудын сан хөмрөгийг баяжуулна. | | | | | хандиваар 128 боть номоор сан хөмрөгөө баяжуулсан.<br>**4.** Орхон сумын номын санд хандиваар 96 боть ном .<br>**5.** Хонгор сумын номын санд хандиваар 13 боть номоор сан хөмрөгөө баяжуулсан.<br>**6.** Алслагдсан багуудын иргэдэд зориулж номын сангийн баяжилт хийх зорилгоор “Номын хандив” аяныг зарлаж төрийн байгууллага, иргэдээс нийт 752 боть ном цугларснаас 618 боть номыг алслагдсан Малчин, 15 дугаар багийн төвд хүлээлгэн өгч дэмжлэг үзүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:** 2023 онд аймгийн хэмжээнд нийтийн номын сангуудад худалдаагаар 794 нэр төрлийн 1942 боть ном, хандиваар 1407 боть номоор баяжилт хийсэн. Нийт 3349 боть номын баяжилт хийгдсэн. | |
| 4.1.13 | **Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, журам, Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолын хавсралт:**<br>Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, холбогдох тайлан мэдээллээр зохих төрийн байгууллага, албан тушаалтныг хангана. | Батлагдсан төсвийн хүрээнд | Өргөдөл, гомдол, албан бичгийн шийдвэрлэлт | 2022 оны жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр 172 албан бичиг хүлээн авч шийдвэрлэсэн. | Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хууль, журам, зааврын дагуу явуулж, албан бичиг, өргөдөл хүсэлтийг зохих журмын дагуу шийдвэрлэнэ. | 1. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын дагуу эрхлэн явуулсан.<br>2.Иргэдээс нийтдээ 39 өргөдөл, гомдол ирснээс 32 нь бичгээр, 6 нь 70370011, 1 нь 1111 суурин утсаар ирсэн болно. Хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэж хариуг өгсөн.<br>3. Аж ахуйн нэгж, байгууллагаас 429 албан бичиг хүлээн авч бүртгэлжүүлсэн. Үүнээс 74 нь хариутай бичиг ба 4 нь хугацаа ирүүлэх болоогүй. Шийдвэрлэлт 94.6%-тай байна.<br>4.Гадагшаа бусад байгууллагатай 398 албан бичиг харилцсан. Үүнээс хариутай 36 бичгийн 34 нь хариу ирүүлсэн. Шийдвэрлэлт 94.4%-тай байна.<br>5. 2023 оны I-III улирлын өргөдөл, гомдлын мэдээг аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т хуулийн хугацаанд нь 3 удаа гаргаж тайлагнасан. 2023 оны IY улирлын мэдээ гаргах хугацаа болоогүй хүлээгдэж байна.<br>6.Тус газрын Архив-бичиг хэргийн ажилтныг аймгийн Архивын тасгаас зохион байгуулсан танхимын сургалтад хамруулж, мэдлэг ур чадварыг нь дээшлүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:** Өргөдөл, гомдол, албан бичгийн шийдвэрлэлт дунджаар 96.3 хувьтай байна.<br>Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын хэрэгжилт дунджаар 94%-тай байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.14 | **Соёлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.5 дахь заалт:**<br><br>Салбарын болон байгууллагын статистик мэдээг нэгтгэн боловсруулах үйл ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулна. | Батлагдсан төсвийн хүрээнд | Явуулсан мэдээний тоо | Статистик мэдээг нэгтгэн 5 удаа явуулсан | Статистик мэдээг хугацаанд нь нэгтгэн гаргаж хүргүүлнэ. | 1. Харьяа соёлын 7 байгууллагын 2022 оны жилийн эцсийн статистик мэдээг нэгтгэн Газрын даргаар хянуулан ЗГХАСУГ-т 2023.02.06-ны өдрийн 34 тоот албан бичгийн хамт цахим хаяг info@culture.gov.mn болон шуудангаар илгээж тайлагнасан.<br>2.Харьяа соёлын 7 байгууллагын 2023 оны I-III улирлын статистик мэдээг нэгтгэн СУГ-ын даргаар хянуулан ЗГХАСУГ-т албажуулан албан бичгээр, info@culture.gov.mn цахим хаяг руу илгээж тайлагнасан.<br>3. Соёл, урлагийн газрын болон харьяа соёлын 7 байгууллагын 2022 оны жилийн эцсийн хөрөнгө, санхүүгийн статистик мэдээг нэгтгэн СУГ-ын даргаар хянуулан 2023.04.27-ны өдрийн 127 тоот албан бичгийн хамт ЗГХАСУГ-т шуудангаар болон info@culture.gov.mn цахим хаягаар илгээж тайлагнасан.<br>**Хүрсэн түвшин:** Статистик мэдээг 2022 оны жилийн эцэс, 2023 оны I-III улирлын байдлаар нэгтгэн гаргаж хугацаанд нь ЗГХАСУГ-т илгээж тайлагнасан.<br>2023 оны IY улирлын мэдээний нэгтгэл хийгдэж байна. Цаглалбарт хугацаанд багтаан 2023.12.20-ны дотор ЗГХЭГ СУГ-т цахимаар болон шуудангаар хүргэх болно. | 100% |
| 4.1.15 | **Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны 03 тоот тогтоол, Соёлын сайдын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/424 дүгээр тушаал, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны** | Батлагдсан төсвийн хүрээнд | Төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулсан байна. | Эцэг, эхийн зөвлөл байгуулж, дүрмийг шинээр боловсруулсан. | Төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангуулна. | Тус газрын Эцэг эхийн зөвлөл 2023 онд 9 заалт бүхий төлөвлөгөө гаргаж ажиллалаа.<br>1.Соёлын сайдын 2022 оны А/424 дүгээр тушаалаар батлагдсан Соёлын салбарын хүүхэд хамгааллын бодлого, албан хаагчийн хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэм"-ийг нийт албан хаагчдад танилцуулж хяналтад авч ажиллаж байна.<br>2.Тус газрын эцэг эхийн зөвлөл нь аймгийн Засаг даргын санаачилсан "1/5" аяны хэрэгжилтийг хангуулж зорилтот бүлгийн 18 иргэний мэдээллийг “Гэрэлтэй” өрхийн эмнэлэгт хүргүүлж оношилгоо, үзлэгт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **хөтөлбөр"-ийн 1.5.10.3 дугаар арга хэмжээ:**<br><br>Байгууллагын эцэг, эхийн зөвлөлийн ажлыг идэвхжүүлнэ. | | | | | хамруулж, 2 иргэн, 10 хүүхдэд дархлаа дэмжих витаминыг олгосон. Хуваарилагдсан айл өрхүүдэд сар бүр хүнсний тусламж үзүүлсэн.<br>3.Хүүхэд хамгааллын бодлогын хүрээнд аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөөнд тус газрын албан хаагчдаас гаргасан саналыг нэгтгэж ГБХЗХГ-т хүргүүлсэн бөгөөд хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайланг цаг тухайд нь хүргүүллээ.<br>4."Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх" чиглэлээр цахим сургалтад соёлын 7 байгууллагын 11 албан хаагч хамрагдсан.<br>5.Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхийн өдрийг тохиолдуулан "Нийгэмд шударга ёсыг бэхжүүлье! Хүүхдийн хөдөлмөрийг устгая! уриан дор бодлогын зөвлөгөөний зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллалаа.<br>6.Залуучууд театрын дэргэдэх "Шонхоодой" циркийн хүүхдүүдээс ирсэн хүсэлтийг аймгийн Улаан загалмайн хороонд уламжилж хүнсний болон ахуйн хэрэглээний тусламж үзүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:** Байгууллагын эцэг, эхийн зөвлөлийн үйл ажиллагаа жигдэрсэн. Соёлын байгууллагууд нь "Хөшиг нээгдэх бүрд Хүргэх нэг үг" уриалгын хүрээнд Соёл, урлагийн үзвэр үйлчилгээ бүрийн эхэнд Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдэд үүргийг сануулсан уриалга хүргэж хэвшлээ. Мөн Соёл, урлагийн үзвэр үйлчилгээний байгууллага худалдаалагдсан тасалбарын орлогын 1%-ийг өөрийн байгууллагын хэмжээнд хүүхдийн хөгжил, хамгааллын ажилд зарцуулж байна. Соёлын 7 байгууллагууд тайлангаа улирал бүр өгч хэвшсэн. | |
| 4.1.16 | **Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13** | | Төлөвлөгөө боловсруулан батлуулж, | – | Төлөвлөгөөний хэрэгжилтийг | 1. Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд Соёл, урлагийн газрын гамшгийн өмнөх үйл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **дугаар зүйлийн 13.1, 13.2.4**<br><br>Гамшгаас хамгаалах сургалтын төлөвлөгөө боловсруулан баталж хэрэгжүүлэн ажиллана. | Батлагдсан төсвийн хүрээнд | хэрэгжилтийг хангуулсан байна. | | бүрэн хангуулна. | ажиллагаа болон гамшиг, осол, эрсдэлт нөхцөл байдал үүссэн тохиолдолд ажиллах штабын бүтэц, томилгоот бүрэлдэхүүн, орлон ажиллах ажилтны нэрсийг тус газрын даргын 2023 оны А/10 дугаар тушаалаар баталсан.<br>2. Мөн байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж аймгийн ОБГ-аар хянуулан батлуулсан.<br>3. Улсын хэмжээнд зохион байгуулсан газар хөдлөлтийн гамшиг тохиолдож “Онц байдал” тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа” сэдэвт Стратегийн команд штабын сургалтад бүрэн хамрагдсан. 2023.06.08-ны өдрийн 16:00 цагт дуугарсан гамшгийн зарлан мэдээллийн дуут дохиогоор тус газрын албан хаагчид цуглах цэгт бүрэн цугларч ирц бүртгэл, аранзны үзлэгт хамрагдсан.<br>4.Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн гамшигтай тэмцэх чадавхийг дээшлүүлж, харилцан хамтын ажиллагааг жигдрүүлэх, гамшгаас хамгаалах арга хэмжээнд ард иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, аймгийн гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх зорилго бүхий "Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль"-д албаны бие бүрэлдэхүүн хамрагдсан.<br>5. "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян-2023"-ы хүрээнд Гамшиг эрсдлээс урьдчилан сэргийлэх хамгаалах сургалтад тус газрын 7 албан хаагчийг хамруулсан. Ажлын байрны орчинд галын аюулгүй байдлыг хангуулж ажилласан.<br>**Хүрсэн түвшин:** Гамшгаас хамгаалах сургалтын төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан. Улсын хэмжээнд зохион байгуулсан газар хөдлөлтийн гамшиг тохиолдож “Онц байдал” тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа” сэдэвт | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Стратегийн команд штабын сургалтад бүрэн хамрагдсан. 2023.06.08-ны өдрийн 16:00 цагт дуугарсан гамшгийн зарлан мэдээллийн дуут дохиогоор тус газрын албан хаагчид цуглах цэгт бүрэн цугларч ирц бүртгэл, аранзны үзлэгт хамрагдсан. | |
| **Стратегийн зорилт 4.2 Хүний нөөцийн сургалт, нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.** | | | | | | | |
| 4.2.1 | Байгууллагын хүний нөөцийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулна. | Батлагдсан төсвийн хүрээнд | Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хүний нөөцийн үйл ажиллагааг зохион байгуулсан байна. | Хүний нөөцийн өдөр тутмын үйл ажиллагааг хуульд заасны дагуу зохион байгуулж, сул гарсан 6 орон тооноос 5-ыг нь нөхөж томилгоо хийсэн. | Сул орон тоог тухай бүр нөхөх арга хэмжээг авч, хөдөлмөрийн харилцаатай холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. | 1. ТАТХ, ХТХ-д заасны дагуу тайлант хугацаанд 6 хүнийг албан тушаалд томилсон, 6 албан хаагчийг өөрийн санаачилгаар төрийн албанаас чөлөөлсөн, 4 албан хаагчид эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, 1 албан хаагчид хавсран гүйцэтгүүлэх, туршилтын хугацаатайгаар томилогдсон 2 албан хаагчийг жинхэлсэн, түр орлон гүйцэтгэх хугацааг дуусгавар болгосон 4 шийдвэр гаргасан.<br>2. Соёлын сайдын баталсан 2022 оны А/04 дүгээр тушаалаар тус газар нь 11 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулахаас 2023.12.05-ны өдрийн байдлаар 9 албан хаагч ажиллаж байна. Сул гарсан орон тооны хувьд СУХ-ийн дарга, Урлаг, уран бүтээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн байна.<br>3. ТАТХ-д заасны дагуу ДУА дахь ТАЗСЗ-д сул гарсан орон тоог 7 хоногийн дотор мэдээлж, зарлуулах хүсэлтээ 21 хоногт багтаан хүргүүлж захиалга өгөгдсөний дагуу 2023 онд сул гарсан Соёл, гэгээрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Төсөв, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтний орон тоо нөхөгдсөн.<br>4. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, Мэргэжлийн хяналтын байгууллагын төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг албан хаагчид үйл ажиллагаандаа мөрдлөг болгон зөрчилгүй ажилласан. Ёс зүйн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөвлөлөөс 2023 оны эхний хагас жил, жилийн эцсийн тайланг ДУА дахь ТАЗСЗ-д хүргүүлж тайлагнасан.<br>5. Шинээр томилогдсон 6 албан хаагчдад Албан тушаалын тодорхойлолт, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг уншиж танилцуулсан.<br>**Хүрсэн түвшин:** Төрийн жинхэнэ албан хаагчийн сул гарсан орон тоог нөхөх арга хэмжээг авах талаар ДУА дахь ТАЗСЗөвлөлд 5 удаа албан бичгээр хандсан болно.<br>Байгууллагын удирдлагын зүгээс хүний нөөцтэй холбоотой Б тушаал 25-ыг гаргаж, хэрэгжилтийг бүрэн хангуулсан. | |
| 4.2.2 | Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ. | Батлагдсан төсвийн хүрээнд | Хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | 1 албан хаагч ХАСУМ, ХАСХОМ гаргасан. | ХАСУМ, ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд мэдүүлж, зөрчилгүй ажиллана. | 1. Тайлант хугацаанд 2022 оны ХАСХОМ-ийг 4 албан хаагч шинэчлэн гаргаж, 2 албан хаагч шинээр мэдүүлсэн.<br>2. Нийтийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн 4 хүний ХАСУМ-ийг АТГ-т хянуулахаар хүргүүлснээс зөрчилгүй гэх 4 дүгнэлт ирсэн. Үүнээс 2 хүний томилгоог хийж, 2022 оны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд нь гаргуулсан.<br>3.АТГ-ын даргын 2023.05.12-ны өдрийн А/31 дүгээр тушаалаар баталсан маягтыг үндэслэн 7 төрлийн бүртгэлийн дэвтрийг хэвлэж бэлэн болгосон.<br>4. Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг боловсруулан газрын даргаар хянуулж, 7 үйл ажиллагааны хүрээнд 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс биелэлтийг 94%-иар хангууллаа.<br>5.Нийтийн албан тушаалд нэр дэвших хүсэлт гаргасан 4 хүний ХАСУМ-ийг хянаж, АТГ-т хүргүүлэх арга хэмжээг авсан.<br>6.Төрийн албаны тухай хуульд заасан шаардлагыг хангасан, төрийн албаны тусгай шалгалт өгч тэнцсэн нэр бүхий 2 иргэнийг ДУА дахь ТАЗСЗ-ийн тогтоолоор нэр дэвшүүлсний дагуу холбогдох хууль тогтоомжийн хүрээнд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дүгнэлт, лавлагаа, тодорхойлолтуудыг авч томилгоо хийсэн шийдвэрийг хавсарган хүргүүлэв.<br>7. Нийтийн албан тушаалд томилогдсон 2 албан тушаалтанд ХАСХОМ-ийг хэрхэн мэдүүлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хуулийн хугацаанд мэдүүлгийг авсан.<br>**Хүрсэн түвшин:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулахад бүх шатандаа анхаарч, ёс зүйн зөрчилгүй ажилласан. | |
| 4.2.3 | **Соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.8**:<br><br>Албан тушаалын мэргэшүүлэх багц, богино, дунд хугацааны сургалтад албан хаагчдыг хамруулна. | Батлагдсан төсвийн хүрээнд | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо<br>Сургалтад хамрагдсан албан хаагчдын нэгдсэн мэдээлийн сан үүсгэнэ. | Мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 1 албан хаагч, богино хугацааны сургалтад хамруулсан. | Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах ажилтны судалгаа, саналыг холбогдох байгууллагад хүргүүлж, сургалтад хамруулна. | Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах ажилтны судалгааг гаргаж, саналаа Дархан-Уул аймаг дахь ТАЗСЗ-д өгч, 2 квот авсан. Үүнээс<br>Тус газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, статистик мэдээ хариуцсан мэргэжилтэн Ш.Дэлгэрмаа хамрагдаж сертификатаа гардан авсан.<br>Тус газрын Соёл, урлагийн хэлтсийн Төлөвлөлт, тайлагналт, мэдээлэл технологи, цахимжилтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Чинбилэг төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад хамрагдаж байна. | 100% |
| 4.2.4 | **Соёлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2 дахь заалт:**<br><br>Байгууллагаас 2023 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөө, Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулна. | Батлагдсан төсвийн хүрээнд | Төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангуулсан байна. | Сургалтын болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний хэрэгжилт 90.5%-иар хангагдсан. | Төлөвлөгөөний хэрэгжилтийг өмнөх оны мөн үеэс 3 хувиар нэмэгдүүлнэ. | 1. Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны асуудлыг шийдвэрлэх хүрээнд:<br>-2023 онд 13 заалт бүхий хавсралт төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг 93 хувиар хангуулан ажиллаж байна. Үүнд:<br>-Төрийн албаны тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журамд заасны дагуу 7 албан хаагчид төрийн албан хаасан хугацааны нэмэгдлийг нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн.<br>-МУЗГ-ын 2022 оны 489 дүгээр тогтоолоор орон нутагт ажилласны нэмэгдлийг төрийн захиргааны албан тушаал эрхэлдэг 7 албан хаагчид албан тушаалын сарын үндсэн | ~~100%~~ 90% |



95% > ?

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цалингийн 20 хувиар бодож 2023.01.01-нээс эхлэн сар бүр олгож байна.<br>-АИТХ-ын 2023 оны 43 дугаар тогтоолоор орон нутагт ажилласны нэмэгдлийг төрийн захиргааны албан тушаал эрхэлдэг 7 албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиар бодож 2023.07.01-нээс эхлэн сар бүр олгож байна.<br>-Ажил хөдөлмөрөөрөө бусдыгаа манлайлан ажилласан 3 албан хаагчийг салбарын шагналд тодорхойлсноос 2 албан хаагч салбарын шагналаар шагнагдсан.<br>2. Төрийн албан хаагчийг чадавхижуулах чиглэлээр 13 заалт бүхий сургалтын төлөвлөгөө боловсруулан батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 94 хувьтай байна.<br>**Хүрсэн түвшин:** Байгууллагаас 2023 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөө, Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний хэрэгжилтийг дунджаар 93.5%-иар хангууллаа. | |
| 4.2.5 | Соёл, урлагийн газар, харьяа соёлын байгууллагуудын ээлжит, ээлжит бус шуурхай хурлыг танхим болон цахимаар зохион байгуулж хурлаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавьж ажиллана. | Батлагдсан төсвийн хүрээнд | Оролцсон болон зохион байгуулсан хурлын тоо, өгсөн үүрэг даалгавар, биелэлтийн хувь | - Удирдах дээд байгууллагаас зарласан хуралд 18 удаа оролцож, хурлаас өгөгдсөн 7 үүрэг даалгаврыг хэрэгжүүлж тайлагнасан.<br>-Дотоодын шуурхай хурлыг 16 удаа зохион байгуулж, 135 үүрэг | Удирдах дээд байгууллагаас зохион байгуулсан цахим шуурхай хуралд тухай бүр нь оролцож, дотоодын шуурхай хурлыг 7 хоног тутам зохион байгуулж, биелэлтийг хангуулна. | 1. Соёл, урлагийн газрын шуурхай хуралдаан 2023 оны жилийн эцсийн байдлаар 24 удаа хуралдаж, 80 үүрэг даалгавар өгөгдөж бүрэн хэрэгжсэн.<br>2.Харьяа соёлын байгууллагын удирдлагуудтай танхимаар 11 удаа, цахимаар 8 удаа хуралдаж, 60 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг бүрэн хангуулсан.<br>3.ЗГХАСУГ-аас зохион байгуулсан 28 удаагийн цахим хуралд оролцож, өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг тухай бүр нь тайлагнасан.<br>**Хүрсэн түвшин:** Удирдах дээд байгууллагаас зохион байгуулсан 28 удаагийн цахим хуралд оролцсон. Дотоодын шуурхай хурлыг 24 удаа зохион байгуулж, биелэлтэд байнгын хяналт тавин ажилласан. Харьяа соёлын байгууллагуудыг удирдлага зохион | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | даалгаврыг албажуулж ажилласан. | | байгуулалтаар хангах хүрээнд 19 удаа /танхим-11, цахим-8/ хурал зарласан. | |
| 4.2.6 | **Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйл, "Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 1.5.10.5 дугаар арга хэмжээ:**<br><br>"Жендэрийн эрх тэгш байдлыг хангах" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллана. | Батлагдсан төсвийн хүрээнд | Төлөвлөгөө боловсруулан батлах, хэрэгжилтийг хангуулах. | 5 арга хэмжээг зохион байгуулсан. | Төлөвлөгөөний хэрэгжилт хангагдана. | 1. Жендерийн тэгш байдал болон Монгол Улсын охид эмэгтэйчүүдийн нийгэм эдийн засагт эзлэх байр суурийг бэхжүүлэхэд инноваци ба технологийн оролцоо сургалтад 1 мэргэжилтэн хамрагдсан.<br>2.Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай 8 ширхэг зурагт хуудас хийж, газрын пэйж хуудсанд байршуулж, "Харилцан бие биенээ хүндэтгэе" аянд нэгдэн харъяа соёлын байгууллагуудыг уриалгад нэгдүүлсэн.<br>3. "Төрийн байгууллагуудын жендерийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт"-д хамрагдаж, байгууллагын 2022 онд хийсэн ажлын талаар мэдээлэл хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцсон.<br>4. "Жендерийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр"-ийн хүрээнд 12 заалт бүхий төлөвлөгөө гарган хэрэгжилтийг бүрэн хангуулж ажиллалаа.<br>5.Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аянг өрнүүлж 32 нөлөөллийг ажлыг зохион байгуулж, соёлын байгууллагын 100 гаруй албан хаагчид аянд нэгдсэн.<br>6. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бэлгийн мөлжлөгийн хохирогчид туслалцаа үзүүлэх төслийн хүрээнд зарласан "Жендэрт суурилсан хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөгийн хохирогч, даван туулагчийн үзэл бодол, мэдрэмж" уран бүтээлийн уралдаанд Дархан-Уул аймгаас оролцогч МУСТА, Шог зураач, шог зохиолч Д.Мянганзам 2 дугаар байранд шалгарч шагналын эзэн боллоо. Тус уран бүтээлийн уралдаанд нийт 19 бүтээлчийн 25 бүтээл оролцсон байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **Хүрсэн түвшин:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг 100 хувь хангуулсан. | |
| **Стратегийн зорилт 4.3. Санхүүгийн удирдлага, төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналтыг чангатгаж, үр дүнг тайлагнах, шилэн дансны бүртгэлийн хөтлөлт, үнэн зөв байдлыг хангана.** | | | | | | | |
| 4.3.1 | Соёл, урлагийн байгууллагын 2024 оны төсвийн төслийг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлнэ. | Батлагдсан төсвийн хүрээнд | Төсвийн төслийг хүргүүлсэн эсэх | Батлагдсан нийт төсөв - 210,861.1 мянган төгрөг | 2024 оны төсвийг өмнөх оныхоос бууруулахгүйгээр батлуулна. | 1. 2024 оны төсвийн төслийг 2023 оны 09 дүгээр сард багтаан боловсруулж дуусган Соёлын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлэхээр бэлтгэл ажлыг хангах хүрээнд соёлын байгууллагуудаас төсвийн санал авах, мэдээлэл цуглуулах зэрэг ажлуудыг хийж нэгтгэсэн.<br>2. Дунд хугацааны төсвийн төслийг хуулийн хугацаанд багтаан төсвийн ерөнхийлөн захирагчид 2024 онд 470,409,8 мянган төгрөгөөр төсөвлөж хүргүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:** Соёлын байгууллагын 2024 оны төсвийг өмнөх оныхоос бууруулахгүйгээр 259,548,7 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх саналтайгаар хүргүүлж батлуулсан. | 100% |
| 4.3.2 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан цахим системийн хөтлөлтөд тогтмол бүртгэлээр хяналт тавьж, санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллана. | Батлагдсан төсвийн хүрээнд | Мэдээллийн тоо, хэрэгжилтийн хувь | Шилэн дансанд нийтлэх 52 мэдээллийг цахим системд байршуулсан.<br>Хэрэгжилт 99.1 хувь | Шилэн дансны цахим хуудасны хөтлөлтөд сар бүр хяналт тавьж, зөрчилгүй ажиллана. | Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуульд заасны дагуу шилэн дансанд цаг тухай бүрт нь нийтлэх нийт 163 мэдээллийг ил тод байршуулсан. | 100% |
| 4.3.3 | Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу цахим хэлбэрээр хэрэгжүүлнэ. | Батлагдсан төсвийн хүрээнд | Арга хэмжээний тоо | - | Худалдан авах ажиллагааг 100 хувь цахимаар зохион байгуулсан байна. | 1. 2023 оны 12 дугаар сарын байдлаар төсөл хөтөлбөрийн хүрээнд 2023 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авах тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т хүргүүлж, аймгийн ОНӨГ-аас нээлттэй тендер шалгаруулалтын журамд заасны дагуу хялбаршуулсан цахим худалдан авалтыг 2023.11.28-ны өдөр зарлаж, 2024.01.02-ний өдрийг хүртэл хугацаанд тендер хүлээн авах | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагаа хийгдэж байна. Уг жагсаалтад Залуучууд театрт 450.0 сая төгрөгийн үнэ бүхий зөөврийн тайз, карказ, гадна зориулалтын зөөврийн лед дэлгэц, 50.0 сая төгрөгийн үнэ бүхий 4 нэр төрлийн 23 ширхэг тоног төхөөрөмж орсон болно.<br>2. Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс орон нутгийн хөрөнгө оруулалтаар Залуучууд театрт 200.0 сая төгрөгийн дуу шуумны тоног төхөөрөмж худалдан авах тендерийг зарласан. Аймгийн ОНӨГ-аас худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулж, тендерт Бодь интернешнель ХХК шалгарсан.<br>3. 2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар соёлын байгууллагуудын тоног төхөөрөмжийн зардалд 300.0 сая төгрөгийг батлуулж, техникийн тодорхойлолтыг боловсруулан 2023.12.10-ны өдрийн дотор Соёлын яаманд хүргүүлэхээр ажиллаж байна.<br>4. Тус газраас худалдан авах ажиллагааны цахим системд 7 арга хэмжээний 12,462.6 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээний төлөвлөгөөг нийтлэн батлуулсан.<br>5. Харъяа соёлын 7 байгууллага худалдан авах ажиллагааны цахим системд 78 арга хэмжээний 288.879.3 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөг батлуулан нийтэлж, 275.885.4 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг шууд худалдан авалтаар хийсэн байна.<br>Тус газраас 20.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 1 худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулах техникийн тодорхойлолтыг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т хүргүүлсний үр дүнд аймгийн ОНӨГ-аас цахим худалдан авалтыг зарлаж, тендер хүлээн авах ажлыг зохион байгуулж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.3.4 | Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх төсөл, арга хэмжээг эрэмбэлэх, барилга, байгууламж, их засвар, хөрөнгө оруулалтыг данс бүртгэл, тайлан, балансад тусгагдсан эсэхэд хяналт тавьж үр дүнг тооцно. | Батлагдсан төсвийн хүрээнд | Төсөл, арга хэмжээний тоо | - | Төсөл, арга хэмжээг эрэмбэлж, хөрөнгө оруулалтыг данс бүртгэлд тусгуулна. | Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын даргын 2023 оны 02-А/47 дугаартай тушаалаар Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төв номын сан /10.0 сая/, Хүүхдийн номын ордон /10.0 сая/, Музейн /15.0 сая/ сан хөмрөгийг баяжуулах, соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх зардалд нийт 35.0 сая төгрөг гаргуулахаар шийдвэрлүүлсэн.<br>2. Дархан-Уул аймгийн ИТХ-ын 2023 оны 58 дугаар тогтоолоор Хүүхдийн номын ордны гадна цахилгааны ажлыг гүйцэтгэх төсвийн төслийг баталж, гүйцэтгэгч компанитай гэрээ хийж ажлыг хийж гүйцэтгүүлсэн.<br>3. Аймгийн музейн үзэл баримтлал, үзүүллэг дэглэлтийг боловсруулахад зөвлөх үйлчилгээ авах төсвийн төслийг улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгуулахаар санал өгсний дагуу 16,0 сая төгрөгийн санхүүжилтээр музейн үзэл баримтлал, үзүүллэг дэглэлт боловсруулах шийдвэрийг гарсан. Энэ хүрээнд тус газрын дарга Х.Соёл-Эрдэнэ, Уран сайхны удирдаач О.Ангарагсүрэн нар 2023.11.16-ны өдөр" Ажил гүйцэтгэх гэрээ"-г байгуулж, шинэ музейн үзэл баримтлал, үзүүллэг дэглэлтийн үндсэн чиглэл боловсруулах төлөвлөгөөний төслийг боловсруулж батлуулснаар судалгааны ажлыг эхлүүлээд байна.<br>4. Хонгор сумын орон нутгийн хөгжлийн сангаас 20.0 сая төгрөгийн бүжгийн хувцас, 10.0 сая төгрөгийн номын сангийн тоног төхөөрөмж, 10.0 сая төгрөгийн музейн үзмэрийг хадгалах хорго, 20.0 сая төгрөгийн дуу шумны студийн тоног төхөөрөмж худалдан авахад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.<br>5.Залуучууд театрт 20.0 сая төгрөгийн уран бүтээлчдийн хувцас худалдан авах санхүүжилтийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлэсэн.<br>6.Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс орон нутгийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөрөнгө оруулалтаар Залуучууд театрт 200.0 сая төгрөгийн дуу шуумны тоног төхөөрөмж худалдан авах тендерийг зарласан. Аймгийн ОНӨГ-аас худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулж, тендерт Бодь интернешнель ХХК шалгарсан. Мөн Залуучууд театрын гадна шатны засвар 394,854,725.4 төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Оролцогч ирээгүй шууд гэрээ байгуулахаар шийдвэрлэсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Залуучууд театрт 450.0 сая төгрөгийн үнэ бүхий зөөврийн тайз, карказ, гадна зориулалтын зөөврийн лед дэлгэц, соёл, урлагийн газарт 50.0 сая төгрөгийн үнэ бүхий 4 нэр төрлийн тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т хүргүүлж, аймгийн ОНӨГ-аас нээлттэй тендер шалгаруулалтын журамд заасны дагуу хялбаршуулсан цахим худалдан авалтыг 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр зарлаж, 2024 оны 01 дүгээр сарын 02-ний өдрийг хүртэл хугацаанд тендер хүлээн авах ажиллагаа хийгдэж байна.<br>**Хүрсэн түвшин:** Санхүүжилтээр хөрөнгө оруулалт хийгдсэн даруй данс бүртгэлд тусгаж ажилласан байна. Ажил гүйцэтгэх гэрээний дагуу шинэ музейн үзэл баримтлал, үзүүллэг дэглэлтийн үндсэн чиглэл боловсруулах төлөвлөгөөний төслийг боловсруулах судалгааны ажлыг эхлүүлсэн. Соёлын салбар дахь хөрөнгө оруулалт нэмэгдсэн. | |
| 4.3.5 | **Соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.5:**<br>Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2024 онд хийгдэх их засвар, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын ажлын | Батлагдсан төсвийн хүрээнд | Хүргүүлсэн саналын тоо | 2 удаа санал авч нэгтгэн хүргүүлсэн. | 2 удаа | 1. 2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хонгор суманд 400 үзэгчийн суудалтай соёлын төв байгуулах саналыг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т хүргүүлж, хөрөнгө оруулалтын PIMIS программд мэдээллийг оруулсан.<br>2. Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайд болон Аймгийн Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээнд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | саналыг нэгтгэн дээд шатны байгууллагад хүргүүлнэ. | | | | | тусгагдсаны дагуу аймгийн ЗДТГ-ын НБХ-т соёл, урлагийн байгууллагуудад нэн шаардлагатай техник хэрэгслийн судалгааг гаргаж хүргүүлсэн. Энэ дагуу 2024 онд Улсын төсөвт соёлын байгууллагуудын тоног төхөөрөмжид нийт 300.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэх төсөв батлагдсан.<br>3. Соёлын 8 байгууллагаас 2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх тоног төхөөрөмжийн судалгааг нэгтгэн гаргасан. Саналаа аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т хүргүүлж, хөрөнгө оруулалтын PIMIS программд шивсэн.<br>2. 4. УИХ-ын гишүүн, сангийн сайд Б.Жавхланд зөөврийн тайз, гадна зориулалтын лэд дэлгэцтэй болох саналыг хүргүүлж улсын төсвийн хөрөнгө оруулалтаар авахаар шийдвэрлүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:** Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2024 онд хийгдэх их засвар, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтад 5 удаа санал хүргүүлсэн. | |
| 4.3.6 | **Соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.4, 21.1.5:**<br><br>Соёлын салбарын төсвийн төслийг нэгтгэн боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлнэ. | Батлагдсан төсвийн хүрээнд | Хэрэгжилтийн тоо, хувь | 100% | 100% | Соёлын 7 байгууллагын 2024 оны дунд хугацааны төсвийн төсөл, 2025-2026 оны төсвийн төсөөллийг Соёлын яамны СХОГ-т 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 212 тоот албан бичгээр хүргүүлсэн. Тус газрын харъяа соёлын салбарын 7 байгууллагын төсвийн төсөл, төсөөллийг нэгтгэн боловсруулж, цаглабарын дагуу Соёлын яаманд хүргүүлж ажилласан. | 100% |
| 4.3.7 | Соёлын салбарт улс, орон нутаг, төсөл хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын ажлуудад хяналт тавьж ажиллана. | Батлагдсан төсвийн хүрээнд | Хяналт тавьсан тоо | - | 2 | 1. Музей, Номын сангийн цогцолбор барилгын ажлын нийт төсөвт өртөг шаардлагатай 15,6 тэрбум төгрөгийн санхүүжилтээс тус онд 5,920.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн ба уг төслийн гүйцэтгэгчээр Воком констракшн ХХК ажиллаж, барилгын гүйцэтгэлийн ажил 85 хувьтай явагдаж байна.<br>2. Хонгор сумын нутагт Говил уулын ар бэлд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | буй Сяньбигийн хаад язгууртны бунхант булшны малтлагын төсөвт орон нутгаас 70 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Уг малтлага судалгааны ажлын үр дүнд 49 нэр төрлийн эртний олдворууд илэрсэн байна.<br>3.Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсаны дагуу орон нутгийн хөрөнгө оруулалтаар Музейн үзмэр худалдан авах төсөл арга хэмжээнд зориулж 15 сая төгрөг, Төв номын сангийн сан хөмрөгийн баяжилтанд зориулж 10 сая төгрөг, Хүүхдийн номын ордны номын сангийн сан хөмрөгийн баяжилтанд зориулж 10 сая төгрөг тус тус төсөвлөснийг хяналт тавьж ажилласан.<br>4.Хонгор сумын орон нутгийн хөгжлийн сангаас 20.0 сая төгрөгийн бүжгийн хувцас, 10.0 сая төгрөгийн номын сангийн тоног төхөөрөмж, 10.0 сая төгрөгийн музейн үзмэрийг хадгалах хорго, 20.0 сая төгрөгийн дуу шумны студийн тоног төхөөрөмж худалдан авахад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.<br>Тайлант хугацаанд харьяа соёлын 6 байгууллагуудад нийт 16,649.9 сая төгрөгөөр санхүүжигдэх 9 төсөл хөтөлбөр хэрэгжиж байгаагаас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 15,6 тэрбум төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 1,049.9 сая төгрөгийн санхүүжилт үзүүлсэн. Соёлын салбарт улс, орон нутаг, төсөл хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй нийт төсөл хөтөлбөрүүдэд 9 удаа хяналт тавин ажилласан. | |
| 4.3.8 | **Соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.4, 21.1.5:** Төсвийн тодотголд санал өгч ажиллана. | Батлагдсан төсвийн хүрээнд | Саналын тоо | Төсвийн тодотголд 1 санал өгсөн. | 1-ээс доошгүй санал өгнө. | Соёлын байгууллагууд батлагдсан төсвийн хүрээнд төсөвтөө багтаан үйл ажиллагаагаа явуулсан.<br>Үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилт хийгдснээр төсөв хүрэлцээтэй, тодотголд өгөх саналгүй болно. | 100% |
| 4.3.9 | **Соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.5, Нягтлан бодох** | Батлагдсан төсвийн хүрээнд | Хэрэгжилт хувиар | Хэрэгжилт бүрэн хангагдсан. | Санхүүгийн зөрчилгүй ажиллана. | Соёл, урлагийн газар, харъяа соёл, урлагийн 7 байгууллагуудын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэж, санхүүгийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **бүртгэлийн тухай хууль,** Соёлын байгууллагуудын санхүүгийн тайланг олон улсын стандартад нийцүүлэн гаргаж аудитын дүгнэлт гаргуулж, холбогдох байгууллагуудад хүргүүлнэ. | | | | | зөрчилгүй дүгнэлт гаргуулж, цахим системд нэгтгэж, нэгтгэл тайланг Соёлын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газарт 2023.03.20-ны өдрийн 74 тоот албан бичгээр хүргүүлж тайлагнасан. Соёлын байгууллагууд санхүүгийн зөрчилгүй, ажилласан. | |
| **Стратегийн зорилт 4.4.Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын ажлыг сайжруулна.** | | | | | | | |
| 4.4.1 | **Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам:** Соёл, урлагийн газрын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллана. | Батлагдсан төсвийн хүрээнд | 1/ Байгууллагын нэгжийн болон албан хаагчдын үйл ажиллагаанд дотоод хяналт хийсэн дүн, танилцуулга, санал, хурлын шийдвэр 2/ Хурлын шийдвэрийн хэрэгжилт | - | Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулан батлуулж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг хүргүүлсэн байна. | 1.Дотоод хяналт шалгалтын дүнг байгууллагын удирдлагад болон нийт бие бүрэлдэхүүнд танилцуулж, 1 зөвлөмж гарган Архив-бичиг, няравын ажилтанд хүлээлгэн өгч, биелэлтийг хангуулсан. 2.Тус газрын харъяа соёлын 7 байгууллагын бүтэц, орон тоог баталсан, цалин хөлсийг шинэчлэн тогтоосон шийдвэрийг хянан үзэж, "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-ын хэрэгжилттэй танилцаж, хүний нөөцтэй холбоотой шийдвэр, баримт бичигт үзлэг хийж, цахим системд нэвтрэн хяналт тавьж зөвлөмж өгсөн. | 100% |

ерөнхий үнэлгээ Σ 96,31%
Σ 97,7%

Төлөвлөгөөний биелэлтийг хянасан: Төсвийн шууд захирагч

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА Х.СОЁЛ-ЭРДЭНЭ

(албан тушаал)

2023.12.05
(огноо)

# ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2023.12.04 Дархан-Уул

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гүйцэтгэлийн тавьсан зорилт шалгуур үзүүлэлтийг хүрэх түвшинтэй нь харьцуулан хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хариуцлагыг сайжруулах, санал, зөвлөмж гаргах, байгууллагын удирдлагыг болон харьяа дээд байгууллагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах зорилготой.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үндэслэл**

Хяналт- шинжилгээ үнэлгээг хийхдээ Монгол улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоол, 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох тайлан гаргах журам” -ын 4.2 дэх хэсэгт заасны дагуу тус газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний **жилийн эцсийн** тайланг үндэслэл болгон хяналт-шинжилгээ үнэлгээ хийж **гүйцэтгэв.**

**Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын үр дүн**

2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 14 зорилтын хүрээнд 78 арга хэмжээг тоо хэмжээ, чанарын шалгуур үзүүлэлтээр гарган тайлагнахаар үйл ажиллагаагаа зохион байгуулж ажилласан байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөнд тусгасан зорилт, арга хэмжээг тоо хэмжээ болон чанарын шалгуур үзүүлэлтээр бүрэн хэрэгжүүлж тайлагнасан байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтийн үнэлгээ:

1. 100 хувийн буюу “Үр дүнтэй” – 76
2. 90 хувийн буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” – 2 арга хэмжээ байна.

2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт **99,74 хувь буюу “Үр дүнтэй”** гэж үнэлэгдлээ.

**Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээг зорилт тус бүрээр харуулвал:**

| | Дэвшүүлсэн зорилтууд | Арга хэмжээ-ний тоо | Зорилтын хэрэгжилт ( хувиар ) | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Үр дүнтэй (100%) | Тодорхой үр дүнд хүрсэн (70-99%) | Эрчим-жүүлэх шаард-лагатай (31-69%) | Үр дүнгүй (0-30%) |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Соёлын салбарын бодлого, хөгжлийн хэтийн чиглэлийг судалгаа шинжилгээнд тулгуурлан тодорхойлж, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно | 2 | 100 | | | |
| 2 | Соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах | 8 | | 98,75 | | |
| 3 | Соёлын биет бус өвийг өвлөн сурталчлах, төсөл хөтөлбөрийг дэмжин ажиллана. | 3 | 100 | | | |
| 4 | Музейн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 3 | 100 | | | |
| 5 | Утга зохиол, ном хэвлэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна. | 6 | 100 | | | |
| 6 | Урлагийн тоглолт, үзвэр үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 4 | 100 | | | |
| 7 | Сумдын соёлын төвийн үзвэр үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна. | 3 | 100 | | | |
| 8 | Аудио, видео, интерактив медиаг дэмжиж цахим орчинг дэлгэрүүлнэ. | 6 | 100 | | | |
| 9 | Дүрслэх урлаг, зураг, дизайн, гар урлал болон соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана. | 3 | 100 | | | |
| 10 | Бүх нийтийн соёлын боловсролын дээшлүүлэх, үндэсний соёлын дархлааг нэмэгдүүлнэ. | 8 | | 98,75 | | |
| 11 | Байгууллагын тайлагнах үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлнэ. | 16 | 100 | | | |
| 12 | Хүний нөөцийн сургалт, нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ. | 6 | 100 | | | |
| 13 | Санхүүгийн удирдлага, төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналтыг чангатгаж, үр дүнг тайлагнах, шилэн | 9 | 100 | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | дансны бүртгэлийн хөтлөлт, үнэн зөв байдлыг хангана. | | | | | |
| 14 | Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын ажлыг сайжруулана. | 1 | 100 | | | |
| | **Нийт: 14 зорилт** | **78** | **Үнэлгээ 99,74** | | | |

## ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж хийхэд:

1. 100 хувийн буюу "Үр дүнтэй" – 76 арга хэмжээ
2. 90 хувийн буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" – 2 арга хэмжээ байна.

**Онцлох ажлуудаас дурдвал:**

➢ МУИС-ийн Улаанбаатар сургуулийн Түүх, археологийн тэнхимийн доктор Т.Идэрхангай ахлагчтай судалгааны анги нь 2023.06.25-наас 2023.07.31-ний өдөр хүртэл хугацаанд хийж гүйцэтгэсэн. "Сяньбигийн үеийн хаад язгууртны бунхант булшны малтлага, судалгаа"-ны ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэхэд шаардлагатай төсвийг Аймгийн ИТХ-ын 2022 оны ээлжит 14 дэх хуралдаанаар хэлэлцүүлж, 70.0 сая төгрөгийг шийдвэрлүүлсэн. Бунхант булшийг малтан судлах ажлыг үргэлжлүүлж язгууртны 2 оршуулга, үүдэнд нь зарц, бараа бологсод байх магадлалтай босоо болон хагас суугаа байдалтай хоёр хүний бүтэн шарил, дал 4 өндөр, дорго, шувуу зэрэг ан амьтад, бод малын тахилга анхны байдлаараа олдсон нь Сяньбичүүдтэй холбоотой Монгол нутгаас илрэн олдоод буй хоёрдох том оршуулгын газар болохоороо түүхэн чухал ач холбогдолтой юм. Энэ жилийн малтлагаар үсний ясан хатгуур 1, төмөр ойл 2, шавар ваар 22 ихэнх нь бүтэн, хүрэл зоос 4, авсны төмөр хадаас 11, хазаарын төмөр зуузай 1, хазаарын төмөр амгай 1, хазаарын төмөр цагираг 4, төмөр арал 4, төмөр жижиг тогоо 1, хүрэл эдлэл 1, эмээлийн төмөр бүүрэг 2, шавар цар жижиг 1 ширхэг буюу нийт 55 олдвор олдсон. Малтлага судалгаанд тулгуурлан дурсгалт газар дээр хээрийн ИЛ МУЗЕЙ байгуулах урьтач нөхцөлийг бүрдүүлэх, эх орны түүхийг ирээдүй хойч үедээ үнэн зөвөөр нь өвлүүлэн үлдээх үндсэн зорилготой юм.

➢ Улаанбаатар хотын Налайх дүүргийн "Тайж хайрхан"-ы бэлд зохион байгуулагдсан "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивальд Дархан-Уул аймаг соёлын биет бус өвийн 5 ай савын 15 өвлөн уламжлагч, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн 11 байгууллагын 100 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, мэргэжлийн урлагийн

байгууллагын 19 уран бүтээлч, бусад оролцогч 19 буюу 58 хүний бүрэлдэхүүнтэйгээр оролцсон. Соёлын өвийн орон зай, бүтээлч үйлдвэрлэл, уламжлал шинэчлэл, баялаг байдал, соёлын биет бус өвийн олон төрөл зүйлийг түгээн дэлгэрүүлэх, илэрхийлэх хэлбэр, язгуур өв соёлоо дээдэлж, зохион байгуулалттай оролцсон амжилтаар "ШИЛДЭГ АЙМАГ"-аар шалгарч, цом батламжаар шагнуулсан.

- Монгол Улсын Засгийн Газраас 2023-2025 оныг Монголд зочлох жил болгон зарлаж энэ хүрээнд "СОЁЛЫН СЭРГЭЛТ-2023" аяныг 9 дүгээр сарын 23-нд "Кинонд ээлтэй хот" уриан дор Манай аймагт киноны орчин бүхий гадаад дотоод жуулчид, аялагчдын сонирхол татахуйц, кино үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг илэрхийлсэн соёлын орон зайг бий болгох санаачлагаар эхлүүллээ. Аймгийн Музейгээс Дархан, Орхон, Хонгор сумдад Дархан хотод зураг авалт нь хийгдсэн киноны 16 ш гэрэл зургийн үзэсгэлэн зохион байгуулж 600 гаруй иргэдэд толилуулла Кино орон зайг "Миний Монгол" цэцэрлэгт хүрээлэнд буюу "Гарын таван хуруу" киноны зураг авалт хийж байсан газарт байгуулахаар тогтож тохижилтийн эскиз төслийг танилцууллаа.
- "СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР" 3 дахь жилдээ 11 дүгээр сарын турш амжилттай зохион байгуулагдаж Соёл, урлагийн газрын нэгдсэн төлөвлөгөөнд харьяа 7 байгууллагаас 123 арга хэмжээ хийхээр тусгагдаж 195 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулагдаж аймгийн хэмжээнд 88738 иргэдийг хамруулсан байна.
- Бүтээлч сарын хүрээнд Соёлын яамнаас хэрэгжүүлсэн 16-18 насныханд зориулсан Соёлын эрхийн бичигт ЕБС-ийн 1374 сурагч хамрагдаж соёл, урлагийн байгууллагуудын соёлын хөтөлбөр, үйлчилгээнд амжилттай хамрагдлаа. Тайлант хугацаанд дээрх онцлох ажлуудаас гадна бүх нийтийн соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой соёлын олон талт үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж ажилласан.

2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 30-70 хувийн буюу "Эрчимжүүлэх шаардлагатай" 6 арга хэмжээг байгууллагын удирдлагуудад танилцуулан санал дүгнэлт гарган ажилласан.

2023 оны сүүлийн хагас жилийн байдлаар эдгээр арга хэмжээг эрчимжүүлэн ажиллаж 90-100 хувьд буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлэгдэж байна.

Тайланд тусгагдсан 78 арга хэмжээнээс 90 хувийн буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" – 2 арга хэмжээ байна. Үүнд:

1.2.7. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийж, тайлагнана. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны жилийн эцсийн байдлаар улсын тооллогын

бэлтгэл ажлын хүрээнд Соёлын Сайдын А/401 тоот тушаалын хавсралт удирдамжийн дагуу аймгийн Музейд шинээр авсан 33 дэс, Хонгор сумын 24 дэс, Орхон сумын 7 дэсийн үзмэр тус бүрд хувийн дугаар өгөн, гэрэл зургийн хамт бүртгэн баримтжуулж RCH программд шивж оруулав гэж тайлагнасан байна. 2024 онд аймгийн Музейн бүртгэл мэдээллийн санд бүртгэлтэй 1031 дэсийн 1449 үзмэрийг бүрэн тооллогод хамруулна.

3.3.1. Музей, Номын сангийн цогцолборын барилга угсралтын ажлын явцыг эрчимжүүлнэ. .Музей, номын сангийн цогцолбор барилгын ажлын талаар Соёлын яамнаас барилгын захиалагч, гүйцэтгэгч талуудыг байлцуулан 2 удаа цахимаар хуралдаж, удирдах дээд байгууллагаас томилогдсон ажлын хэсэг барилгын явцтай газар дээр нь 3 удаа ирж танилцан үүрэг чиглэл өгч ажилласан. Музей, Номын сангийн цогцолбор барилгын ажлын нийт төсөвт өртөгт шаардлагатай **15,6** тэрбум төгрөгийн санхүүжилтээс тус онд **5,920.0** сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн ба уг төслийн гүйцэтгэгчээр Воком констракшн ХХК ажиллаж, барилгын гүйцэтгэлийн ажлын явц **90** хувьтай явагдаж байна. 2024 онд тус барилгын ажлын явцад хяналт тавин эрчимжүүлэх шаардлагатай байна.

ТАНИЛЦСАН:
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА Х.СОЁЛ-ЭРДЭНЭ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, СТАТИСТИК МЭДЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ш.ДЭЛГЭРМАА

## ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

## НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

### 1.1. Ерөнхий мэдээлэл:

➢ "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг "Монголд зочлох жил", Дархан-Уул аймаг 2023 оныг хүүхэд хамгааллын жил болгон зарласантай уялдуулан тус газар нь 2023 онд **14** зорилтын хүрээнд **77** арга хэмжээг хэрэгжүүлэхээр ажиллалаа.

➢ Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайдын 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/04 тоот тушаалаар тус газар нь Захиргаа, удирдлагын хэлтэс, Соёл, урлагийн хэлтэс гэсэн **2** нэгжтэйгээр, бүтэц, орон тооны хувьд **11** ажилтан, албан хаагч ажиллахаас удирдах албан тушаалтан **1**, төрийн захиргааны **6,** төрийн үйлчилгээний **2** буюу нийт **9** орон тоотойгоор үйл ажиллагаагаа явууллаа.

➢ Эрсдэлийн удирдлагын стратегийг хэрэгжүүлэх хүрээнд МУЗГ-ын 2023 оны 79 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Салбарын хяналт шалгалтын 2023 оны төлөвлөгөө"-нд тусгагдсаны дагуу Соёлын яамны Салбарын хяналтын газраас **4** хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Дархан-Уул аймагт ажиллаж, соёлын салбарын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах **4** шалгуур үзүүлэлт, **8** хяналтын хуудасны хэлэлцүүлгийг зохион байгуулж, соёл, урлагийн байгууллагуудад эрсдэлийн үнэлгээ хийж, мэдээлэл цуглуулж, тандалт судалгаа хийж гүйцэтгэсэн. Шилэн хяналтын цахим системийг ашиглан **4** шалгуур үзүүлэлтээр **90** объектод эрсдэлийн үнэлгээ хийхэд **6** буюу **6.7%** нь бага, **46** буюу **51.1%** нь дунд, **38** буюу **42.2%** нь их эрсдэлтэй үнэлэгдсэн. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй **32** караоке, **1** эвент танхим, 1 кинотеатр, **8** сүм хийд, ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн нийт **44** номын сан, Залуучууд театр, Музей, Төв номын сан, Хүүхдийн номын ордоны үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийж, **13** объектыг тандалт судалгаанд хамруулсан.

➢ Тайлант хугацаанд **9** албан хаагч **2250** хүн/өдөр ажиллахаас **2151** хүн/өдөр ажилласан. Үүнээс **5** албан хаагч **99** хүн/өдөр ээлжийн амралт эдэлжээ.

### 1.2. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

➢ Соёлын салбарын дунд хугацааны стратеги төлөвлөгөөний хүрээнд боловсруулагдсан 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр төсвийн ерөнхийлөн захирагчаар хянуулж, газрын дарга 2 нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг, нэгжийн дарга 5 захиргааны албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус хянаж, үйлчилгээний 2 албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллалаа.

➢ Тайлант хугацаанд газрын дарга **46** тушаал гаргасан ба шийдвэрийн биелэлт бүрэн хэрэгжсэн. Үүнээс **25** нь хүний нөөцийн асуудлаар, **21** нь үндсэн үйл ажиллагааны асуудлаар гаргасан.

➢ Газрын өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй, байнгын удирдлагаар хангах зорилгоор газрын шуурхай хуралдааныг нийтдээ **24** удаа зохион байгуулж, эдгээрээс өгөгдсөн **80** үүрэг даалгаврыг бүрэн биелүүлжээ.

➢ Харъяа соёлын байгууллагын удирдлагуудтай танхимаар **11** удаа, цахимаар **8** удаа хуралдаж, **60** үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг бүрэн хангуулсан.

➢ Соёлын яам болон ЗГХАСУГ-аас зохион байгуулсан **28** удаагийн цахим хуралд оролцож, Дархан-Уул аймгийн хэмжээнд соёлын салбарт авч хэрэгжүүлсэн онцлох ажлуудын талаар 1 удаа мэдээлэл хийн ажлаа танилцуулж, эдгээрээс өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг бүрэн хангуулж тухай бүр нь тайлагнасан.

➢ Аймгийн хэлтэс, агентлагийн дарга нарын хуралд **11** удаа, аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийн зөвлөгөөнд **1** удаа оролцож, соёлын салбарт хийж хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг танилцуулсан.

➢ Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайдын "Шил ажиллагааг эрчимжүүлэх тухай" 2023 оны А/05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг бүрэн хангуулж, 7 хоног бүр цахимаар тайлагнасан.

➢ **"ШҮҮР АЖИЛЛАГАА"**-ны хүрээнд аймгийн ЗДТГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг тус газарт /2023.03.28/ ажиллаж, даргын гаргасан тушаал шийдвэр, албан хаагчдын хувийн хэрэг, албан тушаалын тодорхойлолт, боловсролын диплом зэрэг бусад шаардлагатай бичиг баримтуудтай танилцав.

➢ "Авлигатай тэмцэх таван ажиллагаа"-ны нэг арга хэмжээ болох "ШҮГЭЛ АЖИЛЛАГАА"-ны хүрээнд 2023.05.29-ны өдрөөс эхлэн орон даяар зарласан **"НЭГДЬЕ"** аянд аймгийн Соёл, урлагийн газар, соёлын байгууллагууд нэгдлээ.

➢ Соёлын сайдын албан даалгаврын өөрт хамаарах 3 заалтын хэрэгжилтийг 94%-иар хангуулж, цахимаар тайлагнасан.

➢ Аймгийн Засаг даргын 2023 онд гаргасан **7** захирамж, **1** албан даалгавар, Дархан сумын Засаг даргын **1** албан даалгавраас өөрт хамааралтай заалтын хэрэгжилтийг хангуулж тухай бүр нь тайлагнасан.

➢ Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны "Эрүүл аюулгүй-Цэвэр орчин бүрдүүлэх арга хэмжээний тухай" 02, 03 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангуулж, биелэлтийг **4** удаа гаргаж цахимаар тайлагнасан.

➢ Тус газрын дэргэдэх орон тооны бус баримт нягтлан шалгах комиссыг 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж байгууллагын архивын баримтын үнэ цэнийг нягтлан шалгах, баримт бичгийн хадгалах хугацааг тодорхойлох, төрийн архивт шилжүүлэх баримтыг сонгох, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг хянан хэлэлцэх, байнга болон түр хадгалах баримт бичгийн данс бүртгэл, устгах баримтын жагсаалтыг хянан хэлэлцэх, баримт бичгийн хөтлөлт, бүрдүүлэлтэд үзлэг шалгалт хийх, дотоод ажил, архив, албан хэрэг хөтлөлтийг стандартын дагуу зөв зохион байгуулж байгаа байдалд хяналт тавих, мөрдүүлж ажиллахыг үүрэг болгосон.

➢ МУЗГ-ын 2023 оны 185 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам"-ыг соёлын 7 байгууллагад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар соёлын 7 байгууллагын 79 соёлын ажилтанд 366,684,226 төгрөгийн мөнгөн урамшуулал олгогджээ.

➢ Аймгийн ЗДТГ, ТАЗ-ийн Дархан-Уул аймаг дахь Салбар зөвлөлөөс зохион байгуулсан **"Эрүүл чийрэг, мэдлэг, ур чадвартай төрийн албан хаагч"** төслийн **спорт, урлаг, мэдлэг ур чадварын тэмцээн**үүдийн нийлбэр дүнгээр СУГ, БТСГ, БШУГ, ДДТ ОНӨААТҮГ-ын хамтарсан баг **"Гутгаар" байранд шалгарч Өргөмжлөл, 10.000.000** төгрөгийн төсөл хэрэгжүүлэх эрхийн бичгээр шагнууллаа.

➢ Аймгийн соёлын салбарын удирдлага, хүний нөөц, нягтлан бодогч нартай ажил хэргийн уулзалт хийж, 2022 оны санхүүгийн тайлан, 2023 оны 1 дүгээр улирлын статистик, урлаг, уран бүтээл, цахим системүүдийн хэрэглээ, цаашид анхаарах асуудлаар мэдээлэл хүргэв.

➢ Дархан-Уул аймагт 2023 оны 06 дугаар сард зохион байгуулагдсан **Команд штаб**ын сургууль болон **Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуульд** аймгийн Соёл, урлагийн газар, Соёлын байгууллагууд тус тусын чиг үүргийнхээ дагуу оролцлоо. Соёл, урлагийн газар аймгийн Онцгой комисст болон дадлага сургуулийн үеэр Ар тал, хангалтын багийн гишүүнээр томилогдож, Соёлын төвүүд Сумдын Онцгой комисст болон Нүүлгэн шилжүүлэлтийн ажилд дайчлагдаж, Залуучууд театрын уран бүтээлчид мэргэжлийн ангийн тактикийн үзүүлэх сургуульд дууриалган үзүүлэх, газар хөдлөлтийн аюулын үед хүн амыг

аюулгүй газарт нүүлгэн шилжүүлэх дадлага сургуульд урлаг, соёлын үйлчилгээгээр тус тус хамтран ажиллалаа.

➢ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй Музей, номын сангийн цогцолбор барилгын ажлын талаар Соёлын яамнаас барилгын захиалагч, гүйцэтгэгч талуудыг байлцуулан 4 удаа цахимаар хуралдаж, удирдах дээд байгууллагаас томилогдсон ажлын хэсэг барилгын явцтай газар дээр нь 8 удаа ирж танилцан үүрэг чиглэл өгч ажилласан. Соёлын сэргэлт аяны үеэр Соёлын сайд Дархан-Уул аймагт ажиллах хугацаандаа 5900 гаруй м.кв талбай бүхий 3 давхар цогцолборын барилга угсралтын ажил, барилгын явцтай танилцсан.

➢ Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг ханган ёс зүйн зөрчилгүй ажиллалаа.

**1.3. <u>Хүний нөөцийн үйл ажиллагааны талаар:</u>**

➢ Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журмыг үндэслэн:

-Төрийн захиргааны албан тушаалд **3**, төрийн үйлчилгээний албан тушаалд **3** хүнийг томилсон.

-Туршилтын хугацаатай томилогдсон төрийн захиргааны **3** албан тушаалтан эрдэм мэдлэг, ур чадвараа дайчлан, ажлын гүйцэтгэлээр хангалттай үнэлгээ авч, ёс зүйн хэм хэмжээг чанд сахин ажилласан тул жинхлэн томилсон.

-Сул гарсан орон тоог нөхөгдөх хүртэл хугацаанд төрийн захиргааны **3** албан тушаалтны зөвшөөрлийг авсны үндсэн дээр түр орлон гүйцэтгүүлэх, төрийн үйлчилгээний **2** орон тоог хавсран гүйцэтгүүлэх шийдвэрийг тус тус гаргасан. Үүнээс **4** орон тоо нөхөгдсөн тул түр орлон болон хавсран гүйцэтгэх хугацааг тушаалаар дуусгавар болгосон.

- Өөрийн санаачилгаар төрийн албанаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан **4**, шатлан дэвших зарчмаар төрийн захиргааны албан тушаалын сул гарсан орон тоонд төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт өгч тэнцэж нэр дэвшсэн **1** албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх шийдвэрийг гаргасан.

➢ Тус газарт сул гарсан **5** орон тоог Төрийн албаны тухай хуульд заасны дагуу Дархан-Уул аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд албан бичгээр мэдэгдэж, зарлуулах арга хэмжээг авсны үр дүнд **3** орон тоо */Төсөв, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Соёл, гэгээрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн/* нөхөгдсөн.

➢ Тайлант хугацаанд нийтийн албан тушаалд нэр дэвших хүсэлт гаргасан **4** хүний ХАСУМ-ийг АТГ-аар хянуулж зөрчилгүй гэх дүгнэлт авч, цахимд мэдээллийг оруулсан. Шинээр томилогдсон **2** албан хаагчийн ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд нь хянан цаасаар бүртгэж, цахим бүртгэлд баталгаажуулсан.

➢ ТАЗ-өөс томилогдсон ажлын хэсэг Дархан-Уул аймагт ажилласан. 2023.06.18-ны өдөр тус газрын “Хүний нөөцийн мэдээллийн удирдлагын тогтолцоо” цахим систем дэх мэдээллийн бүрдүүлэлт, хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаанд хяналт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсний дагуу төрийн захиргааны **5** албан хаагчийн ажилд томилогдсон шийдвэрийг төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт өгч тэнцсэн материалыг ТАЗ болон аймгийн ТАЗСЗ-ийн тогтоолын хамт нэг файл болгон хавсаргаж хүний нөөцийн мэдээллийн цахим системд мэдээллийг шинэчлэн байршуулж, төрийн албан хаагчийн үндсэн мэдээллийн боловсрол хэсэгт **1** албан хаагчийн боловсролын голч дүн, дипломын дугаарыг дахин оруулж баталгаажуулсан. Цаашид цахим системийн мэдээллийн хадгалалтыг сайжруулах, цэсүүдэд файл хавсаргах боломжийг бүрдүүлэх саналыг өгсөн.

➢ Жил бүрийн дөрөвдүгээр сард зохион байгуулдаг сайн үйлсийн үзэл санааг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготой “Сайн үйлсийн өдөр”-ийг тэмдэглэн **“НЭГ**

**БАЙГУУЛЛАГА- НЭГ САЙН ҮЙЛ"** аянд тус газрын албан хаагчид нэгдэж, **ЦУСАА** бэлэглэлээ.

**1.4. <u>Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны асуудлыг шийдвэрлэх чиглэлээр:</u>**

➢ Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайд болон Дархан-Уул аймгийн Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээний 4.6-д заасны дагуу аймгийн удирдлагаас Дархан сумын 11 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах Багш хөгжлийн төвийн 1 дүгээр давхрын зүүн жигүүрт /171.6 м.кв талбай/ байрлан үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлж, ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлсэн.

➢ Ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд "Хүний нөөцийн чадавхийг сайжруулах, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах" чиглэлээр 2023 онд **13** заалт бүхий хавсралт төлөвлөгөөний хэрэгжилтийг **93%**-иар хангуулсан.

➢ Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журамд өөрчлөлт орсны дагуу **7** албан хаагчид төрийн албан хаасан хугацааны нэмэгдлийг нэмэгдүүлэн олгосон.

➢ МУЗГ-ын 2022 оны 489 дүгээр тогтоолоор орон нутагт ажилласны нэмэгдлийг төрийн захиргааны албан тушаал эрхэлдэг **7** албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн **20** хувиар бодож 2023.01.01-нээс сар бүр олгож эхэлсэн.

➢ МУЗГ-ын 2022 оны 489 дүгээр тогтоолоор Дархан-Уул аймгийн ИТХ-ын 2023 оны 43 дугаар тогтоолоор орон нутагт ажилласны нэмэгдлийг төрийн захиргааны албан тушаал эрхэлдэг **7** албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн **40** хувиар бодож 2023.07.01-нээс сар бүр олгож эхэлсэн.

➢ Төрийн албаны тухай хууль, Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журамд заасны дагуу **1** албан хаагчид зэрэг дэв шинээр олгуулж, журмын шаардлага хангасан **1** албан хаагчид зэрэг дэв шинээр олгуулах саналыг Дархан-Уул аймаг дахь ТАЗСЗ-д хүргүүлсэн.

➢ Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу тус газрын **8** албан хаагчийн ээлжийн амралтыг хуваарийн дагуу эдлүүлсэн.

➢ Ажил хөдөлмөрөөрөө бусдыгаа манлайлан ажилласан **3** албан хаагчийг салбарын шагналд тодорхойлсноос **2** албан хаагч салбарын шагналаар шагнагдсан.

➢ Соёлын салбарын бодлого, зорилтыг хэрэгжүүлэх, соёл, урлагийн салбарын хөгжилд оруулж буй тодорхой хувь нэмрийг нь үнэлэн нэр бүхий **48** хүнийг төрийн дээд одон медальд, **89** хүнийг салбарын шагналд, **51** хүнийг аймаг, орон нутгийн шагналд тодорхойлон уламжилснаас **1** хүн "Соёлын гавьяат зүтгэлтэн" цол тэмдгээр, **3** хүн "Алтан гадас" одонгоор, **6** хүн "Хөдөлмөрийн хүндэт медаль"-иар, **32** хүн "Ардын хувьсгалын 100" жилийн ойн хүндэт тэмдгээр, 31 хүн салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдгээр, **13** хүн ардын авъяастан хүндэт тэмдгээр, **12** хүн жуух бичгээр, аймгийн Засаг даргын шагналаар **51** хүн шагнагдсан.

**1.5. <u>Хүний нөөцийг чадавхижуулах, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх чиглэлээр:</u>**

➢ Тус газраас төрийн албан хаагчийг чадавхижуулах чиглэлээр **13** заалт бүхий сургалтын төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг **94%**-иар хангууллаа.

➢ Богино хугацааны сургалтаар **9** албан хаагч давхардсан тоогоор **29** удаагийн танхимын сургалтад, давхардсан тоогоор **96** удаагийн цахим сургалтад хамрагдаж, мэдлэг ур чадвараа дээшлүүлж, **20** сертификат, гэрчилгээ авсан байна.

➢ Төрийн албаны тухай хуульд заасны дагуу мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах ажилтны судалгаа гаргаж, саналаа Дархан-Уул аймаг дахь ТАЗСЗ-д өгч, **2** квот авсан. Тус газрын **1** мэргэжилтэн хамрагдаж сертификатаа гардан авсан, **1** ахлах мэргэжилтэн төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад хамрагдаж байна.

➢ Харъяа соёлын **7** байгууллагын статистик мэдээ хариуцсан албан тушаалтнуудад Соёлын тухай хууль, Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг сурталчлан таниулж, соёлын салбарын статистик мэдээг нэгтгэх арга зүйгээр хангаж, тодорхой мэдлэг, мэдээлэл олгож ажилласан.

➢ ЗГХАСУГ-тай хамтран аймгийн СУГ, Залуучууд театр, Музей, Төв номын сан, Шарын гол, Орхон, Хонгор сумын Соёлын төвийн статистик мэдээ гаргадаг албан хаагчдад статистикийн маягт ашиглах, хөтлөх зааварчилгаа сургалтыг танхимаар зохион байгуулсан.

➢ Орхон, Хонгор сумын Соёлын төвийн статистик мэдээ гаргадаг **4** албан хаагчдад статистикийн маягт ашиглах, хөтлөх зааварчилгаа сургалтыг газар дээр нь зохион байгуулж холбогдох хууль тогтоомжийг сурталчлан мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан.

➢ **Гамшиг эрсдлээс урьдчилан сэргийлэх хамгаалах чиглэлээр** аймгийн Соёл, урлагийн газрын албан хаагчид сургалтад хамрагдлаа. Тус сургалтыг аймгийн Онцгой байдлын газраас албан хаагч мэдээлэл хийж байгууллагын бэлэн байдлын аранз, хэрэгсэлтэй танилцаж заавар зөвлөмж өглөө.

➢ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмыг соёлын **7** байгууллагын бичиг хэрэг хариуцсан албан тушаалтанд сурталчилж, мэргэжил арга зүйгээр хангасан.

➢ ДУА дахь ТАЗСЗ-тэй хамтран соёлын 7 байгууллагын хүний нөөцтэй холбоотой шийдвэр, баримт бичигт үзлэг хийж, цахим системд нэвтрэн хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, дүнг танилцуулахын зэрэгцээ удирдлага болон нэгжийн дарга, нягтлан бодогч, хүний нөөц, бичиг хэргийн ажилтнуудад Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-ын талаар сургалт зохион байгуулсан.

➢ Шинэчлэн батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал, Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний загвар, гүйцэтгэлийн тайлан, үнэлэх аргачлал"-ыг судлан хэрэгжилтийг хангуулж байна.

➢ Оюуны өмчийн тухай хуулиар зохион байгуулсан цахим сургалтад соёлын **8** байгууллагын удирдлагууд хамруулж, орон нутагт оюуны өмчийн эрхээр хамгаалагдах бүтээл, оюуны өмчийг хамгаалах зарчим, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах, дэмжих талаар ойлголт өгөв.

**1.6. <u>Эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр:</u>**

Тайлант хугацаанд **5** удаагийн хэлэлцүүлэгт оролцож, **4** хуулийн шинэчилсэн найруулга, **1** журмын төсөлтэй танилцаж, мөрдөгдөж буй **1** журамд нэмэлт өөрчлөлт оруулах саналаа тус тус өгсөн. Үүнд:

➢ Газрын багц хуулийн төсөл болон ГЗЗТХ, ХБТХ-ийн шинэчилсэн найруулгын төслийг танилцуулах нээлттэй хэлэлцүүлэгт оролцож саналаа өгсөн.

➢ Төрийн албан хаагчдын цалин хөлсний талаарх нээлттэй хэлэлцүүлэгт оролцож санал өгсөн.

➢ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцож санал өгсөн.

➢ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хэлэлцүүлэгт оролцож, цаасаар болон цахим санал асуулгад хамрагдан саналаа өгсөн.

➢ Соёлын сайдын 2023 оны А/56 дугаар тушаалаар баталсан "Хяналт шалгалтын баримт бичигт нэгдсэн дугаар олгох заавар, Хяналт шалгалтын баримт бичигт нэгдсэн дугаар олгох бүртгэлийн дэвтрийг загварын дагуу хэвлэж, ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн.

➢ Соёлын байгууллагын соёлын ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журмын төсөлд санал өгсөн.

➢ "Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний харьяа байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ын төсөлд санал өгсөн.

➢ Нийгмийн даатгалын тухай багц хуулийн хэлэлцүүлэгт оролцож санал өгсөн.

**1.7. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр:**

➢ Тус газрын дарга 2023 оны 10 дугаар сарын 04-13-ны өдрүүдэд Соёлын яам, Монголын үндэсний кино урлагийн зөвлөл, кино уран бүтээлчдийн бүрэлдэхүүнд багтан БНСУ-ын Бусан хотноо зохион байгуулагдсан **28** дахь удаагийн Бусаны олон улсын кино наадамд оролцлоо. Энэхүү олон улсын тэргүүлэх зэрэглэлийн кино наадамд Монгол Улсын кино урлагийн салбарын эрх зүйн орчин, Кино урлагийн зөвлөлийн үйл ажиллагаа, шинэ кино уран бүтээлийг сурталчлах зорилготой байв.

➢ Тус газрын дарга аймгийн ЗДТГ, Европын холбооны санхүүжилттэй хамтран хэрэгжүүлдэг "Найрамдал төсөл"-ийн хүрээнд нийгмийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, тэргүүн туршлага солилцох болон туршлага судлах зорилгоор 2023 оны 11 дүгээр сарын 20-25-ны өдрүүдэд Монтенегро улсын Бар хот болон Словени улсад ажиллах багийн бүрэлдэхүүнд томилогдон ажиллав.

➢ Дарханд кино үйлдвэрлэлийг дэмжих, соёлын бүтээлч үйлдвэрлэлээр дамжуулан соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр аймгийн Засаг дарга болон МҮКУЗ-ийн дарга нар хамтран ажиллах "Санамж бичиг"-т 2023 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр гарын үсэг зурж, Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнд кино орон зай буюу "Кино гудамж" байгууллаа.

➢ Соёлын Яам, МҮКУЗ-ийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан Кино урлагийн салбарын уран бүтээлчдийг чадавхжуулах "Кино нүүдэл" олон улсын сургалтад тус аймгаас 5 уран бүтээлчийг хамруулаа.

➢ Тус аймагт хийгдсэн 31 кино зураг авалт, 20 уран бүтээлч, жүжигчин, 5 найруулагч, кино зураг авах 26 газар, 39 дурсгалт газар, Дарханд кино урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 3 байгууллага, 1 кино театрын судалгааг нэгтгэж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

➢ Гэгээн хайрын баярын өдрийг тохиолдуулан аймгийн ГБХЗХГ,УБХ, СУГ хамтран 4 залуу хосуудад "ГЭРЛЭСНИЙ ГЭРЧИЛГЭЭГ НЬ ГАРДУУЛАХ ЁСЛОЛ"-ыг Гэрлэх ёслолын өргөөнд зохион байгуулж, хосуудад нандин дурсамж үлдээлээ.

➢ Монгол Улсын Дархан-Уул аймаг, БНСУ-ын Кёнги аймгийн хооронд найрамдалт харилцааг бататгах санамж бичгийг 2023 оны 07 дугаар сарын 08-ны өдөр шинэчлэн үйлдсэн. Энэхүү санамж бичгийн хүрээнд Дархан-Уул аймгаа сурталчлах зорилгоор мэргэжлийн урлагийн байгууллагын урлагийн тоглолтыг сонирхуулах хүсэлтэй байгаагаа аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ээр дамжуулан бичгээр илэрхийлж, талархлын хамт хүргүүлсэн.

**1.8. Хяналт, шинжилгээ, үнэлгээний талаар:**

➢ Соёл, урлагийн газар нь 2023 онд байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 14 зорилтын хүрээнд 78 арга хэмжээг тоо хэмжээ, чанарын шалгуур үзүүлэлтээр гарган 99.74 хувьтай буюу "Үр дүнд хүрсэн" үзүүлэлттэй үнэлэгдлээ. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн ажлын биелэлтийн үнэлгээ:

- 100 хувийн буюу "Үр дүнтэй" - 76 арга хэмжээ
- 90 хувийн буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" – 2 арга хэмжээ

➢ 2023 оны жилийн эцсийн байдлаар 4 бодлогын баримт бичгийн 16 заалтын хэрэгжилтийг дунджаар 97.9 хувиар хангуулсан.

➢ Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийн тайланд: Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын 9 шалгуур үзүүлэлтээр тайлан хийж Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын төрийн захиргаа удирдлагын хэлтэст хүргүүлсэн.

➢ МУЗГ-ын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний өөрт хамаарах 2 заалтын хэрэгжилтийг дунджаар бүрэн хангуулсан.

➢ Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний өөрт хамаарах **6** заалтын хэрэгжилтийг дунджаар **91.5%**-иар хангуулсан.

➢ Аймгийн ЗДТГ-ын НБХ-ээс ирүүлсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт гаргах жагсаалтаас өөрт хамаарах **2** заалтын хэрэгжилтийг бүрэн хангуулж, сар бүр нийтдээ **11** удаа аймгийн ЗДТГ-ын НБХ-т тайлагнасан.

➢ Соёлын яамнаас ирүүлсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт гаргах жагсаалтаас өөрт хамаарах **3** заалтын хэрэгжилтийг бүрэн хангуулж, нэгтгэлийг цахимаар илгээж тайлагнасан.

➢ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын өөрт хамаарах 3 заалтын хэрэгжилтийг бүрэн хангуулж тайлагнасан.

**1.9. <u>Дотоод хяналтын чиглэлээр:</u>**

➢ Тус газрын 2023 оны үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах 5 заалттай төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангуулсан.

➢ Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, байгууллагын архивын ажлын үндсэн зааврыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангаж байгаа эсэх, архивын баримтын нөхөн бүрдүүлэлт, тоо бүртгэл хийх, хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, албан хэрэг хөтлөлтийг эмх цэгцтэй, албан ёсны бүрдлийн дагуу баталгаажуулсан эсэхэд дотоод хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт дунджаар **91%**-тай байсныг гүйцэтгэлийн хяналтаар **95%**-д хүргэсэн.

➢ ЗГХА СУГ-ын цахим шуурхай хурлаар Соёлын яамны СХОГ-аас өгсөн үүрэг чиглэлийн дагуу харьяа соёлын байгууллагын бүтэц, орон тоог баталсан, цалин хөлсийг шинэчлэн тогтоосон шийдвэрийг хянан үзэж, үнэлэлт дүгнэлт өгөхийн зэрэгцээ мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж, дотоод хяналтыг сайжруулах зорилгоор хяналт хийсэн. Соёлын **7** байгууллагын удирдлага, нягтлан бодогч, нарийн бичгийн ажилтан, архивын эрхлэгч зэрэг **17** албан тушаалтнаас тодруулга авч, зөвлөгөө өгч ажилласан.

➢ Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ, СУГ-ын дарга нарын хамтран баталсан "Зөвлөн туслах ажлын удирдамж"-ийн дагуу ТАЗ-ийн 2019 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-ын хэрэгжилттэй танилцах, хүний нөөцтэй холбоотой шийдвэр, баримт бичигт үзлэг хийж, цахим системд нэвтрэн хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах чиг үүргийг ДУА дахь ТАЗСЗ-тэй хамтран хэрэгжүүлсэн. Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Төсвийн тухай, Соёлын тухай, Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам, Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам, Хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх, хадгалах журам, Албан хэрэг хөтлөлтийн стандартын хэрэгжилтийг бүрэн хангуулах, дотоод хяналтыг сайжруулах нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрсэн.

**1.10. <u>Байгууллагын ил тод байдлын талаар</u>:**

➢ Соёлын сайдын "Шил" ажиллагааг эрчимжүүлэх тухай 2023 оны А/05 дугаар албан даалгаврын хүрээнд "Нийтийн мэдээллийн ил толд байдлын тухай хууль"-ийн 8.2-8.5 дахь заалтын 98 мэдээллээс **46** заалтын мэдээллийг https://da.moc.gov.mn/ цахим хуудсанд нийт **531** мэдээлэл нийтэлсэн.

➢ Ил тод байршуулсан мэдээллийг 7 хоног бүр шинэчлэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, салбарын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан, систем http://moc.igovernment.mn/home/-д оруулж, Соёлын яам болон ЗГХА СУГ-т тухай бүр нь

илгээж тайлагнасан. Мөн ЦХХХЯ, аймгийн ЗДТГ зэрэг холбогдох байгууллагуудад **10** удаа бичгээр болон цахимаар илгээж тайлагнасан.

- "Цахим соёл" хөтөлбөрийн хүрээнд https://da.moc.gov.mn/ цахим хуудаснаас гадна тус газрын сошиал цахим хуудсанд https://www.facebook.com/darkhan.gov /**19000** лайкс, **23000** дагагч/ https://www.facebook.com/profile.php?id=100091754469705 /**762** лайкс, **1600** дагагч/ 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар нийтдээ **5000** гаруй мэдээг нийтэлж, олон нийтэд сурталчилж ажилласан.
- Тус газрын үйл ажиллагааны хүрээнд **3** удаа хэвлэлийн бага хурал, **5** удаагийн нэвтрүүлэг, нийт **110** гаруй фото мэдээ, **60** гаруй видео мэдээг Монцамэ агентлаг, орон нутгийн DBS, RGB, Цэц.мн, аймгийн ЗДТГ-ын Мэдээлэл технологийн алба, Дархан сумын ЗДТГ-ын хэвлэл мэдээллийн алба зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран олон нийтэд түгээсэн. Мөн соёлын салбарын үйл ажиллагааны талаарх **13** мэдээг МҮОНРТ-ээр иргэд олон нийтэд хүргэж сурталчилсан.
- Тус газрын төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний сул орон тооны зар мэдээллийг байгууллагын https://da.moc.gov.mn/ цахим хуудас болон сошиал хуудас, ТАЗ-ийн https://hh.csc.gov.mn/, Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын https://darkhan.gov.mn/, ТАЗСЗ-ийн сошиал цахим хуудсаар тухай бүр нь нийтэлсэн.
- Соёлын байгууллагуудад Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай албан бичгийг хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.
- "Цахим Дархан" төслийн хүрээнд нэвтрүүлсэн https://e-darkhan.mn/ өргөдөл, гомдлын нэгдсэн системд бүртгүүлж, тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг нийтэлсэн. Өнөөдрийн байдлаар дээрх цахим системд иргэдээс соёлын байгууллагатай холбоотой санал, гомдол ирээгүй болно.

**1.11. <u>Мэдээллийн технологийн чиглэлээр</u>**

- Тус газрын албан хаагчдын албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа суурин **9** компьютер, принтерийн программ хангамж, техник үзлэгийг тухай бүр хийж нийт 100 гаруй удаагийн үйлчилгээг хийлээ.
- Ажлын байр өөрчлөгдсөнтэй холбогдуулан Univision-ий шилэн кабель татуулж, дотоод сүлжээг аймгийн ЗДТГ-ын Мэдээлэл технологийн албатай хамтран татаж албан хаагчдын интернет сүлжээний асуудлыг шийдвэрлэн хэвийн ажиллагааг хангасан.
- Салбарын болон дотоод үйл ажиллагааны хүрээнд салбарын гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн систем http://plan.igovernment.mn/home/, салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн систем http://moc.igovernment.mn/home/, дотоод удирдлага, албан хэрэг солилцооны ERP систем https://erp.e-mongolia.mn/, аймгийн ЗДТГ-ын https://intranet.gov.mn/index.php, цахим шуудан, албан мэйл хаяг - https://mail.gov.mn/ зэрэг системүүдийг ашиглаж байна.
- ERP систем https://erp.e-mongolia.mn/-д тус газрын дарга, албан хаагчдын мэдээллийг оруулж, өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж хэвшсэн. Тус системээр **189** албан бичгийг хүлээн авч, гадагшаа **214** албан бичгийг цахимаар илгээсэн.
- Аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын нэгдсэн дотоод удирдлагын цогц систем https://intranet.gov.mn/index.php-ээр аймгийн удирдлагаас өгч буй цаг үеийн мэдээ, мэдээллийг авч, цахимаар ажлаа тайлагнан ажиллаж байна.
- Хүний нөөцийн бүртгэл мэдээллийн тогтолцоо цахим систем https://hh.csc.gov.mn/-д хөдөлмөр эрхлэлт, цалин хөлсөнд өөрчлөлт орсон даруй албан хаагчдын мэдээллийг шинэчлэн баяжилт хийж баталгаажуулсан.
- Тус газрын **9** албан хаагч өдөр тутмын үйл ажиллагаандаа албаны имэйл ашиглаж хэвшсэн.

➢ https://shilen.gov.mn/ цахим хуудсанд аймгийн соёлын байгууллагуудын мэдээллийг засварлах, шинээр бүртгүүлэх хүсэлтийг ЦХХХЯ-ны Цахим бодлого хэрэгжүүлэх газрын info@shilen.gov.mn мэйл хаягаар хүргүүлсэн.

**1.12. Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар:**

➢ "Цахим Дархан" төслийн хүрээнд нэвтрүүлсэн https://e-darkhan.mn/ өргөдөл, гомдлын нэгдсэн системд холбогдсон. Тайлант хугацаанд дээрх цахим системд иргэдээс соёлын байгууллагатай холбоотой санал, гомдол ирээгүй болно.

➢ Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын дагуу эрхлэн явуулсан.

➢ Иргэдээс нийтдээ **39** өргөдөл, гомдол ирснээс **32** нь бичгээр, **6** нь 70370011, **1** нь иргэд олон нийттэй харилцах төвийн 1111 утсаар ирсэн болно. Хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэж хариуг өгсөн.

➢ Аж ахуйн нэгж, байгууллагаас **429** албан бичиг хүлээн авч бүртгэлжүүлсэн. Үүнээс **74** нь хариутай бичиг ба **4** нь хугацаа ирүүлэх болоогүй. Шийдвэрлэлт **94.6%**-тай байна.

➢ Гадагшаа бусад байгууллагатай **398** албан бичиг харилцсан. Үүнээс хариутай **36** бичгийн **34** нь хариу ирүүлсэн. Шийдвэрлэлт **94.4%**-тай байна.

➢ 2023 оны I-III улирлын өргөдөл, гомдлын мэдээг аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т хуулийн хугацаанд нь **3** удаа гаргаж тайлагнасан. 2023 оны IY улирлын мэдээ гаргах хугацаа болоогүй хүлээгдэж байна.

➢ Тус газрын Архив-бичиг хэргийн ажилтныг аймгийн Архивын тасгаас зохион байгуулсан танхимын сургалтад хамруулж, мэдлэг ур чадварыг нь дээшлүүлсэн.

**1.13. Санхүүгийн удирдлага, төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаар:**

➢ 2023 оны улсын төсвөөс **245,268,600** төгрөгийн санхүүжилт баталж өгсөн. Үүнээс 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар нийт **219,289,600** төгрөгийн санхүүжилт авч **187,766,807** төгрөгийг зүйл тус бүрээр зориулалтын дагуу зарцуулсан. Төсвийн гүйцэтгэлийг зориулалт, эдийн засгийн ангилал бүрээр харуулвал:

-Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил-**143,800,**817 төгрөг

-Ажил олгогчоос төлөх НДШ-**18,054,020** төгрөг

-Хангамж, бараа материалын зардал-**6,085,990** төгрөг

-Томилолтын зардал-**2,310,000** төгрөг

-Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр-**14,941,050** төгрөг

-Бараа үйлчилгээний бусад зардал-**2,574,930** төгрөг

➢ Төсвийг сар, улирал, жилийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу шаардлагатай худалдан авалтыг хийж, албан хаагчдыг бичиг хэргийн болон аж ахуйн хэрэгцээний материалаар хангаж ажиллах орчинг сайжруулан ажилласан.

➢ 2023 оны батлагдсан төсвийг хэмнэлттэй байхаар тооцоолон зарцуулж ирсэн ба жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр цалин хөлс хэмнэлттэй байгаа нь сул гарсан орон тоо нөхөгдөөгүйтэй холбоотой байна.

➢ Төсвийн гүйцэтгэлийн мэдээг **11** удаа, орлогын төлөвлөгөөний биелэлтийг **11** удаа, бараа материалын тооллогыг **1** удаа зохион байгуулсан. Тооллогоор дутагдаж үрэгдсэн, данс тооцоонд бүртгэлгүй маргаантай хөрөнгө байхгүй, 41 нэр төрлийн 37,5 сая төгрөгийн хөрөнгийг тоолоод байна.

➢ Шилэн дансны тухай хуульд заасны дагуу гүйлгээ хийсэн тухай бүр нийтдээ **163** мэдээллийг цахим санд байршуулж хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан.

➢ Нэг удаагийн тэтгэмжийн зардалд нийт **378,400** төгрөгийн төсөвтэй. Ханиад, томуунаас урьдчилан сэргийлэх зорилгоор ажилчдыг нэг удаагийн дархлаажуулалт буюу витаминжуулалтад хамруулж байна.

➢ Байгууллагын 2022 оны санхүүгийн тайланд аймгийн Аудитын газраар аудит хийлгэж, зөрчилгүй гэх дүгнэлтийг тайлангийн хамт Соёлын яамны СХОГ-т хүргүүлсэн.

**1.14. Төсөв, хөрөнгө оруулалтын талаар:**

Тайлант хугацаанд соёлын салбарт улс, орон нутаг, төсөл хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын ажлуудад хяналт тавьж ажиллалаа. Тус газрын харьяа соёлын **6** байгууллагад нийт **16,649.9** сая төгрөгөөр санхүүжигдэх **9** төсөл хөтөлбөр хэрэгжиж байгаагаас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар **15,6** тэрбум төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтаар **1,049.9** сая төгрөгийн санхүүжилт үзүүлсэн. Үүнд:

➢ Музей, Номын сангийн цогцолбор барилгын ажлын нийт төсөвт өртөгт шаардлагатай **15,6** тэрбум төгрөгийн санхүүжилтээс тус онд **5,920.0** сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн ба уг төслийн гүйцэтгэгчээр Воком констракшн ХХК ажиллаж, барилгын гүйцэтгэлийн эхний үе шатны ажлын явц **85** хувьтай явагдаж байна.

➢ Тус аймгийн Хонгор сумын нутаг, Говил уулын ар бэлд буй Сяньбигийн хаад язгууртны бунхант булшны малтлагын төсөвт орон нутгийн хөгжлийн сангийн **70.0** сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Уг малтлага судалгааны ажлын үр дүнд **49** нэр төрлийн эртний олдворууд илэрсэн.

➢ Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсаны дагуу орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Музейн үзмэр худалдан авах төсөл арга хэмжээнд зориулж **15.0** сая төгрөг, Төв номын сангийн сан хөмрөгийн баяжилтад зориулж **10**.0 сая төгрөг, Хүүхдийн номын ордны номын сангийн сан хөмрөгийн баяжилтад зориулж **10.0** сая төгрөг шийдвэрлэж өгсний дагуу үзмэр болон номын баяжилтыг хийсэн.

➢ Хонгор сумын орон нутгийн хөгжлийн сангаас **20.0** сая төгрөгийн бүжгийн хувцас, **10.0** сая төгрөгийн номын сангийн тоног төхөөрөмж, **10.0** сая төгрөгийн музейн үзмэрийг хадгалах хорго, **20.0** сая төгрөгийн дуу шумны студийн тоног төхөөрөмж худалдан авахад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.

➢ Соёлын 7 байгууллагын 2024 оны дунд хугацааны төсвийн төсөл, 2025-2026 оны төсвийн төсөөллийг Соёлын яамны СХОГ-т цаасаар хүргүүлж, цахимаар илгээсэн.

➢ 2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дархан-Уул аймгийн Хонгор суманд **400** үзэгчийн суудалтай соёлын төв байгуулах, соёлын **8** байгууллагын тоног төхөөрөмжийг шинэчлэх судалгааг нэгтгэн гаргаж, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т хүргүүлж, хөрөнгө оруулалтын PIMIS программд мэдээллийг оруулсан.

➢ Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2024 онд хийгдэх засвар тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтын ажлын саналыг авч дээд шатны байгууллагад хүргүүлсэн. Үүний үр дүнд 2024 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтад соёлын байгууллагуудын техник тоног төхөөрөмжийг шинэчлэх нийт **300.0 сая** төгрөгийн хөрөнгө оруулалтын төсвийг тусгаж батлагдсан.

➢ Дархан-Уул аймгийн ИТХ-ын 2023 оны 58 дугаар тогтоолоор Хүүхдийн номын ордны гадна цахилгааны ажлыг гүйцэтгэх **13.1** сая төгрөгийн төслийг баталж, гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулан хийж гүйцэтгүүлсэн.

➢ Тус аймагт шинээр баригдаж буй музейн үзэл баримтлал, үзүүллэг дэглэлтийг боловсруулахад зөвлөх үйлчилгээ авах төсвийн төслийг улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгуулахаар санал өгсний дагуу **16.0** сая төгрөгийн санхүүжилтээр музейн үзэл баримтлал, үзүүллэг дэглэлт боловсруулах шийдвэр гарсан. Энэ хүрээнд "Ажил гүйцэтгэх гэрээ"-г байгуулж, шинэ музейн үзэл баримтлал, үзүүллэг дэглэлтийн үндсэн чиглэл боловсруулах төлөвлөгөөний төслийг боловсруулан батлуулснаар судалгааны ажлыг эхлүүлээд байна.

**1.15. Худалдан авах ажиллагааны талаар:**

➢ Тус газраас худалдан авах ажиллагааны цахим системд **7** арга хэмжээний **12,462.6** мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээний төлөвлөгөөг нийтлэн батлуулсан.

➢ Харъяа соёлын **7** байгууллага худалдан авах ажиллагааны цахим системд **78** арга хэмжээний **288.879.3** мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөг батлуулан нийтэлж, **275.885.4** мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг шууд худалдан авалтаар хийсэн байна.

➢ 2023 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Залуучууд театрт **450.0** сая төгрөгийн үнэ бүхий зөөврийн тайз, карказ, гадна зориулалтын зөөврийн лед дэлгэц, соёл, урлагийн газарт **50.0** сая төгрөгийн үнэ бүхий **4** нэр төрлийн тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т хүргүүлж, аймгийн ОНӨГ-аас нээлттэй тендер шалгаруулалтын журамд заасны дагуу хялбаршуулсан цахим худалдан авалтыг 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр зарлаж, 2024 оны 01 дүгээр сарын 02-ний өдрийг хүртэл хугацаанд тендер хүлээн авах ажиллагаа хийгдэж байна.

➢ Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс орон нутгийн хөрөнгө оруулалтаар Залуучууд театрт **200.0** сая төгрөгийн дуу шуумны тоног төхөөрөмж худалдан авах тендерийг зарласан. Аймгийн ОНӨГ-аас худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулж, тендерт Бодь интернешнель ХХК шалгарсан.

➢Залуучууд театрын гадна шатны засвар **394,854,725.4** төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Тендерийн материал ирээгүй.

## ХОЁР. СОЁЛЫН БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР:

### <u>2.1. Бүх нийтийн соёлын боловсролын чиглэлээр</u>

**Үндэсний бичиг үсгийн баяр, Номын баяр, Дэлхийн Хүүхдийн номын өдөр, Эх хэлний өдөр зэрэг** 4 нэгдсэн **үйл ажиллагааны хүрээнд 237 арга хэмжээг зохион байгуулж, 34,539 хүнийг хамруулсан. Цахимаар 22,793 хүнд** үйлчилгээг **хүргэсэн байна. Үүнд:**

➢ "Үндэсний бичиг соёл, номын өдрүүд"-ийг Дархан, Шарын гол, Орхон, Хонгор суманд 2023 оны 5, 9 дүгээр сард “Илүү их уншъя”, “Номын баяр-Номтой Монгол” уриан дор нийт 106 арга хэмжээг 154 удаа зохион байгуулж 18,828 иргэнийн хамруулсан. Цахимаар 9 арга хэмжээг 8,198 хүнд хүргэсэн.

➢ Үндэсний бичиг үсгийн баяр-2023” үйл ажиллагааны хүрээнд харьяа соёлын байгууллагууд нийт 17 арга хэмжээг зохион байгуулж 596 хүнийг хамруулж, цахимаар 3 арга хэмжээг 3616 хүнд хүргэсэн.

➢ “Эх хэлний өдөр” үйл ажиллагааны хүрээнд 21 арга хэмжээг зохион байгуулж 508 хүнийг хамруулж, цахимаар 8,433 хүнд хүргэсэн.

➢ “Дэлхийн Хүүхдийн номын өдөр”-өөр 93 арга хэмжээг зохион байгуулж 14,607 хүнд үйлчилсэн. Цахимаар 2,546 хүнийг хамруулсан.

**Аймгийн төв номын сан, Хүүхдийн номын ордон нь бүх нийтийн соёлын боловсролд чиглэсэн 22 арга хэмжээнд** 21228 **хүүхдийг хамруул**сан. **Цахим сурталчилгаа, шторк, постер 10694 хүний хандалт ав**сан. Музей нь түүх соёл, **уламжлалт** ёс, Монголчуудын уламжлалт **тоглоом наадгайн боловсролын** 13 төрлийн **хөтөлбөр**ийг 204 удаа явуулж 8990 **нийт сурагч, оюутан** хамрагджээ. Үүнд:

➢ “Угийн бичгээ хэрхэн хөтлөх вэ” сэдвээр 37 удаагийн сургалт зохион байгуулж 450 хүн, 4000 хүнд арга зүй мэдээлэл, зөвлөгөө өгч, 20 удаагийн үзэсгэлэн зохион байгуулж 678 хүн хамрагдсан. Цахим хичээлийг 8399 хүнд хүргэсэн байна.

➢ “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч Г.Мягмар “Уламжлалт арга ухаан” ай савын “Угийн бичиг хөтлөх монгол уламжлалт мэдлэг” өвөөр оролцож 4000 гаруй иргэдэд үйлчиллээ. Түүний мэдлэг аргазүйг аймгийн иргэдэд түгээн дэлгэрүүлэхэд анхаарч ажиллаж байна.

➢ “Хос бичигтэн байгууллага” хөтөлбөрийн хүрээнд соёлын байгууллагууд 20 арга хэмжээг зохион байгуулж 1931 хүн хамруулсан. Монгол бичгийн цахим болон танхимын 22 удаагийн сургалтад 423 хүн хамрагдсан байна. Хос бичигтэн байгууллага" хөтөлбөрийг сурталчилсан 126 зурагт хуудас, контентыг бэлтгэн цахим сүлжээнд байршуулж цахимаар 9 арга хэмжээнд 6096 хандалт авсан байна. Соёл, урлагийн газар болон харьяа

байгууллагууд нийт 22 албан бичиг, 8 албан хаагчийн нэрийн хуудас, ажлын үнэмлэх, байгууллагын хаягийг Монгол бичгээр үйлдэж хэрэглээнд нэвтрүүллээ.

- "Соёлын өв" улсын эчнээ уралдааны II шатны шалгаруулалтыг 2023.05.12-ны өдөр аймгийн СУГ зохион байгуулж ЕБС-ийн XI, XII ангийн 6 сурагчийн эссэ бүтээлийг шалгаруулж III шатанд явуулснаас 2 хүүхдийн эссэ бүтээл шалгарч 3 дугаар байр эзэллээ.
- "Эрүүл монгол хүн" үндэсний фестивалийг аймгийн хэмжээнд 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулагдаж Соёл, урлагийн газар, Нийтийн бүжгийн холбооны Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөл, "Ирээдүй" бүжгийн клуб хамтран шугаман бүжгээр оролцон эрүүл хооллож дасгал хөдөлгөөн хийж эрүүл байхыг уриаллаа. 258 хүн оролцсон.
- **"БИД ЭХ ОРНЫ ИРЭЭДҮЙ"** төслийн хүрээнд **"ЭХ ОРОНЧ ҮЗЛИЙГ ТӨЛӨВШҮҮЛЭХ НЬ**" өдөрлөгийг аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб, Зэвсэгт хүчний 330 дугаар анги, соёлын байгууллагуудтай хамтран зохион байгуулж, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 102 сурагчдын дунд **"АХА"** тэмцээнийг зохион байгуулж, **"Эх орны хүү"** урлагийн тоглолт, цэргийн хувцас эд хэрэгсэл, явуулын станц, аранз, техникийг турших үзэх музейн хөтөлбөр, сэдэвчилсэн номын үзэсгэлэн, уншигчийн үнэмлэх нээх, ном солилцоо, бэлэгтэй асуулт зэрэг соёлын боловсролын хөтөлбөрүүдэд 712 гаруй хүүхэд залуус хамрагдлаа.
- Төв номын сан нь Монгол хүн бүрийн эх хэлээрээ зөв цэвэр ярих, уран яруу унших чадварыг хөгжүүлэх, авъяас билэг, ур чадварыг дэмжин урамшуулах зорилгоор **"СУДАР ЭРДЭНЭ"** богино өгүүллэгийн уран уншлагын уралдааныг ЕБС-ийн ахлах, дунд, бага ангийн болон СӨБ-ийн 82 хүүхэд оролцсон байна.
- Номын сангийн боловсролын "МОНГОЛ БАХАРХАЛ" хөтөлбөрийн хүрээнд "Монгол дээлийн товч түүний бэлэгдэл" сургалтыг 14 явуулж 377 хүн хамрагдлаа.
- "Оюунлаг Дархан" хөтөлбөрийг 21 удаа зохион явуулж 1560 хүн хамрагдсан байна.
- МУУГЗ Г.Баяртай багшийн удирдлага дор бий биелгээний "Угсаатан бий" төслийн сургалтад хамрагдсан бий биелээч 17 хүүхэд Хүүхдийн баярын нээлтэд биеллээ.
- Ахмад уран бүтээлч Б.Алтанцэцэг 12 хүүхдэд бий биелгээ, 2 хүүхдэд хурдан морины цол дуудах эрдэмд сургасан.
- Аймгийн Соёлын салбарын залуучуудын хөгжлийн зөвлөлтэй хамтран СББӨ-ийг өвлөн уламжлагчдыг нэмэгдүүлэх, шавь сургалтыг уламжлал болгох зорилгоор "Өв соёлоо өвлөн уламжилъя" Зүү ороох хатгамлын сургалтад ЕБ-ын 1 дүгээр сургуулийн 20 сурагчийг хамруулан зохион байгуулсан.
- Хүүхдийн номын ордон "Олуулаа уншья" аяны хүрээнд "Уншихад урам хайрла" уулзалтыг ЕБС-ийн сурагчдын дунд зохион байгуулж 400 сурагчийг хамруулав.
- JCI Их Хүрээ салбараас санаачлан хэрэгжүүлсэн "MIND UPDATE" төслийг СУГ, БШУГ хамтран зохион байгуулж, ЕБС-ийн ахлах ангийн 590 сурагчийг хамруулсан.
- 2023 онд "Монгол бахархал", "Ном бид хоёр" номын сангийн боловсролын хөтөлбөрийг 26 удаа зохион байгуулж 707 хүн
- "Нүүдэл" номын багцын үйлчилгээг 20 байгууллагад үзүүлж, 560 гаруй хүн хамрагдсан байна. Нийт 8 удаагийн аялалд 348 сурагч хамрагдаж, товч зангидах, номын хавчуурга хийхийг амжилттай суралцлаа.
- Орхон сумын 9 дүгээр Цэцэрлэгтэй хамтран 9 бүлгийн 196 хүүхэд багачуудын дунд "БЯЦХАН ЕРӨӨЛЧ- УРАН УНШЛАГА" тэмцээн амжилттай зохион байгууллаа.
- Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр тус сумын 11,14-р сургуулиуд, Чандага, 16-р цэцэрлэгүүдийн авьяаслаг сурагчид, Соёлын төвийн дугуйлангийн нийт 90 гаруй сурагчдын бүрэлдэхүүнтэйгээр урлагийн тоглолтыг зохион байгуулсан.
- Номын санчийн чиглэлээр хүүхдийн оролцооны INDEPOS MAKERS сайн дурын байгууллагыг шинээр байгуулж, хүүхэд, залуусруу чиглэсэн олон арга хэмжээг зохион байгуулж байна.

➢ Клубийн гишүүд 5-8-р ангийн 400 гаруй сурагчдад “Үе тэнгийн дарамт, дээрэлхэлд”, “Өсвөр насны хүүхдийн сэтгэл зүй, бие бялдар”, “Сайн дурын ажил зэрэг” сэдвийн хүрээнд сургалт тавьсан.

➢ "Угсаатан бий" төслийн бий биелгээний сургалтад 17 хүүхэд, 13.Соёлын байгууллагуудын сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 69 удаа хийж 3200 хүүхэд,

➢ “Эх хэлний өдөр”-өөр 21 арга хэмжээнд 508 хүүхэд, цахимаар 8433 хүнд,

➢ “Хуруун хүүхэлдэйн үлгэр”-ийн уралдаанд 62 хүүхэд,

➢ Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан Нийтийн бүжгийн спортын VII их наадам, Улсын аварга шалгаруулах тэмцээнд Дархан-Уул аймгаас ИРЭЭДҮЙ клубын “ШИНЭ ҮЕ”, “ХӨСӨГТӨН” хамтлагууд амжилттай оролцож Залуучуудын хамтлаг Мөнгө, Ахмадын баг Хүрэл медаль хүртлээ.

➢ Аймгийн Музей УБТЗ-ын хувь нийлүүлсэн нийгэмлэгийн аялал жуулчлалын төвүүд хамтран ажиллах гэрээ байгуулж, хүүхдийн галт тэрэгний аялалд Дархан хотоор аялахын зэрэгцээ музейд зочлон боловсролын хөтөлбөрүүдэд хамрагдах боломжийг бүрдүүлсэн.

➢ Орхон сумын Соёлын төвийн уран бүтээлчид сумынхаа төрийн байгууллагын эрэгтэй албан хаагчидтай хамтран **"БҮСГҮЙЧҮҮДДЭЭ БАРИХ БИДНИЙ БЭЛЭГ"** хүндэтгэлийн тоглолт үдшийн цэнгүүнийг зохион байгууллаа.

➢ **"БИ ЭЭЖИЙНХЭЭ ОН ЦАГИЙН ҮРГЭЛЖЛЭЛ"** захидлын уралдаанд нийт 404 захидал ирсэн бөгөөд үүнээс насанд хүрэгчдийн ангилалд 33, ЕБ-ын 9 сургуулийн сурагчдаас 371 захидал иржээ.

➢ Шарын гол сумын Соёлын төвөөс “**ЭРХЭМСЭГ ЭМЭГТЭЙ ТАНД ХАЯГЛАХ ЗАХИДАЛ”** уралдааныг зохион байгуулав. Уралдаанд 100 гаруй захидал ирж 4 насны ангилалд 10 захидлын эзнийг шалгаруулж соёлын төвийн уран бүтээлчид захидлыг эздэд нь хүргэхдээ тайзнаас захиаг амьдруулан уншиж, дуу хуур, хөг аялгуутай хамтатган хүргэжээ.

➢ Хонгор сумын Соёлын төвөөс **"ЭЭЖДЭЭ ЗАХИДАЛ БИЧЭЭРЭЙ"** захидлын уралдааныг зохион байгуулав. Нийт 42 захиа ирснээс шилдэг 5 байрыг шалгаруулж, шагнаж урамшуулжээ.

➢ Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн нээлтийн тоглолтыг аймгийн ГБХЗХГ, БТСГ, БШУГ, Залуучууд театр, Хүүхэд хөгжлийн ордны дэргэдэх дугуйлангуудтай хамтран зохион байгуулж, соёлын үйлчилгээгээр бэлэг барьлаа. Музейгээс Дархан-50 цогцолборт "БИ ЗУРААЧ" ART DAY хөтөлбөр, уламжлалт хөлөгт наадгай Чүүчамай, 4 бух, тэмээн таваг зэрэг сонирхолтой тоглоомуудыг зааж, 180 гаруй хүүхэд багачуудад үйлчиллээ.

➢ Хүүхдийн номын ордноос **Цардмал талбайн зургийн уралдаан**ыг 4-11 насны хүүхдүүдийн дунд зохион байгуулж 40 бүтээл хүлээн авч, Монгол ёс заншил, танин мэдэхүй” сэдэвт **АХА** тэмцээнд 9-11 насны 51 хүүхэд тус тус хамрагдлаа.

➢ Төв номын сангаас "ХӨГЖӨӨНТ ТОГЛООМ" буюу дүрст шоо эвлүүлэх, бодъё, сэтгэе, холбоё, саная 4 төрөлт үг эвлүүлэх тоглоом зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж 60 гаруй хүүхэд оролцлоо. Оюун ухаанаа сорьсон дүү нартаа газрын зураг, номыг дээжлэн бэлэглэв.

➢ **Дархан хот** үүсэн байгуулагдсаны 62 жилийн ойг угтан /2023.10.13/-ны өдөр

-Төв номын сангаас "Бүтээлч уншлага" өдөрлөгийг "Энэрэл цогцолбор", "Шинэ алхам" сургуулийн 80 гаруй сурагчдын дунд зохион байгууллаа.

-Аймгийн ЗДТГ, СУГ, Найрамдал төсөл хамтран “Машинтай кино үзвэр”-ийг Дарханчууддаа толилууллаа.

-**“DARKHAN DRIFT SERIES”** дрифтийн тэмцээнийг /2023.10.15/-ны өдөр зохион байгууллаа. Тус тэмцээнийг “Монголын мэргэжлийн спорт авто машины холбоо”, аймгийн

ЗДТГ, аймгийн СУГ хамтран зохион байгуулж, “Mongolian drift series Final round”-дын мэргэжлийн ангилалд 31 тамирчин, сонирхогчдын ангилалд 36 нийт 67 тамирчин оролцсон.

-Аймгийн Хүүхдийн номын ордон нь Дархан хотын 62 жилийн ойн өдрийн хүрээнд ЕБС-ын сурагчдын дунд “ХОТЫН СОЁЛ НАДААС ЭХЭЛНЭ” эссэ болон видео бичлэгийн уралдааныг зохион байгууллаа.

- Тус газар нь **"ЧИНГИС МАСТЕР КРОСС-2023"** 23 дахь удаагийн уралдааныг хамтран амжилттай зохион байгууллаа.

## 2.2. Соёл гэгээрлийн чиглэлээр:

**2023 онд** аймгийн хэмжээнд нийтийн номын сангуудад **худалдаагаар 794 нэр төрлийн 1**942 **боть ном, хандиваар 1**407 **боть номоор баяжилт хийсэн. Нийт** 3349 **боть номын баяжилт хийгдсэн. Үүнд:**

- Төв номын сан 2023 онд нийт 23,598,580 төгрөгийн 871 нэр төрлийн 1170 боть номоор фондоо баяжуулжээ. Үүнээс худалдаагаар 17,404,660 төгрөгийн 450 нэр төрлийн 734 боть, хандиваар 7,099,820 төгрөгийн 421 нэр төрлийн 436 боть ном байна.
- Хүүхдийн номын ордон 16 удаагийн худалдан авалтаар 19,115,422 төгрөгийн 344 нэрийн 932 боть ном худалдан авч сан хөмрөгөө баяжуулсан.
- Шарын гол сумын Соёлын төв нь орон нутгийн төсвийн 3.0 сая төгрөгийн санхүүжилтээр 276 боть ном, иргэдийн хандив тусламжаар 128 боть номоор тус номын сан хөмрөгөө баяжуулсан.
- Орхон сумын Соёлын төв иргэдийн хандиваар 96 боть номоор сан хөмрөгөө баяжуулсан.
- Хонгор сумын Соёлын төв иргэдийн хандиваар 13 боть номоор сан хөмрөгөө баяжуулсан.
- Алслагдсан багуудын иргэдэд зориулж номын сангийн баяжилт хийх зорилгоор “Номын хандив” аяныг зарлаж төрийн байгууллага, иргэдээс нийт 752 боть ном цугларснаас 618 боть номыг алслагдсан Малчин, 15 дугаар багийн төвд хүлээлгэн өгч дэмжлэг үзүүлсэн.

**Зохиолч, уншигчдын уулзалт, шинэ шилдэг номын** үзэсгэлэн худалдаа, **сурталчилгаа зэрэг соён гэгээрүүлэх олон талт** 24 арга хэмжээг **зохион байгуул**ж, 15631 иргэдийг хамруулсан байна. Үүнд:

- “Зохиолч хүүхэд” сэдэвт зохиолч, яруу найрагчдын уулзалтыг 4 удаа зохион байгуулж 310 хүүхэд хамрагдсан байна.
- Хүүхдийн номын ордон "Олуулаа уншья" аяны хүрээнд “Уншихад урам хайрла” уулзалтыг ЕБС-ийн сурагчдын дунд зохион байгуулж 400 сурагчийг хамруулав.
- Зохиолч, МУСГЗ Б.Шүүдэрцэцэгийн “Эрвээхэйн сүнс” номын нээлт, зохиолч, уншигчдын уулзалтад 100 хүн хамрагдсан.
- Орон нутаг дахь хэвлэлийн үйлдвэрүүдийн хамтарсан номын үзэсгэлэн, уралдааныг 5 удаа зохион байгуулж 860 хүн хамрагдлаа.
- “Номын эзэн”-ийг алдаршуулах ном бэлэглэх ёслолын арга хэмжээг зохион байгуулж 752 хүн оролцсон.
- Олон улсад Монголын уран зохиолыг таниулах, үндэсний утга зохиолоор дамжуулан эх орноо сурталчлах, нийгмийг соён гэгээрүүлэх зорилгоор 2023 оны 05 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд нийслэл хотноо зохион байгуулагдсан **“УЛААНБААТАР ОЛОН УЛСЫН ЯРУУ НАЙРГИЙН ФОРУМ"-д** Дархан-Уул аймгаа төлөөлөн яруу найрагч Б.Норовсамбуу, Н.Төмөртогоо, Т.Банзрагч нар амжилттай оролцсон.
- “Номын клуб” ном сонирхогчдын уулзалтад 30 уншигч оролцсон.
- Радио телевизийн Тэргүүний ажилтан, МҮОНРТ-ийн ахмад ажилтан Д.Жамсрангийн 3 дахь бүтээл болох "Мэдлэг ба сэтгэлгээ өдрийн тэмдэглэл" номын "Шинэ номын баяр"-т 40 гаруй уншигч оролцов.

- Орон нутгийн зохиолчдын гарын үсэгтэй худалдаанд 35 уншигч оролцсон.
- "Уутан хацарт" номын зохиолч МУСГЗ, сэтгүүлч Ө.Рагчаасүрэн, зураач Б.Нямдаваа нарын оролцсон "Зохиолч-хүүхэд" уулзалтад ОИЦогцолбор сургуулийн 6-11 анги, Од цогцолбор сургуулийн 10-2 ангийн сурагчид оролцлоо.
- Яруу найрагч Р.Лхамрагчаагийн уулзалтад 100 гаруй сурагч,
- Хүүхдийн зохиолч Н.Мандалын уулзалтад 70 гаруй уншигч,
- Шог зураач, яруу найрагч Д.Мянганзамын уулзалтад 200 иргэн,
- Хүүхдийн зохиолч О.Сундуйн уулзалтад 75 уншигч,
- МУСГЗ, сэтгүүлч Ө.Рагчаасүрэнгийн "Чихтэй шувууны садан" номын нээлтэд 45 иргэн,
- "Сүбээдэй Баатар" шинэ номын нээлтэд 100 гаруй уншигч,
- "Номтой Дархан" зохиолчдын гарын үсэгтэй, хямдралтай номын өдөрлөгт 19 зохиолч, 6 хэвлэлийн байгууллагууд оролцож 480 гаруй иргэд,
- "Тэнгэрийн заадаст оршихуй" уулзалтад 315 иргэнийг тус тус хамрууллаа.
- Оны шилдэг шүлэг шалгаруулах "Гал өд" яруу найргийн наадамд 18 яруу найрагч оролцож 220 гаруй хүн хамрагдлаа. Наадмыг зохион байгуулахад аймгийн ЗДТГ-аас 2.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж 300 ширхэг номыг хэвлүүлэхээр захиалгад өгсөн.
- "Яруу эгшиглэн-2023" яруу найргийн тэмцээнд 11 яруу найрагч оролцож 50 гаруй иргэн,
- Хүүхдийн номын ордноос аймгийн аварга шалгаруулах уран уншлагын **"УРАН ЖИРГЭЭ-2023"** наадмыг зохион байгууллаа. Тус наадамд нийт 4 насны ангилалд ЕБ-ын 18 сургууль, 15 цэцэрлэгийн нийт 57 хүүхэд оролцож өрсөлдсөн.
- Улаанбаатар хотоос "АЗ ХУР" номын их дэлгүүрийн 72%-ийн номын хямдралтай худалдаа 2023.10.17,18-ны өдрүүдэд Залуучууд театрт боллоо.
- Шинэ ба сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 69 удаа гаргаж, 8,571 хүнийг тус тус хамруулсан байна.

**Дүрслэх урлагийн бүтээлээр улс, бүс, аймгийн үзэсгэлэнд оролцох, аймгийн иргэдэд зориулсан үзэсгэлэн гаргах ажлын хүрээнд нийт аймгийн Музейд 12** удаагийн **гэрэл зургийн үзэсгэлэн гаргасан байна. Аймгийн СУГ-аас нийт 30 удаагийн үзэсгэлэнд дэмжлэг үзүүлж хамтран ажиллалаа. Үүнд:**

- 1 дүгээр сард Монголын гэрэл зургийн холбоотой хамтран "Цаг уурын өөрчлөлт" гэрэл зургийн үзэсгэлэн 10 хоног,
- "Монгол Арт" Галерейтай хамтран Монголын алдарт зураач, уран бүтээлчдийн бүтээлүүдээр нүүдлийн үзэсгэлэн 5 хоног,
- 3 дугаар сард Зураач урчуудын эвлэлийн зураач С.Мөнгөнзулын анхны биеэ даасан "Гүнж" уран зургийн 10 хоног үзэсгэлэн,
- 4 дүгээр сард "Хүний эрх, эрх чөлөө" сэдэвт шог зургийн үзэсгэлэн 7 хоног, "Art of n" хүүхдийн уран зургийн үзэсгэлэн,
- 5 дугаар сард "Галерей аялж байна" Монголын түүх соёлын хосгүй үнэт дурсгал, сор бүтээлийн үзэсгэлэн 2 хоног,
- Улаанбаатар хотноо зохион байгуулсан "ART FAIR 2023" дүрслэх урлагийн үзэсгэлэн, худалдаанд зураач Ц.Намдаг, Н.Хишигбаатар, С.Мөнгөнзул, Г.Сугар нар нийт 11 бүтээлээр 7 хоног, "Дархан хотын хөшөө дурсгал-Миний дуранд" гэрэл зургийн үзэсгэлэн,
- Үнэт эдлэл, Соёлын өвийн хосгүй бүтээлүүд, Гоёл чимэглэлийн салбарын нэгдсэн үзэсгэлэнд Дарханы урчууд оролцлоо.
- Евро Азийн соёл, урлагийн нийгэмлэг, Монголын урчуудын эвлэлийн удирдах зөвлөлөөс Дарханы зураач урчуудын эвлэлийн залуу уран бүтээлчидтэй уулзаж, цаашдын уран бүтээлийн хамтын ажиллагаа Дархан хотод дүрслэх урлагийг хөгжүүлэх тухай асуудлаар санал бодлоо солилцлоо.

➢ D-art урлангийн багш, залуу зураач Ч.Нарангарав зураач хүүхдүүдийн бүтээлийн үзэсгэлэн,

➢ Дархан хотын бэлгэдэл "НАДА" бугийн "Хөгжилтэй аялал" анимейшн хүүхэлдэйн киноны сэдэвт гар зургийн үзэсгэлэнд 300 иргэн,

➢ Дарханы зураач урчуудын эвлэлийн тэргүүн зураач, СТА Н.Хишигбаатар "Монгол авдар"-ны үзэсгэлэн,

➢ Соёлын бүтээлч сар аяны хүрээнд Дарханы Зураач урчуудын 22 уран бүтээлчдийн "Мэдрэмж" уран зургийн үзэсгэлэн,

➢ "Кинонд ээлтэй хот-Дархан" сэдэвт гар зургийн уралдааныг ЕБС-ийн 3-5 дугаар ангийн 20 сурагчдын дунд зохион байгуулж үзэсгэлэн гаргав.

➢ Соёлын сэргэлт аяны хүрээнд "Шог зураг"-ийн үзэсгэлэн,

➢ "Бийрэн бичлэг"-ийн үзэсгэлэнг тус тус гаргалаа

## 2.3. Соёлын өв, уламжлалын чиглэлээр:

➢ Орхон сумын түүх дурсгалын үл хөдлөх 5 дурсгалт газрыг 2 малчин иргэнд, гэрээний үндсэн дээр хариуцуулан хамгаалуулсан. Хонгор сумын 23 үл хөдлөх дурсгалт газрыг харьяа нутаг дэвсгэрийн 3 байгаль хамгаалагчид гэрээний үндсэн дээр хариуцуулан хамгаалуулж, сумын Газар зохион байгуулалтын төлөвлөлт, кадастрын зурганд тэмдэглэгээ хийлгэлээ.

➢ 2 үл хөдлөх түүх соёлын дурсгалт хөшөө, Музейн 3 үзмэрийн гадаад өнгө төрхийг сэргээн засварласан. Сан хөмрөгт хадгалагдаж байгаа 358 дэсийн 518 гэрэл зургийг цахимд шилжүүлэн цахим архив үүсгэн хадгалах ажлыг хийсэн.

➢ Монгол түүх, соёл, үл хөдлөх дурсгалын 2022 оны тайланг Соёлын өвийн үндэсний төвд хүлээлгэж өгсөн. Тооллогоор нийт 51 дэсийн 361 үзмэрийг 100% хамруулсан.

➢ Сяньбигийн үеийн хаад язгууртны бунхант булшны малтлага судалгааны ажил гүйцэтгэх гэрээ" нэртэй №ОНХС-2023/01-05 дугаар бүхий Дархан-Уул аймгийн Хонгор сумын Говилуй уулын орчимд байх 1800 жилийн өмнөх үе буюу Сяньбигийн үеийн хаад язгууртны булшны малтлага судалгааг ОНХСангийн 70 сая төгрөгийн хөрөнгөөр 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрөөс долдугаар сарын 31-ний өдөр хүртэл МУИС-ийн Улаанбаатар Сургуулийн Түүх, археологийн тэнхимийн доктор Т.Идэрхангай болон тус тэнхимийн 2 дугаар багийн хамт олон хийж гүйцэтгэлээ. 2023 онд 7 болон 9 дугаартай бунхант булш болон уг 2 бунхантай зэрэгцээ хоёр том хэмжээний бунхант булшийг малтан судлав. Малтлага судалгаанд тулгуурлан дурсгалт газар дээр хээрийн ИЛ МУЗЕЙ байгуулах урьтач нөхцөлийг бүрдүүлэх, эх орны түүхийг ирээдүй хойч үедээ үнэн зөвөөр нь өвлүүлэн үлдээх үндсэн зорилготой юм.

➢ 2 сумын Соёлын төвийн Музейд 4 удаа түр үзэсгэлэн дэглэж 935 хүн үзэж сонирхож, 400 гаруй хүүхэд боловсролын хөтөлбөрт хамрагдсан байна. 3 сумын Музейн сан хөмрөгийн ажилтнуудыг 5 удаа сургалт, арга зүйгээр хангаж, гарын авлага, ном товхимолоор хангасан.

➢ Хагас жилийн байдлаар иргэдийн гар дээр хадгалагдаж байсан 27 баримтад өвийг бүртгэл судалгаанд хамруулж хадгалалт хамгаалалтын талаар зөвлөгөө өгч ажилласан байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар Дархан сумын 5 дугаар баг Гэцогдаржайлин хийдэд хадгалагдаж байгаа Богд ламын чуулганы орон-цогшин, Ногоон дара эх, Заяаны таван тэнгэр, Лагшин /бие/ зарлиг /хэл/, таалал /сэтгэл/-ын шүтээн, Хараагийн дарь эхийн түүхэн уран зураг, Нархажид бурхан, Соёмбо үсгийн зээгт наамал, Хутагт хувилгаадын гэрэл зураг, шавар бурхан барласан дардас, зурмал бурхан, судар, монгол зураг танка зураг зээгт наамал нийт 9 дэсийн 9 ширхэг; Дархан сумын 4 дүгээр багийн иргэн Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч О.Туулд өвлөгдөж ирсэн Говийн Лха бурхан, зөвшөөрлийн бичиг 2 дэсийн 2 ширхэг, Музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа 12 **дэсийн 12 ширхэг баримтад өв бүртгэлд хамрууллаа.**

➢ УБ-Дархан чиглэлийн авто замын 5 дугаар багцаас ажил гүйцэтгэх явцад хагарч муудаагүй ваар олдсонтой холбогдуулан мэргэжлийн судалгааны байгууллагаар үзлэг тандалт хийлгэхэд зарцуулагдах 1.5 сая төгрөгийн зардлыг гаргуулахаар аймгийн Засаг даргаар ЗТХЯ-нд хүсэлт гаргуулж шийдвэрлүүлсэн. Соёлын яам, ШУАХ-д амаар болон бичгээр мэдэгдэж танилцуулсан.

➢ Музейн сан хөмрөг, үзмэрийн аюулгүй байдлыг хангуулах хүрээнд орон нутгийн төсвөөс 1,610,000 төгрөгийг шийдвэрлэж үзүүллэгийн танхимуудын 12 камерыг "Дархан Сити электроникс" компаниар шинэчлэн солих ажлыг гүйцэтгүүлсэн.

➢ Соёлын яамнаас хэрэгжүүлсэн музейн камер болон дохиолол хамгааллын системийг улсын хэмжээнд шинэчлэх СОЯ/202212021 гэрээний дагуу аймгийн музейд 30.393,083 төгрөгийн эд хөрөнгийг хүлээлгэн өгч суурилуулсан.

➢ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Төр сүм, хийдийн харилцааны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, соёлын биет бус өвийн хадгалалт хамгаалалт, аюулгүй байдалд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгах, алдагдсан болон дутагдсан түүх, соёлын дурсгалт зүйлсийг эрэн сурвалжилж, олж тогтоох зорилгоор "Сүм хийд" нэгдсэн арга хэмжээг аймгийн ЦГ-ын Эрүүгийн цагдаагийн тасагтай хамтран 2023.09.28-наас 2023.10.18-ныг хүртэл өдрийн хугацаанд хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн.

**Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг дэмжих,** тоглолт, **шавь сургалт зохион байгуулах, сурталчлах, алдаршуулах** чиглэлээр нийт 22 арга хэмжээг зохион байгуулж 1115 хүн хамрагдсан байна. **Үүнд:**

➢ 2023.02.15-ны өдөр Монгол улсын мастер тогооч Ч.Зунгарайн санаачилгаар үндэсний үнэт өв соёл болох цагаан сарын идээ ундаа, мах шүүс бэлтгэх арга ажиллагаа, ёс заншлыг тайлбарлан таниулах, уламжлан өвлүүлэх зорилгоор **"ӨВ СОЁЛ-ЦАГААН САР"** уулзалт хэлэлцүүлгийг аймгийн Ахмадын хөгжлийн төвтэй хамтран зохион байгуулав. Нийт 32 хүн хамрагдлаа.

➢ Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчаар шинээр 10 хүн бүртгэлд хамрагдсан.

➢ Монгол Улсын соёлын биет бус өвийн үндэсний жагсаалтад орсон өвлөн уламжлагчийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлын хүрээнд Дархан сум 30, Хонгор сум 12, Шарын гол сум 14, Орхон сум 18 өвлөн уламжлагчийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт тус тус хамруулжээ.

➢ 2023.03.27-ны өдөр "Дархан тайж Хасарын нэрэмжит төвийн бүсийн аварга шалгаруулах үзэсгэлэн тэмцээн"-ийг Дархан хотноо анх удаа зохион байгуулж 8 ангилалд 71 Монгол банхар ноход өрсөлдлөө. Үзэгчдийн тоо 150

➢ Ардын бий биелгээний арга барил, биелэх онцлог, зан үйлийн боловсрол олгох, соёлын биет бус өвийг өвлүүлэн уламжлуулах зорилгоор **"УГСААТАН БИЙ"** төслийг УИХ-ын гишүүн Б.Баттөмөрийн дэмжлэгээр тус газраас эрхлэн зохион байгуулж, сургагч багш бэлтгэх болон сонирхогчийн гэсэн 2 ангид нийт 140 гаруй хүн хамруулсан. Нийт 80 суралцагч батламж авч, үүнээс 17 сургагч багш монголын зургаан угсаатны бий биелгээг заах эрхтэй болсон юм. Тус сургалтын төгсөгч, СББӨ-ийн өвлөн уламжлагч З.Алтанцэцэг Шарын гол сумын ЕБС-ийн 25 сурагчид бий биелгээг зааж сургасан.

➢ УБ хотноо МҮОНРТ-ийн "Өв түгээ" зорилтот төслийн нээлтэд аймгийн 3 өвлөн уламжлагч оролцсон.

➢ Хонгор сумын СББӨ-ийг өвлөн уламжлагч 3 иргэн "Олон улсын музейн өдөр" буюу 2023.05.18–нд өөрсдийн өвлөсөн өвөөр мэндчилгээ дэвшүүлсэн.

➢ Орхон сумын СББӨ-ийн өвлөн уламжлагчид болон тус сумын Соёлын төвийн дэргэдэх дугуйлангийн сурагчдын хамтарсан гурван үеийн "ЗАЛГАМЖ" тоглолтыг сумын 300 иргэнд толилуулсан.

➢ Аймгийн ИТХ-аас санаачлан 3 сумдын ЕБС-уудын ахлах ангийнхны дунд спорт, урлаг, оюуны мэдлэг шалгасан 3 төрлийн уралдаан 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Хонгор сумын ЕБС-ын сурагчдын дунд “Өв соёлоо дээдэлье” урлагийн тэмцээнд 60 гаруй сурагч оролцож 460 хүүхэд хамрагдсан.

➢ Шарын гол сумын ЕБС-ийн бага ангийн 300 сурагчдын дунд “Зан заншлаас суралцъя” уралдаан, номын санч уран уншлагын дугуйлангаар дамжуулан долоон насанд хүрэгч 31 хүүхдэд ерөөл, магтаал аялгуулан уншихыг зааж сургасан.

➢ Ахмад уран бүтээлч бий биелгээний сургалтад хамрагдан төгсөөд 12 хүүхдэд бий биелгээ, 2 хүүхдэд хурдан морины цол дуудах эрдэмд сургасан.

➢ Тус аймгийн Соёлын салбарын залуучуудын хөгжлийн зөвлөлтэй хамтран СББӨ-ийг өвлөн уламжлагчдыг нэмэгдүүлэх, шавь сургалтыг уламжлал болгох зорилгоор “Өв соёлоо өвлөн уламжилъя” Зүү ороох хатгамлын сургалтад ЕБ-ын 1 дүгээр сургуулийн 20 сурагчийг хамруулан зохион байгуулсан. Дархан сумын ЗДТГ-аас хавтага, даалингийн бэлдэц, зүү утсаар дэмжсэн.

➢ Соёл, урлагийн газар, Соёлын байгууллагуудаас зусланд амарч буй хүүхдүүдэд **НҮҮДЛИЙН АХУЙ, ҮНДЭСНИЙ СОЁЛЫН ӨВ, УЛАМЖЛАЛЫГ СУРТАЛЧЛАН ТАНИУЛАХ ХӨТӨЛБӨР**-ийг аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран зохион байгуулж нийт 8 ээлжийн 900 хүүхдэд хүрч үйлчиллээ.

➢ СББӨ-ийг өвлөн уламжлагч нийт 7 хүнийг “АРДЫН АВЬЯАСТАН” цол тэмдэгт тодорхойлж шагнаж урамшуулсан.

➢ Хонгор сумын Соёлын төв нь “Соёлын сэргэлт 2023” аяны хүрээнд СББӨ-ийн өвлөн уламжлагч 7 иргэний танилцуулга мэдээллээр Залуучууд театрт үзэсгэлэн гаргаж алдаршуулсан.

➢ “Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд СББӨ-ийн өвлөн уламжлагч 4 ахмад иргэний танилцуулга видеог цахимд байршуулсан бөгөөд нийт 3509 хүн үзэж 378 хүнд таалагдаж 103 сэтгэгдэл үлдээж 47 хүн хуваалцсан байна.

➢ Хонгор суманд Говлиу хайрханы тахилгыг тохиолдуулан “Малчдын баяр”-ыг 2023 оны 06 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд тус баярын хүрээнд 15 багийн 150 гаруй иргэд Шилмэл малын үзэсгэлэн, Сээр цохих, Сураар бүтээгдэхүүн хийх, Дээс томох, Цагаан идээ шалгаруулах, Олс татах, Хос морьтон шалгаруулах, Шагай шүүрэх, Эмнэг булгиулах зэрэг тэмцээн, Хурдан морины уралдаан, Үндэсний бөхийн барилдаан зэрэг төрлүүдээр өрсөлдсөн.

➢ ЕБС-ийн 2 дугаар сургуулийн бага ангийн сурагчдын дунд “Зан заншлаас суралцъя” уралдааныг хамтран зохион байгуулсан.

➢ Номын санч уран уншлагын дугуйлангаар дамжуулан 7 насанд хүрэгч, 31 хүүхдэд ерөөл, магтаал аялгуулан уншихыг, 2 хүүхдэд хурдан морины цол дуудахыг зааж сургасан.

➢ Шарын гол сумын Соёлын төв өвлөн уламжлагч, соёлын ахмад ажилтан Цэрэнжавтай хамтран ажиллах гэрээ байгуулан, морин хуурын дугуйлан хичээллүүлсэн.

➢ ЗГХА СУГ-аас ирүүлсэн 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 01/253 тоот “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд оролцох тухай албан бичиг, удирдамжийг үндэслэн 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдрөөс 21-ний өдрүүдэд Улаанбаатар хотын Налайх дүүргийн “Тайж хайрхан”-ы бэлд Дархан-Уул аймаг нийт 58 хүний бүрэлдэхүүнтэй оролцож шилдэг 5 аймгийн нэгээр шалгарлаа.

➢ Төвийн бусийн соёл, урлагийн байгууллагын ажилтнуудын дунд зохион байгуулсан **"ШАГАЙН ХАРВАА"** тэмцээнд 100 гаруй шагайн харваачид оролцлоо.

➢ Аймгийн соёлын байгууллагууд "Уламжлалт өв соёлоо дээдэлье“, "Үндэсний наадгай-бидний бахархал“, “ЕРӨӨЛ ДҮҮРЭН МОНГОЛ”, "Үндэсний өвийг уламжилъя“, “Хорол, Үйчүүр” “ӨВ СОЁЛОО ДЭЭДЭЛЦГЭЭЕ”, “Дээлтэй Монгол”, “МОНГОЛ ЁС ЗАНШЛАА ЭРХЭМЛЭЭ”, "Ерөөл дүүрэн цагаан сар“, “Бултаараа уншдаг бол ГОЁ” зэрэг уралдаан,

наадам, уламжлалт наадгайн хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж түүх уламжлалаа түгээн дэлгэрүүллээ.

➢ Орхон сумын Соёлын төв, сумын ЗДТГ-аас хамтран Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, Сум орон нутгийнхаа Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газруудыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, хайрлан хамгаалах зорилгоор **"МОРИН АЯЛАЛ"**-ыг зохион байгуулж ажиллалаа.

**2.4. Урлаг, уран бүтээлийн чиглэлээр:**

➢ Залуучууд театрын урын санд шинээр концерт, драмын болон хүүхдийн жүжгээр 7 уран бүтээл шинээр нэмэгдэж 42 удаа тоглогдож 12048 гаруй үзэгчдэд урлаг соёлоор үйлчилсэн байна. **Үүнд:**

1. Хүүхдийн шинэ жүжиг Д.Бибишийн зохиол, Г.Саранчимэгийн найруулга "Толбот цагаан" мюзикл жүжиг нэмэгдэж 32 удаа тоглогдож 11200 гаруй үзэгчдэд,
2. Г.Саранчимэгийн найруулга "Хорвоод ганцхан ээждээ" тоглолт -1 удаа тоглогдож 300 үзэгч,
3. "Мэндийн цэнхэр хадаг "концерт 2 удаа тоглогдож 700 үзэгч,
4. Г.Саранчимэгийн найруулга "Аядуун" тоглолт 1 удаа тоглогдож 450 үзэгч,
5. МУСТА С.Баярсайханы найруулга "Хөх тэнгэрийн орон" бүрэн хэмжээний концерт 2 удаа 1182 үзэгч, Үндэсний их баяр наадмын нээлт хаалтын урлагийн тоглолт давхардсан тоогоор 5800 гаруй үзэгч,
6. МЗЭ-ийн шагналт зохиолч А.Амарсайхан, найруулагч МУСТА Б.Жаргалсайхан нарын найруулга "Нагацын охин" инээдмийн драмын жүжиг 4 удаа тоглогдож 848 иргэдэд үйлчилснээс 300 хүүхэд урилгаар үнэ төлбөргүй, 548 хүүхэд соёлын эрхийн бичгээр,
7. Зорилтот бүлгийн гэр бүлүүдэд зориулсан "Бүсгүйчүүд" тоглолт 2 удаа 1116 үзэгчдэд тус тус толилууллаа.

➢ Залуучууд театрт 6 шинэ уран бүтээл туурвиж, 13828 хүнд хүргэсэн. Үүнд: Концертын уран бүтээл 5, үзэгч 1190, Хүүхдийн жүжиг 1, тоглолт 26 удаа, үзэгч 8952 байна. **Үүнд:**

1. Орхон сумын СББӨ-ийн 3 үеийн өвлөн уламжлагчид болон тус сумын Соёлын төвийн дэргэдэх дугуйлангийн сурагчдын хамтарсан "ЗАЛГАМЖ" тоглолтыг сумын 300 иргэнд толилуулсан.
2. "Угсаатан бий" төслийн сургалтад хамрагдсан Залуучууд театрын 2 бүжигчний бий биелгээг клипжүүлэн МҮОНРТ -ээр цацуулж, олон нийтийн хүртээл болгосон.
3. Орхон сумын Соёлын төвийн дэргэдэх бүжгийн дугуйлангийн "Язгуур" хамтлаг "Наадан биелээ"-ээр урын сангаа нэмсэн.
4. Сар шинийн баярт зориулан цэцэрлэгийн багш нарын дунд "Дөрвөн бэрх" телевизийн контентыг Цэц.мн цахим сайттай хамтран зохион байгуулав.
5. Сар шинийн баярыг угтан RGB телевизтэй хамтран соёлын биет бус өвийг өвлөн тээгч нарыг оролцуулсан ярилцлага, контент нэвтрүүлгийг бэлтгэж олон нийтэд хүргэсэн.
6. "Хөх тэнгэрийн орон" уран бүтээлийн тоглолтыг шинээр найруулан тавьж, 60 уран бүтээлч оролцон 2 удаа тоглогдож 1182 үзэгч үзсэн. Залуучууд театраас 7.0 сая, АЗДТГ-аас 53,6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.
7. МУСТА, дуучин Б.Сорөнзонболд нь Дархан магтаал, Золгох ерөөлийн дуунуудыг шинэчлэн бүтээсэн уран бүтээлийн зардалд ОНТ-өөс 1.3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.
8. "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивальд Дархан-Уул аймгийн онцлог бүхий олон ястны язгуур урлагийн "Олон үндэстний дуулал" тоглолтыг 16 удаа тоглож 4000 гаруй ард иргэдэд толилууллаа.

➢ Залуучууд театрын залуу уран бүтээлчдийн хамтарсан гэгээн хайрын баярт зориулан **"ХАЙР ӨӨРӨӨ ГАЙХАЛТАЙ"** богино хэмжээний лайв тоглолтыг цахимаар дамжуулан үзэгчдийн хүртээл болгож, Олон улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт

зориулсан **“ХОРВООД ГАНЦХАН ЭЭЖДЭЭ”** уран бүтээлийн тоглолтыг үзэгч олондоо өргөн барьж, Эх орончдын өдөрт зориулсан “МЭНДИЙН ЦЭНХЭР ХАДАГ” уран бүтээлийн тоглолтыг Дархан сумын иргэдэд толилууллаа.

➢ “Тогтвортой аялал жуулчлал”-ыг чадавхжуулах сургалтын хүрээнд зохион байгуулсан **Аялал жуулчлалын** нээлттэй өдөрлөгт аймгийн Залуучууд театрын уран бүтээлчид урлагийн тоглолтоор оролцож, соёлын орон зай, соёлын үйлчилгээг танилцуулав.

➢ Дархан хотын 70, 80, 90, 2000-аад оны амьд хөгжмийн уран бүтээлчдийн нэгдсэн **“МАРТАГДСАН АЯЛГУУ”** тоглолт 2023 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Залуучууд театрт тоглов. Тоглолтод Дархан хотыг бүтээн байгуулагч үе үеийн залуус нэгэн дор цуглаж нэгэн үдшийг хамтдаа дуулж бүжиглэж, эрч хүчтэй цоглог залуу насаа эргэн дурсацгаалаа. Тоглолтын үеэр уран бүтээлчдийг Соёлын тэргүүний ажилтан, Яамны жуух бичиг, Дархан хотын 60 жилийн ойн дурсгалын тэмдгээр шагнаж алдаршуулав.

➢ Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан **ДАРХАНЫ ҮДЭШ** шоу тоглолтод Залуучууд театрын болон Дарханы чөлөөт уран бүтээлчид оролцож ая дуугаа өргөн барьлаа.

➢ Ардын хувьсгалын 102 жил, Дархан хот байгуулагдсаны 62 жилийн ой, аймгийн баяр наадам, нээлт, хаалтын ёслолын үйл ажиллагаа **“ЭВ МӨНХИЙН ТУСГААР МОНГОЛ”** нэрийн дор зохион байгуулагдлаа. Энэ жилийн аймгийн баяр наадмын нээлт, бусад урлаг соёлын үйл ажиллагаанд Залуучууд театрын болон чөлөөт уран бүтээлчид, бүжгийн дугуйлангийн авьяаслаг хүүхэд багачууд, төрийн байгууллагын нийт 500 гаруй хүн оролцож Дарханчууддаа дуу хуур, бүжиг наадмаа толилууллаа.

➢ “Blue sky messengers” Европ Монголын залуу хөгжимчдийн Жазз оркестрын тоглолт 2023 оны 08 дугаар сарын 26-ны өдөр Залуучууд театрын тайзнаа тоглогдлоо.

➢ Монгол-Оросын найрамдал, хамтын ажиллагааны 63 дахь өдрүүдийн хүрээнд УИХ-ын гишүүн, Сангийн Сайд Б.Жавхлангийн урилгаар ОХУ-ын Бүгд найрамдах Буриад улсын мэргэжлийн урлагийн байгууллагууд, уран бүтээлчдийн “НАЙРАМДАЛ” тоглолт Дархан хотноо боллоо.

➢ Дархан хотын 62 жилийн ойн баярын Хүндэтгэлийн тоглолтыг Монгол Улсын Төрийн Соёрхолт "Баян Монгол" чуулгын уран бүтээлчид нийт Дарханчууддаа өргөн барьлаа. Тоглолтод “Баян Монгол” чуулгын удирдаач, МУСТА С.Саруул-Од удирдаж жазз хөгжмийн хамгийн том биг бэнд оркестрын стандартаар уран бүтээлүүдээ толилууллаа.

➢ **Дархан хот** үүсэн байгуулагдсаны 62 жилийн ойг тохиолдуулан дуулах сонирхолтой, өөрийн дуу хоолойг бусдад түгээх хүсэлтэй залуус хуран цугладаг "Open Mic" үйл ажиллагааг 2023.10.17-ны өдрийн 18:00 цагт "Дархан-50" цогцолборт зохион байгууллаа. Тус арга хэмжээнд 60 гаруй хүүхэд бүртгүүлэн дуулж 350 гаруй хүүхэд залуус, иргэд үзэж сонирхлоо.

➢ Монголын Моно жүжгийн төвөөс жил бүр зохион байгуулдаг **“Ялагчдын цуваа”** нэг хүний жүжгийн олон улсын уралдаан Дархан-Уул аймгийн Залуучууд театрын тайзнаа 5 өдөр амжилттай зохион байгууллаа.

➢ “Нүүдэлчдийн соёл суурин театрын хөгжилд” уриан дор “Гэгээн муза-17” олон улсын наадамд Залуучууд театр “Шидэт модны үр” хүүхдийн жүжгээр амжилттай оролцлоо.

➢ Аймгийн ИТХ-ын урилгаар Дархан хотноо айлчилж буй БНСУ-ын иргэдийн төлөөлөгчдөд болон ГТШУБ-ын 75 жил, (УСГТХБ) Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн 60 жилийн ой, Стандарт хэмжилзүйн 100 жилийн ойн баяр, Багш нарын бага хурлуудад Залуучууд театрын уран бүтээлчид урлагийн тоглолтоо өргөн барьлаа.

➢ Шарын гол, Орхон, Хонгор сумдын Соёлын төвд соёл, урлаг, гэгээрлийн 263 ажил зохион байгуулагдаж 42871 гаруй иргэдийг хамрууллаа. Үүнд:

1. “Соёлын түүчээ-330” төслийн хүрээнд сумдын Соёлын төвүүд болон “Т энтэртайнмент”-тай хамтран ажиллах гэрээг байгуулсан.

2. Шарын гол, Орхон, Хонгор сумдын Соёлын төвд "Соёлын сэргэлт-2023" аяны хүрээд тус тус 8 арга хэмжээ, "Соёлын бүтээлч сар"-ын хүрээнд нийт 25 арга хэмжээг зохион байгууллаа.
3. Мөн соёлын төвүүдэд бусад байгууллагын 14 киног 29 удаа гаргаж 3266 үзэгчдэд хүргэлээ.
4. Дархан хотыг сурталчлах, хотын түүхийг өгүүлсэн "Хөгжилтэй аялал" анимэйшнийг бүтээж соёлын төвүүдээр дамжуулан 19 удаа 1527 хүүхэд багачуудад тус тус үзүүлсэн.
8. Хонгор сумын Соёлын төв нь дугуйлангийн сурагчидтай хамтран Үзэсгэлэн болгогч хэмээх Харагчин туулай жилийг угтан **“ХОНГОРЫН ДУУЛАЛ-2023” урлагийн тоглолт**оо Буурал, Салхит багуудад тоглон 300 гаруй иргэдэд толилууллаа.
9. Казак ард түмний соёл, ёс заншлыг танин мэдэх, суртчилах зорилгоор “Казак гэр” Атарчин талбайд барьж цайллах үйл ажиллагаа зохион байгуулсан бөгөөд 400 орчим иргэд хамрагдсан.

➢ Орон нутгийн иргэдэд хүргэх соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах хүрээнд Орхон сумын Соёлын төв Лэд дэлгэцтэй болж, Хонгор сумын Соёлын төв нь ном сан, музейн орчин нөхцлийг сайжруулах, хувцас шинэчлэх, тоног төхөөрөмж авах төслийг үе шаттай хэрэгжүүлж байна.

➢ **Дархан хотын** бүжгийн спортын **"Vision dance“** клуб үүсэн байгуулагдсаны 15-н жилийн ойн нэрэмжит “АЛТАН НАВЧ-2023” 21 аймаг, 9 дүүргийн спорт бүжиг, нийтийн цэнгээнт бүжгийн улсын чанартай тэмцээнийг 2023.10.21-22-ны өдрүүдэд Дархан сумын Спорт цогцолборт зохион байгууллаа.

➢ **“DARKHAN DANCE FESTIVAL 2023”** бүжгийн наадамд нийт 18 хамтлагийн 360-аад бүжигчин хүүхдүүд авьяас билгээрээ өрсөлдлөө.

➢ WDC холбоо Япон улсын JBDF холбооноос зохион байгуулсан Дэлхийн Супер Цуврал 44 наадамд Дарханчууд амжилттай оролцлоо. **Өсвөр насны стандарт төрөлд** Маргад-Эрдэнэ, Эрдэнэжаргал хагас финал 9-р байр, Латин төрөлд Мөн хагас финал 8-р байр, **Amateur Latin төрөлд** Vision dance club-ийн Насанбат, Золзаяа 71 хосоос латин төрөлд 1/8 финал (49) тус тус шалгарлаа.

➢ Говьсүмбэр аймагт зохион байгуулагдсан нийтийн Цэнгээнт бүжгийн нээлттэй тэмцээний "ШИЛДЭГ КЛУБ" цомын эзнээр Хос хэмнэл клубийнхэн боллоо. Тэмцээн нийт үндсэн 4 төрөл, 16 ангиллаар явагдаж нийт 67 хосын 134 бүжигчин оролцжээ.

➢ Дорноговь аймагт зохион байгуулагдсан НИЙТИЙН БҮЖГИЙН СПОРТЫН VII ИХ НААДАМД Дархан-Уул аймгаас Ахмадын “Шинэ үе”, “Жигүүр”, Залуусын “Хөсөгтөн” зэрэг нийтийн бүжгийн хамтлагууд оролцож 18-45 насны ангилалд Хөсөгтөн хамтлаг “ТЭРГҮҮН БАЙР” эзэлж цом, өргөмжлөл, алт, мөнгөн медалиар тус тус шагнагдлаа.

➢ 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдөр **17 продакшны "Орлон тоглогч"** олон ангит киноны зураг авалтыг Хонгор сумын Соёлын төв, Цагдаагийн хэсэгт хийлээ.

➢ 2023 оны 09 дүгээр сарын 28-аас 10 дугаар сарын 01-ний өдрүүдэд Болгар улсын Софи хотод зохион байгуулагдсан "Алтан Морь" олон улсын циркчдийн анхдугаар тэмцээнд олон орны жүжигчдээс сонгогдон оролцсон Дархан-Уул аймгийн Залуучууд театрын дэргэдэх "Шонхоодой" Shonkhoodoi ardiin circus циркээс 7 жүжигчин болон Zola&Bros Circus-ээс 6 жүжигчид хамтарсан баг ТУСГАЙ байрын шагналын эзэд боллоо.

➢ 2023 оны 10 сарын 18-ны өдөр яг Өргөө театрт “Эмэгтэй кейс” МУСКиноны нээлт боллоо. Нээлтээр Д.Галбаяр МУСТА, Гол дүрийн жүжигчид Т.Хулан МУСТА, А.Цэгмэд МУГЖ, Т.Бархүү МУСТА, А.Өнөржаргал /Өөскө/ МУСТА нар зурагт хуудсанд гарын үсэг зурж үзэгч олонтойгоо уулзсан юм.

## 2.5. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн чиглэлээр:

➢ Дархан-Уул аймаг нь Кинонд ээлтэй хот болох зорилтын хүрээнд орон нутгийн кино уран бүтээлчдийг дэмжих, мэдээллээр хангах ажлыг тогтмол зохион байгуулж байна.

Кино урлагийг дэмжих сангийн 2023 оны II дугаар ээлжийн сонгон шалгаруулалтыг зарыг Дарханы кино урлагийн салбарын төлөөлөлд мэдээлэл хүргэлээ.

- Аймгийн ЗДТГ-ын дэмжлэгтэйгээр Япон улсын TBS телевиз, Номадиа пикчерс ХХК-ийн хамтарсан "VIVANT" киноны зураг авалт 05 дугаар сарын12-17-ны өдрүүдэд Дархан хотод хийгдлээ. 420 гаруй иргэд 6 өдрийн турш зураг авалтад оролцсон.
- **"ЗҮРХЭНД ГЭРЭЛТЭНЭ" УСК** нээлтээ хийлээ. Өсвөр насны хүүхдүүдийг хүсэл мөрөөдлийнхөө төлөө зүтгэх, амьдралын зорилготой байх, зам тээврийн осол, гэмтлээс сэргийлье уриатай энэхүү уран бүтээлийг туурвижээ. Тус киноноос олсон орлогыг "Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх сан"-д хандивлах юм.
- Тэгш хүртээмжтэй нийгмийг цогцлоох, Монгол үндэстний ижилсэл ба ялгарлыг дэлхийд таниулах зорилготой **"ТРИО"** тус киноны нээлтэд аймгийн удирдлагууд, ЕБС-ын сургуулийн сурагчид, багш, эцэг эхийн төлөөлөл өргөнөөр оролцлоо.
- Залуучууд театр нь 9 удаагийн кино үзвэр үйлчилгээг дэмжин ажиллаж, нийт 44 удаагийн кино үзвэрийг 9333 хүүхдэд толилуулж, 5 киноны зураг авалтад дэмжлэг үзүүллээ.
- Соёл, урлагийг дэмжих сангаас 2023 онд санхүүжүүлэх төслийн сонгон шалгаруулалтад нийт 375 төсөл цахим системд бүртгэгдсэн байна. Үүнээс 90 төсөл, арга хэмжээг дараагийн шатны шалгаруулалтад дэмжихээр шийдвэрлэсний дотор Дархан-Уул аймгийн хоёр оролцогчийн **"Найрамдлын Дархан хот"** монгол зураг шинээр бүтээх төсөл, **"Сүбээдэй Баатар"** туульсын зохиолын ном хэвлэх төслүүд тус тус шалгарсан.
- Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл болох Кино, дуу дүрсний урлагийг орон нутагт хөгжүүлэх хүрээнд тус аймаг нь Соёлын сэргэлт-2023 аянаар "Кинонд ээлтэй Дархан" уриаг дэвшүүлэн 55 арга хэмжээг зохион байгуулж 6810 иргэнийг хамруулсан. "Соёлын бүтээлч үйлдвэрлэл II"-ийн хүрээнд аймгийн бүтээлч үйлдвэрлэгчдийг дэмжсэн сургалт, өдөрлөг зэрэг 14 арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажилласан байна.
- Кино, дуу дүрсний урлагийг дэмжих хүрээнд тус аймаг нь "Кинонд ээлтэй хот болох" зорилт дэвшүүлэн ажиллаж байна. "Соёлын сэргэлт-2023 аянаар "Кинонд ээлтэй хот" уриан дор зохион байгуулж 4 суманд нийт 55 арга хэмжээг зохион байгууллаа.
- 2023.09.23-ны өдөр кино үйлдвэрлэлийг дэмжих, соёлын бүтээлч үйлдвэрлэлээр дамжуулан соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр аймгийн Засаг дарга болон МҮКУЗөвлөлийн дарга нар хамтран ажиллах Санамж бичиг байгуулж "Кинонд ээлтэй Дархан" форумыг зохион байгуулсан.
- Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнд Кино орон зай, соёлын орчин байгуулах газрыг товлов. Киноны хөгжмүүдээр "Анир" поп оркестр бүрэн хэмжээний тоглолтыг тоглож Монгол кино нэгтгэл Кино үзэсгэлэнг дэглэв.
- "Кино нүүдэл" ОУ-ын сургалтад тус аймгаас 5 уран бүтээлч хамрагдлаа. "Соёлын түүчээ 330" төслийн хүрээнд Шарын гол, Орхон, Хонгор сумдад 6 киног 25 удаа-1426 үзэгч, бусад байгууллагын 19 киног 29 удаа-3266 үзэгч, Залуучууд театрт 12 киног 72 удаа-14653 үзэгчдэд тус тус үзүүлсэн. Трио, Fearbook, Бид нэг гэр бүл, Зүрхэнд гэрэлтэнэ, Вивант ЯОАК, Цор ганц, Орлон тоглогч зэрэг кино зураг авалт болон нээлтийн үйл ажиллагаануудыг дэмжин хамтран ажилласан.
- Кино соёлыг сурталчилах хүрээнд "Машинтай кино үзвэр"-ийг 2 удаа зохион байгууллаа. Дарханы түүхийг харуулсан "Хөгжилтэй аялал" анимэйшний I ангийг бүтээж олны хүртээл болгов. "Тогтвортой аялал жуулчлал" чадавхжуулах нээлттэй өдөрлөгт оролцож "Соёлын бүтээлч үйлдвэрлэл-Кино орон зай" төслийг иргэдэд танилцуулав.
- Тус аймагт хийгдсэн кино зураг авалт-31, уран бүтээлч-20, найруулагч-5, кино зураг авах боломжит газар-26, дурсгалт газар-39, кино урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага-3, кино театр -1 зэрэг судалгааг нэгтгэж МҮКУЗ-д хүргүүлэв.

- Аймгийн ЗДТГ-ын дэмжлэгтэйгээр Япон улсын TBS телевиз, Номадиа пикчерс ХХК-ийн хамтарсан "VIVANT" киноны зураг авалт 05 дугаар сарын 12-17-ны өдрүүдэд Дархан хотод хийгдлээ. 420 гаруй иргэд 6 өдрийн турш зураг авалтад оролцсон.
- Дүрслэх урлагийг дэмжих хүрээнд Соёлын яам, Монголын урчуудын эвлэлээс Улаанбаатар хотноо зохион байгуулсан "ART FAIR 2023" дүрслэх урлагийн үзэсгэлэн, худалдаанд Дарханы зураач урчуудын эвлэлийн зураач Ц.Намдаг, Н.Хишигбаатар, С.Мөнгөнзул, Г.Сугар нар нийт 11 бүтээлээр оролцлоо.
- Дархан суманд Зураач, МУСТА Н.Хишигбаатар нь ур хийц, өнгө донжоор ялгарахуйц монгол зургаар чимсэн MOZU брэндийг үүсгэн байгуулж ажиллаж байна. Энэхүү брэндийг олон нийтэд таниулах зорилгоор "МОНГОЛ АВДАР" үзэсгэлэн 9 дүгээр сарын 23-ны өдрөөс 30-ны өдрийг зохион байгуулсан.
- Утга зохиол, ном хэвлэлийг дэмжих хүрээнд СУДСангийн шалгаруулалтад тус аймгаас 2 уран бүтээлчийн "Найрамдлын Дархан хот" монгол зураг шинээр бүтээх төсөл, "Сүбээдэй Баатар" туульсийн зохиолын ном хэвлэх төслүүд шалгарч оролцсон. Оны шилдэг шүлэг шалгаруулах "Гал өд" яруу найргийн наадамд ОНТ-өөс 2.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж 300 ш ном хэвлүүлж байна.
- Хувцас загварыг дэмжих хүрээнд "Уран үйл 2023" төвийн бүсийн урлаачдын уралдаанд 6 аймгийн 80 гаруй уран бүтээлч оролцлоо. "Хайр хүндэтгэлийн урлал" үндэсний уран хатгамалчдын анхдугаар чуулганд 5 хүн оролцсон.
- "SUPER FASHION-2023" оны шилдэг, шинэ залуу модел, шилдэг фото моделийг шалгаруулах улсын уралдааныг зохион байгуулав. СБҮ-ийн үзэсгэлэнд "Цайны их зам" ХХК Англи, Австрали ковбой загварын ШИРМЭЛ эмээлээр оролцов. Дарханд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн холбоо ГҮТББ-аас арьс, ноос, сүлжмэл эдлэл зэрэг 5 төрлийн бүтээгдэхүүний СБҮ-ийг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллах хүсэлт тавьсныг хүлээн авч дэмжсэн.
- Шарын гол сумын Соёлын төв Эмэгтэйчүүдийн холбоотой хамтран "Үзэсгэлэнт" өдөрлөгийг сумын брэнд үйл ажиллагаа болгохоор зорин ажиллаж байна.
- Шарын гол сумын Соёлын төв нь МУСТА Дамчаабадгар багшаар "НАДА" буга нэртэй бүжиг дэглүүлэхээр гэрээ хийж бие даасан хөгжмийн зохиол, хувцас бүхий 18.0 сая төгрөгийн төсөл боловсруулсан. "Нада" нь Дархан хотын түүхт 60 жилийн ойгоор гаргасан хотын бэлгэдэл бугын нэр бөгөөд "Найрамдлын Дархан" нэрийн товчлол юм.
- Аймгийн Музейн сургалт сурталчилгааны сан хөмрөгт хадгалагдаж буй 9 хөлөгт тоглоомыг эргэлтэд оруулан хуулбар хувийг үйлдвэрлэж худалдаанд гаргав.
- 2023 оны 6 дугаар сарын 29-өөс 7 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулсан **"ТОГТВОРТОЙ НОГООН САНХҮҮЖИЛТ-ДАРХАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ФОРУМ"-**д Соёлын яам, Монголын Үндэсний Кино урлагийн зөвлөл Соёл, урлагийн газрын төлөөлөл оролцов.
- Зохиогч, зохиогчийн эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр, гэрээ байгуулахгүйгээр оюуны бүтээлийг ашиглах, зохиогчийн эрхийг зөрчих гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар сургалтад нийт 16 албан хаагч хамрагдлаа.

2. МУСГЗ, зохиолч, яруу найрагч, хөгжмийн зохиолч М.Хунллиузын "Босоо заяатай монгол" дууны хөшөөг аймгийн бүртгэл мэдээллийн санд бүртгэж хөшөөний эх загвар, ном, CD, цомог зэрэг оюуны бүтээлийг оюуны өмчид бүртгүүлэв. Хөшөөний загвар-1, Ном хэвлэл-10, CD цомог-5 ширхэг. Оюуны өмчид нийт 16 ширхэг бүтээлийг бүртгүүлэв.

## ГУРАВ. ДҮГНЭЛТ, ҮР ДҮН

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дунджаар **99.74%-**иар хэрэгжүүлэн ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайд болон Дархан-Уул аймгийн Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээнд тусгагдсан **6** зорилтын **49** арга хэмжээний хэрэгжилтийг дунджаар **98%-**иар хангуулж ажиллалаа.

2023 оны жилийн эцсийн байдлаар соёлын салбарт хэрэгжиж буй бодлогын баримт бичгийн хэрэгжилт дунджаар **98.3%-**иар хангагджээ.

## ДӨРӨВ: ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

2023 оны бүтэн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр дараах саналыг уламжилж байна. **Үүнд:**

1. Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд соёлын салбарт үүсч буй хүний нөөцийн хомсдолд анхаарал хандуулж, соёлын ажилтнуудыг гадаад, дотоодын их, дээд сургуулиад урт болон богино хугацаагаар сургах, мэргэшүүлэх тал дээр дэмжлэг үзүүлэх;
2. “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсаны дагуу гадаад харилцаа, хамтын ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх хүрээнд орон нутгийн соёлын байгууллагыг олон улсын хэмжээнд сурталчлан таниулах, харилцан туршлага судлуулах;
3. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 4-т заасны дагуу соёлын салбар, мэргэжлийн онцлогийг харгалзан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг Соёлын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран тогтоох эрх зүйн орчин бүрдсэн байх тул төрийн албаны шинэтгэлийн хүрээнд соёлын салбарт ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг нэн даруй батлуулах;
4. MNS 6981:2022 Соёлын төв, соёлын ордон. Орчин ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага стандарт 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан сумдын соёлын төвүүдэд стандартын A, F хавсралтад дурдагдсан барилга байгууламжийн хүчин чадлыг тооцох хэм хэмжээ, байгууллагын орон тоог стандартын жишигт нийцүүлэх зэрэг хүндрэлтэй асуудлууд үүсч байгаа тул шийдвэрлэх тал дээр анхаарал хандуулах;
5. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/195 дугаар тушаалаар баталсан “Төрийн өмчийн мэргэжлийн урлагийн байгууллагын үлгэрчилсэн дүрэм”-ийг шинэчлэн батлах;
6. Шилэн хяналтын цахим системийг соёлын салбараар нь салгаж, хөгжүүлэлтийг боловсронгуй болгох;
7. Эрсдэлийн үнэлгээ хийхэд ашиглах зөвлөмжийг боловсруулан ирүүлж байх;
8. Мэргэжлийн урлагийн байгууллагын соёлын ажил үйлчилгээг шалгах хяналтын хуудас, мэргэжлийн урлагийн байгууллагын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтийг тус тус шинээр боловсруулан батлах;
9. Соёлын байгууллагуудын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан нэг загварт оруулах;
10. “Гар урлал болон урлагийн зориулалттай зүйлс. Музейн үйл ажиллагаанд тавих шаардлага” MNS 5634:2006 стандартын бүтцэд дурдсан зарим албан тушаалын нэршлийг соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалттай уялдуулах.
11. Дижитал шилжилттэй уялдуулан гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн цахим систем http://plan.igovernment.mn-ийн **Зохион байгуулалтын нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний** биелэлтийг тайлагнаж, үнэлгээ хийж баталгаажуулсан даруйд

**Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний** биелэлт рүү мэдээлэл нь автоматаар татагдаж байхаар тохиргоог хийлгэх;

12. Монгол Улсын Засгийн гишүүн, Соёлын сайд болон Дархан-Уул аймгийн Засаг дарга нарын тай байгуулах дараа оны гэрээг орон нутгийн төсөв хэлэлцэн батлахаас өмнө санал авч боловсруулах;

**ТАЙЛАН БИЧСЭН:**

**Төсвийн шууд захирагч:**

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН

СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА....................................../Х.СОЁЛ-ЭРДЭНЭ/

(албан тушаал) (гарын үсэг) (гарын үсгийн тайлал)

(тэмдэг) 2023.12.05

(огноо)